



ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГА  
ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙГ УСТГАХ  
ОЛОН УЛСЫН ХӨТӨЛБӨР  
(ОУХБ/АЙПЕК)

**Зарим хот, хилийн боомтын  
үйлчилгээний салбарт  
ажиллаж буй хүүхэд,  
залуучуудын хөдөлмөр,  
бэлгийн мөлжлөгт өртөх  
эрсдэл, үйлчилгээний  
салбарын гадна бие үнэлж буй  
охид, эмэгтэйчүүдийн байдлын  
судалгаа**

Хүйсийн тэгш эрхийн төв  
МУИС-ийн Хүн ам зүй, сургалт судалгааны төв

2005 он

## Агуулга

Хүснэгтийн жагсаалт	3
Зургийн жагсаалт	5
Хураангуй	7
<b>Бүлэг 1. Оршил</b>	
1.1    Үндэслэл	17
1.2    Судалгааны зорилтууд	18
<b>Бүлэг 2. Судалгааны арга зүй, зохион байгуулалт</b>	
2.1    Судалгааны түүвэрлэлт	19
2.2    Асуулга	20
2.3    Туршилтын судалгаа	20
2.4    Сургалт	20
2.5    Мэдээлэл цуглуулалт, боловсруулалт	20
2.6    Судалгааны хамрагдалт	20
2.7    Судалгааны явцад тохиолдсон зарим бэрхшээлүүд	21
<b>Бүлэг 3. Үйлчилгээний салбарт ажиллаж буй хүүхэд залуучуудын тоог тодорхойлох</b>	
3.1    Арга зүй, аргачлал	22
3.2    Судалгааны хамрагдалт	23
<b>Бүлэг 4. Үйлчилгээний газар ажиллагчдын асуудлууд</b>	
4.1    Үйлчилгээний газруудын бүртгэл	26
4.2    Үйлчилгээний газар ажиллагчдын ерөнхий шинж байдал	27
4.3    Ажил эрхлэлт, ажилд авах үйл явц	30
4.4    Ажлын болон эрүүл мэндийн нөхцөл байдал	35
4.5    Үйлчлүүлэгчдийн шинж байдал	39
4.6    ДОХ, БЗХӨ-ний талаарх мэдлэг, хандлага	40
4.7    Ирээдүйн талаар	40
4.8    Үйлчилгээний газар ажиллагчид хүн худалдаалах асуудлын талаар	41
<b>Бүлэг 5. Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн асуудлууд</b>	
5.1    Судалгаанд хамрагдагчдын ерөнхий шинж байдал	44
5.2    Амьдралын нөхцөл, гэр бүл, хүүхэд нас	45
5.3    Биеэ үнэлэх байдал	49
5.4    Зуучлагчид ба үйлчлүүлэгчдийн шинж байдал	55
5.5    Биеэ үнэлэгчдийн эрүүл мэнд ба ДОХ/БЗХӨ-ний талаарх мэдлэг, хандлага	57
5.6    Биеэ үнэлэгчдэд тохиолдож буй хүндрэл, бэрхшээлүүд	60
5.7    Биеэ үнэлэгчид ирээдүйнхээ талаар	61

5.8	Биеэ үнэлэгчдийн хүн худалдах гэмт хэргийн талаарх ойлголт, хандлага	63
<b>Бүлэг 6.</b>	<b>Ажил олгогчийн асуудлууд</b>	
6.1	Ажил олгогчдын шинж байдал	66
6.2	Ажиллагчдыг ажилд авах үйл явц, ажиллуулах талаар	67
6.3	Ажил олгогчид үйлчлүүлэгчдийн талаар	69
<b>Бүлэг 7.</b>	<b>Дүгнэлт, зөвлөмж</b>	<b>71</b>
<b>Хавсралт.</b>	<b>Асуулгын хуудас</b>	<b>74</b>

## Хүснэгтийн жагсаалт

<b>Хүснэгт 2.1</b>	Судалгааны түүвэрлэлт	19
<b>Хүснэгт 2.2</b>	Үйлчилгээний газрын түүвэрлэлт	19
<b>Хүснэгт 2.3</b>	Судалгааны хамрагдалт	20
<b>Хүснэгт 3.1</b>	Үйлчилгээний газрын тоо, төрлөөр аймаг, дүүргээр	22
<b>Хүснэгт 3.2</b>	25-аас доош насны ажиллагсад, үйлчилгээний байгууллагын төрлөөр	22
<b>Хүснэгт 3.3</b>	Үйлчилгээний газар ажиллагчдын тархалт, сонгогдсон хот, аймгуудаар, хүйсээр	24
<b>Хүснэгт 3.4</b>	Үйлчилгээний газар ажиллагчдын тархалт, сонгогдсон хот, аймгуудаар, үйлчилгээний газрын төрлөөр	25
<b>Хүснэгт 4.1</b>	Үйлчилгээний газруудын тоо бүртгэл, үйлчилгээний газруудын нэр төрөл, байршил, тоо мэдээллийн эх үүсвэрээр	26
<b>Хүснэгт 4.2</b>	Сургууль завсардсан хүмүүсийн хувь, шалтгаан, сургууль завсардсан анги, курсаар	29
<b>Хүснэгт 4.3</b>	Үйлчилгээний газар ажиллагчдын хувь, одоогийн эрхэлж буй ажил, хүйсээр	31
<b>Хүснэгт 4.4</b>	Үйлчилгээний газар ажиллагчдын хувийн жин, сарын дундаж орлогоор, хүйсээр, ажиллаж буй газар болон хийж буй ажлын төрлөөр	32
<b>Хүснэгт 4.5</b>	Үйлчилгээний салбарт ажиллагчдын хувийн жин эрхэлж буй ажлаар, хүйсээр, сарын дундаж орлогоор	33
<b>Хүснэгт 4.6</b>	Охид, эмэгтэйчүүдийг олж өгөх санал авч байсан эсэх хариулагчдын нас, хүйс, байршил, үйлчилгээний газрын төрлөөр	42
<b>Хүснэгт 5.1</b>	Биеэ үнэлэх болсон анхны болон одоогийн шалтгаан, насны бүлгээр	
<b>Хүснэгт 5.2</b>	Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн орлогын зарцуулалт, насны бүлгээр	54
<b>Хүснэгт 5.3</b>	Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн зуучлагчдын	56

үзүүлж буй туслалцаа, насны бүлгээр

<b>Хүснэгт 5.4</b>	Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн үйлчлүүлэгчдийн зүгээс үзүүлдэг дарамт, шахалт, насны бүлгээр	60
<b>Хүснэгт 5.5</b>	Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн зуучлагчдын зүгээс үзүүлдэг дарамт, шахалт, насны бүлгээр	61

<b>Зураг 4.1</b>	Судалгаанд хамрагдсан үйлчилгээний газар ажиллагчид, нас, хүйсээр	27
<b>Зураг 4.2</b>	Сургуульд суралцаж байгаагүй болон сургууль завсардсан хүмүүсийн хувь, шалтгаанаар, хүйсээр	28
<b>Зураг 4.3</b>	Үйлчилгээний салбарт ажиллагчдын хувь, ажиллаж буй газрын төрлөөр, хүйсээр	29
<b>Зураг 4.4</b>	Ажлаа сольсон үйлчилгээний газар ажиллагчдын хувь, шалтгаанаар	30
<b>Зураг 4.5</b>	Ажиллагчид болон ажил олгогчын хувь, гэрээнд тохирсон хамгийн чухал зүйлээр	31
<b>Зураг 4.6</b>	Үйлчилгээний газар ажиллагчдын хувийн жин, сарын дундаж орлогоор	32
<b>Зураг 4.7 а</b>	Үйлчилгээний газар ажиллагчдын хувийн жин, тухайн салбарт ажиллахад таалагддаг зүйлээр	34
<b>Зураг 4.7 б</b>	Үйлчилгээний газар ажиллагчдын хувийн жин, тухайн салбарт ажиллахад таалагддаггүй зүйлээр	34
<b>Зураг 4.8</b>	Үйлчилгээний газар ажиллагчдын хувь, шөнө хийдэг ажлын төрлөөр	35
<b>Зураг 4.9</b>	Үйлчилгээний газар ажиллагчдын хувь, ажлын нөхцлөө муу/маш муу гэж үнэлсэн шалтгаанаар	35
<b>Зураг 4.10</b>	Үйлчилгээний газар ажиллагчдын хувь, үйлчлүүлэгчдийн зүгээс үзүүлж буй дарамт, шахалтаар	36
<b>Зураг 4.11</b>	Үйлчилгээний газар ажиллагчдын хувь үйлчлүүлэгчдийн зүгээс тавьдаг саналаар	37
<b>Зураг 4.12</b>	Үйлчлүүлэгчдийн зүгээс секс үйлчилгээ үзүүлэх санал авч байсан хариулагчдын хувь байршлаар	37
<b>Зураг 4.13</b>	Үйлчилгээний газар ажиллагчдын хувь ажил олгогчийн зүгээс үзүүлж буй дарамт, шахалтаар	38
<b>Зураг 4.14</b>	Үйлчлүүлэгчдийн хувь, улсаар	39
<b>Зураг 4.15</b>	Үйлчилгээний газар ажиллагчдын хувийн жин, цаашдын зорилгоор	41
<b>Зураг 5.1</b>	Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн насны бүтэц	44

<b>Зураг 5.2</b>	Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн хамт амьдардаг хүмүүс	46
<b>Зураг 5.3</b>	Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн гэр бүлийнхэнтэйгээ хамт амьдардаг эсэх, эцэг эхийн гэрлэлтийн байдлаар	47
<b>Зураг 5.4</b>	Анх бэлгийн харьцаанд орсон нөхцөл	49
<b>Зураг 5.5</b>	Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн биеэ үнэлж буй хугацаа	50
<b>Зураг 5.6</b>	Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн биеэ үнэлдэг газар	52
<b>Зураг 5.7</b>	Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн долоо хоногт ажилладаг дундаж өдөр	53
<b>Зураг 5.8</b>	Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн өдөрт олдог орлогын дундаж хэмжээ, төгрөгөөр	53
<b>Зураг 5.9</b>	Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн өдөрт үйлчилдэг үйлчлүүлэгчдийн дундаж тоо	56
<b>Зураг 5.10</b>	Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн БЗХӨ тусаж байсан эсэх	58
<b>Зураг 5.11</b>	Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн гадаадад ажиллах талаарх хүсэл бодол	62
<b>Зураг 5.12</b>	Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн ирээдүйн хүсэл эрмэлзэл	62
<b>Зураг 5.13</b>	Биеэ үнэлэгчдийн худалдаалагдсан охид, эмэгтэйчүүдийн тухай мэддэг эсэх, мэдсэн эх үүсвэрээр	63
<b>Зураг 6.1</b>	Үйлчилгээний газруудын хувийн жин, үзүүлж буй үйлчилгээний төрлөөр	67
<b>Зураг 6.2</b>	Ажил олгогчид ажиллагчдаа ажилд авах үед тавьдаг шаардлага	68
<b>Зураг 6.3а</b>	Ажил олгогчдын хувь, үйлчилгээний газар охид эмэгтэйчүүдийг ажиллуулах давуу талаар	69
<b>Зураг 6.3б</b>	Ажил олгогчдын хувь, үйлчилгээний газар охид эмэгтэйчүүдийг ажиллуулах сул талаар	69

## **Хураангуй**

### **Үнэлгээнүүд**

- Судалгаанд хамрагдсан аймгууд болон Улаанбаатар хот дахь үйлчилгээний байгууллагуудад 25-аас доош насны нийт 34341 хүн ажиллаж байгаагаас ихэнх нь буюу 81.2 хувь нь эмэгтэйчүүд байна.
- Үйлчилгээний салбарт ажиллаж буй хүмүүсийн тархалт нь байршлаараа ялгарч байгаа бөгөөд тухайлбал Улаанбаатар хотод 98 хувь нь төвлөрсөн байна. Мөн Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх, Сүхбаатар дүүргүүдэд үйлчилгээний байгууллагын төвлөрөлт их байна. Нөгөө талаас Налайх дүүрэгт үйлчилгээний байгууллага сийрэг байгааг тооноос харж болно.
- Насанд хүрээгүй хүүхэд хөдөлмөр эрхэлж байгаа тухайд үйлчилгээний газар ажиллаж буй 34341 хүний 178 нь 18-аас доош насны хүүхэд байв.
- Ойролцоогоор гурван хариулагч тутмын нэгд нь үйлчлүүлэгчийн зүгээс бэлгийн үйлчилгээ үзүүлэх санал тавьж байснаас байгууллагынх нь үйлчилгээний салбарын төрлөөр ангилбал нийт зочид буудалд ажиллагсдын – 44 хувьд нь, саун массажны газар ажиллагсдын – 60 хувьд нь, бар/шөнийн клубт – 31.2 хувьд нь дээрх саналыг тавьж байжээ.

### **Бие үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн асуудлууд**

- Судалгаанд Улаанбаатар хотын 60, Дорнод аймгийн 19, Дархан-Уул аймгийн 10, Дорноговь аймгийн Замын-Үүд хотын 2, нийт 91 биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүд хамрагдсан. Тэдгээрийн дундаж нас 19.4. Хамгийн залуу нь 14 настай охин, хамгийн ахмад нь 25 настай эмэгтэй байлаа.
- Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн 17.6 хувь нь одоогоор суралцагчид, 56.0 хувь нь сургуульд суралцаагүй байгаа, 26.4 хувь нь ямар нэг шатны сургууль төгсөгчид байлаа.
- Сургуульд суралцдаггүй 51 охид байгаагийн 96.1 хувь нь ямар нэг шатны сургуульд суралцаж байгаад сургууль завсардсан хүүхдүүд байна. Сургууль завсардсан нийт охидын 41.2 хувь нь санхүүгийн бэрхшээлээс, 13.7 хувь нь эцэг, эх явуулаагүйгээс, 5.9 хувь нь ажил хийх гээд сургуулиас гарчээ.
- Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн 35.2 хувь нь урьд өмнө ямар нэгэн ажил эрхэлж байсан ба тэдний бараг 94 орчим хувь нь үйлчилгээний салбарт ажиллаж байсан бөгөөд тэдний 15.6 хувь нь 13-15 насандаа, 43.8 хувь нь 16-18 настайдаа анх ажиллаж эхэлжээ.
- Судалгаанд оролцогчдын 37.4 хувь нь одоогоор гэр бүлийнхэнтэйгээ цуг, 62.6 хувь нь ганцаараа болон гэр бүлийн гишүүн бус хэн нэгэн хүнтэй амьдардаг ажээ.
- Судалгаанд хамрагдсан биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн 39.6 хувь нь өөрийн сууцанд, бусад нь түрээсийн (34.1 хувь), зуучлагч үнэгүй байлгадаг (4.4 хувь), хамаатан, найз нөхөд үнэгүй байлгадаг (16.5 хувь), халамжийн төвд (5.5 хувь) амьдарч байгаа гэж хариулжээ. Сууцны төрлийн хувьд гэрт 44.0 хувь, хувийн байшинд 16.5 хувь, тохилог сууцанд 20.9 хувь, зочид буудалд 6.6 хувь, дотуур байранд 3.3 хувь, халамжийн төвийн байранд 7.7 хувь нь тус тус амьдардаг байна.



- Эцэг эх нь салсан, дахин гэрлэсэн охид, эмэгтэйчүүдийн хувьд гэр бүлийнхэнтэйгээ хамт амьдрахгүй байх тохиолдол их байна. Мөн эцэг эхийнх нь хэн нэг нь дахин гэрлэсэн тохиолдолд ч хамт амьдрах явдал бага байна.
- Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн анхны бэлгийн харьцаанд орсон дундаж нас 16.2. Тэдний 1.1 хувь нь 9 настайдаа, аравны нэг нь 12-13, дөрөвний нэг нь 14-15, гуравны нэг нь 16-17, тавны нэг нь 18-19, үлдсэн 8.8 хувь нь 20-23 настайдаа анх бэлгийн харьцаанд оржээ. Анх бэлгийн харьцаанд ороходоо 36.3 хувь нь найз залуутайгаа, 22.0 хувь нь санамсаргүй тохиолдлоор орсон байна. Харин зарим охид, эмэгтэйчүүдийн хувьд хүчиндүүлж (19.8 хувь), бие үнэлж (4.4) анхны бэлгийн харьцаанд орсон байлаа.
- Нийт охид, эмэгтэйчүүдийн 40.7 хувь нь хүчиндүүлж байжээ. Эдгээр охид, эмэгтэйчүүдийг хүчиндсэн хүмүүс нь үл таних хүн (59.5 хувь), найз (13.5 хувь), хамаатан (10.8 хувь), хойд эцэг (8.1 хувь), найз залуу (5.4 хувь) болон үйлчлүүлэгчид (2.7 хувь) байв.
- Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүд дунджаар 1.6 жил биеэ үнэлж байгаа ажээ. Тэдний 23.1 хувь нь нэгээс доош жилдээ, 8.8 хувь нь 5 ба түүнээс дээш жил биеэ үнэлж байна. Нийт охид, эмэгтэйчүүдийн хамгийн бага нь 12, хамгийн ахмад нь 25 настайдаа, дунджаар 17.8 настайдаа биеэ үнэлж эхэлсэн байна.
- Охид, эмэгтэйчүүдийн хувьд бие үнэлэх болсон анхны болон одоогийн шалтгаанд мөнгө олох явдал голлож байна. Мөн үүний дараагаар гэр бүлээ тэжээх, найз нөхдөө дагаж, хүчиндүүлснээс ийм замд орсон буюу ийм замаар явахаас өөр аргагүй болсон байна.
- Судалгаанд хамрагдсан биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн тэн хагас нь найз нөхөд нь энэ ажилд анх оруулж байжээ. Мөн тэдний гуравны нэг нь өөрөө энэ замд орсон бол 14.1 хувь нь танил хүн, зуучлагч, 6 гаруй хувь нь бусад буюу хүчиндүүлсэн, хадам эцэг нь энэ ажилд оруулсан зэрэг тайлбарыг өгсөн байна.
- Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн бараг тал хувь нь гудамжинд зогсож биеэ үнэлдэг, гуравны нэг орчим нь зочид буудлаар явж биеэ үнэлдэг байна. Мөн шөнийн цэнгээний газар болон дуудлагаар явж биеэ үнэлдэг охид, эмэгтэйчүүд цөөнгүй байгаа нь харагдлаа. Анхны болон одоогийн биеэ үнэлж буй газруудыг хооронд нь харьцуулахад зочид буудлаар явж биеэ үнэлэгчид бараг 7 хувиар, саун болон гудамжинд биеэ үнэлэгчид тус бүр 1.1 хувиар нэмэгдсэн байдал ажиглагдлаа. Бусад тохиолдлын биеэ үнэлэгчдийн хувь буурсан байна. Биеэ үнэлдэг газраа солих болсон гол шалтгаанд илүү мөнгө олох (42.9 хувь) явдал зонхилж байна.
- Судалгаанд оролцогчид долоо хоногт дунджаар 4.3 өдөр, өдөрт дунджаар 7.5 цаг ажилладаг байна.

- Судалгаанд хамрагдсан охид, эмэгтэйчүүд биеэ үнэлснээр өдөрт дунджаар 20000 орчим төгрөг олдог байна. Насны бүлгээр авч үзвэл, 14-15 настай охидын дундаж орлого 25000 орчим, 16-18 насны охидынх 21000 гаруй, 19-21 насны охидынх 20000 гаруй, 22-25 насны эмэгтэйчүүдийн өдрийн дундаж орлого 16000 гаруй төгрөг байна.
- Зочид буудалд биеэ үнэлдэг охид, эмэгтэйчүүд бусад газруудаар биеэ үнэлэгчдээс 2.5 дахин илүү орлоготой байдаг ажээ.
- Нийт охид, эмэгтэйчүүдийн 94.5 хувь нь бэлэн мөнгөөр, үлдсэн 5.5 хувь нь мөнгөн бус хэлбэрээр орлогоо олж авдаг байна.
- Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн дийлэнх нь олсон орлогоо өөрт хэрэгтэй эд зүйлс (76.9 хувь) болон хоол хүнс (63.7 хувь) худалдан авахад хэрэглэдэг байна. Мөн тодорхой хэсгийг гоо сайхан (31.9 хувь), гэр бүлийнхэн (30.8 хувь), эрүүл мэнд (23.1 хувь), байрны түрээс (22.0 хувь), зуучлагчийн татвар (20.9 хувь), өр зээлэндээ (14.3 хувь) зарцуулдаг бөгөөд өөрийнхөө төлөө буюу сурч боловсрох (4.4 хувь), ирээдүйдээ зориулж хадгаламж (4.4 хувь) бий болгоход өчүүхэн хэсгийг зарцуулж байгаа дүн гарчээ.
- Судалгаанд оролцогчдын 63.7 хувь нь биеэ үнэлсэн орлогоо үйлчлүүлэгчээс шууд өөрөө авдаг бол үлдсэн эмэгтэйчүүдийн хувьд зуучлагч нь авдаг байна.
- Судалгаанд оролцогчдын 62.6 хувь нь зуучлагчтай ажээ. 14-15 насны бүх охидууд, 16-18 насны охидын 53.6 хувь, 19-21 насныхны 66.7 хувь, 22-25 настай эмэгтэйчүүдийн тэн хагас нь зуучлагчаар дамжуулж үйлчлүүлэгч олж, биеэ үнэлдэг байна.
- Хүйсийн хувьд зуучлагчдын 60 орчим хувь нь эмэгтэйчүүд байна. Зуучлагчдын 40.4 хувь нь 30 ба түүнээс дээш настай, 29.8 хувь нь 25-аас бага, үлдсэн хэсэг нь 25-29 настай байна.
- Судалгаанд оролцсон биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн хувьд өдөрт дунджаар 3.4 үйлчлүүлэгчтэй байдаг. Тэдний 35.1 хувь нь 3-4, 30.8 хувь нь 1-2, үлдсэн 24.2 хувь нь 5 ба түүнээс дээш хүнд үйлчилдэг байна. Үйлчлүүлэгчдийн дундаж нас 33.3 байна.
- Судалгаанд хамрагдсан биеэ үнэлэгчдийн 62.6 хувийг гадаадын үйлчлүүлэгчид авч байжээ. Давхардсан тоогоор 97.8 хувь нь монголчууд, 60 орчим хувь нь хятадууд, бараг 30 хувь нь солонгосчууд, 26.1 хувь нь оросууд байна. Мөн япон (7.6 хувь), герман (7.6 хувь), америкчуудын (10.9 хувь) хувьд биеэ үнэлэгчдээр үйлчлүүлдэг байна.
- Үйлчлүүлэгчид биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдтэй зөвхөн бэлгийн харьцаанд орохоос гадна болзоонд урих, Монголд өөр ажил эрхлэх, гадаадад ажиллах санал тавьдаг байна. Мөн үйлчлүүлэгчдийн хувьд эдгээр охид, эмэгтэйчүүдэд хайртай болох, гэрлэх санал тавих, санхүүгийн туслалцаа үзүүлэх зэрэг тохиолдол ч цөөнгүй байдаг ажээ.

- Биеэ үнэлж байхдаа эрүүл мэндийн хүндрэл, бэрхшээлд орж байсан гэж судалгаанд оролцогчдын 47.3 хувь нь хариулжээ. Эрүүл мэндийн хүндрэл гарсан тохиолдолд тэдний 39.5 хувь нь эмийн сангаас эм, тариа авч хэрэглэсэн, 41.9 хувь нь эмч, эмнэлэгт очсон, үлдсэн хэсэг нь найз нөхөд, хамаатан садан, танилдаа хандсан байна.
- Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдэд тохиолдож байсан эрүүл мэндийн хүндрэл, бэрхшээлүүдэд БЗХӨ, бөөр, шээсний замын өвчин зонхилж байна.
- Судалгаанд хамрагдагчдын 22.0 хувь нь үр хөндүүлж байжээ. Үр хөндөлтийн давтамж дунджаар 2 байгаа бөгөөд тэдний 55.0 хувь нь нэг, 25.0 хувь нь гурав, 15.0 хувь нь хоёр, үлдсэн 5.0 хувь нь таван удаа үр хөндүүлсэн байна. Үр хөндүүлэгчид бүгд 16 ба түүнээс дээш настай охид, эмэгтэйчүүд байна.
- Биеэ үнэлэгчдийн бэлгэвч хэрэглэх явдал хангалтгүй, ялангуяа 14-15 настай охидын дийлэнх хэсэг нь хэзээ ч бэлгэвч хэрэглэдэггүй байна.
- Судалгаанд оролцогчдын 41.8 хувь нь БЗХӨ тусаж байжээ. 14-15 насны бүлгийн охидын хувьд БЗХӨ тусаж байсан тохиолдол бусад насны бүлгийнхэнтэй харьцуулахад өндөр байна. БЗХӨ тусаж байсан охид, эмэгтэйчүүдийн 84.2 хувь нь эмчилгээ хийлгэсэн байна.
- Судалгаанд хамрагдагчдын 93.4 хувь нь БЗХӨ-ний талаар сонссон байгаа ба тэдний 97.2 хувь нь бэлгийн хавьталд ороход энэхүү өвчний халдвар авдаг гэсэн зөв ойлголттой байна. БЗХӨ-ний талаарх мэдээллийг зурагт, сонин сэтгүүл, найз нөхөд хамаатан, эрүүл мэндийн ажилтнуудаас мэдэж авах тохиолдол хамгийн өндөр байна.
- БЗХӨ өвчин туссан үед илрэх шинж тэмдгийн талаар 74.1 хувь нь ямар шинж тэмдэг илэрдгийг мэднэ гэж хариулжээ. Мөн нийт охид, эмэгтэйчүүдийн 94.1 хувь нь БЗХӨ-нөөс сэргийлж болох бөгөөд бэлгэвч хэрэглэснээр найдвартай хамгаалах болно гэж үзэж байна.
- Судалгаанд оролцогч охид, эмэгтэйчүүдийн 93.4 хувь нь ДОХ-ын талаар сонссон бөгөөд энэ талын мэдээллийг авдаг гол эх үүсвэр нь зурагт, сонин сэтгүүл, эрүүл мэндийн ажилтнууд гэж хариулжээ. Нийт охид, эмэгтэйчүүдийн 85.9 хувь нь ДОХ үүсгэгчээс сэргийлэх боломжтой гэж бодож байгаа ба тэдний 91.8 хувь нь бэлгэвч хэрэглэснээр, 6.8 хувь нь бэлгийн харьцааг тэвчснээр, 1.4 хувь нь зөвхөн нэг бэлгийн хавьтагчтай байснаар хамгаалж чадна гэж үзэж байна.
- Судалгаанд хамрагдсан биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн гуравны нэг нь хэзээ ч ДОХ/БЗХӨ-ний шинжилгээнд хамрагдаж байгаагүй, 41.8 хувь нь 1-3 сарын өмнө, 13.2 хувь нь 3-6 сарын өмнө, 7.7 хувь нь 6-12 сарын өмнө, үлдсэн хэсэг нь нэг ба түүнээс дээш жилийн өмнө шинжилгээ хийлгэж байжээ.
- Зуучлагчдын хувьд үйлчлүүлэгчтэй харьцуулахад дарамт үзүүлэх байдал бага байдаг аж. Зуучлагч нь дарамт шахалт үзүүлдэггүй гэж 42.1

хувь нь хариулсан байхад үйлчлүүлэгч дарамт үзүүлдэггүй гэж 11-хэн хувь нь үзэж байна.

- Бүх насны охидын хувьд үйлчлүүлэгчдийн зүгээс хэл амаар доромжлох явдал илүү түгээмэл байдаг ажээ. Үүний дараагаар охид, эмэгтэйчүүдийг хүчирхийлэх явдал орж байна.
- Зуучлагчдын зүгээс охидыг хэл амаар доромжлох, айлган сүрдүүлэх, багахан хэмжээний ажлын хөлс өгөх, өрөө төлөхийг шаардах зэрэг дарамт шахалтыг байнга үзүүлдэг ажээ.
- Нийт судалгаанд оролцсон охид, эмэгтэйчүүдийн гуравны нэг нь цаашид биеэ үнэлэх ажлаа үргэлжлүүлэн хийх бодолтой байгаа гэнэ. Гэхдээ ийнхүү үргэлжлүүлэх бодолтой байгаа эмэгтэйчүүдийн 60.7 хувь нь хэр удаан үргэлжлүүлэн ажиллахаа сайн тодорхой хэлж мэдэхгүй байгаа ажээ.
- Охид, эмэгтэйчүүдийн олонх нь гадаадад ажиллах хүсэлтэй бөгөөд ийм санал тавибал дуртайяа хүлээн авах ажээ. 14-15 насны охидын хувьд гадаадад явж ажиллах хүсэл эрмэлзэл бусад насны бүлгийнхэнтэй харьцуулахад харьцангуй өндөр байна. Гадаадад ажиллах сонирхолтой, санал тавибал хүлээн авна гэж хариулсан охид, эмэгтэйчүүдээс 64.2 хувь нь ямар ч хамаагүй ажил хийнэ гэсэн хариултыг өгчээ.
- Гадаад явах сонирхолтой охид, эмэгтэйчүүдийн 62.3 хувь нь Азийн аль нэг улс оронд, гуравны нэг нь Европын орнууд руу, үлдэх 7.5 хувь нь аль ч улс руу хамаагүй явна гэсэн бодолтой байна.
- Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн дийлэнх нь сурч боловсрон, мэргэжлийн ур чадвар эзэмших, өөрийн хүссэн ажлаа эрхлэх, өөрийн гэсэн амьдрал ахуйтай болж, үр хүүхэдтэй, сайхан амьдрах зэрэг өөдрөг хүсэл эрмэлзэлтэй байгаа ажээ.
- Судалгаанд оролцсон охид, эмэгтэйчүүдийн 12.1 хувь өөр ажил төрөл олж хийх, биеэ үнэлэхээ болих, одоогийн нөхцөл байдлаа өөрчлөх зорилгоор ямар нэгэн төрийн бус байгууллагад хандаж байжээ.
- Судалгаанд хамрагдсан нийт биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн 65.9 хувь нь хүн худалдах гэмт хэргийн талаар урьд өмнө нь сонссон ажээ. Мөн нийт охид, эмэгтэйчүүдийн 56.0 хувь нь биеэ үнэлэгчид бол ийм гэмт хэрэгт өртөх эрсдэл ихтэй хүмүүс гэж үзэж байна.
- Нийт судалгаанд оролцогчдын 27.5 хувь нь худалдаалагдсан охид, эмэгтэйчүүдийн тухай мэддэг бөгөөд энэ талаар бусад биеэ үнэлэгчдээс болон зуучлагчаасаа мэдсэн, мөн тухайн худалдаалагдсан эмэгтэй өөрийнх нь найз нөхөд байсан тухай ярьж байсан.
- Худалдаалагдсан охид, эмэгтэйчүүдийн талаар мэддэг охидын 24.0 хувь нь сүүлийн нэг жилийн хугацаанд 2-5 охид зарагдсан тухай ярьж байлаа.

- Судалгаанд оролцсон нийт охид, эмэгтэйчүүдийн 16.5 хувь нь буюу 15 охид, эмэгтэйчүүд өөрсдөө хүн худалдах гэмт хэрэгт өртөх шахжээ. Тэдний арван охидыг монгол зуучлагч, гурвыг нь ойр дотны найз нөхөд, хамаатан, нэг, нэг охидыг гадаадын зуучлагч болон үйлчлүүлэгч нь зарах талаар санал тавьсан байна.
- Судалгаанд оролцсон нийт охидын 67.0 хувь нь үйлчлүүлэгчдийн зүгээс охид, эмэгтэйчүүд олж өгөх санал үйлчлүүлэгчээс ирж байсан гэж хариулжээ.
- Биеэ үнэлэгчдийн 60.4 хувь нь зочид буудал болон бусад үйлчилгээний газруудад насанд хүрээгүй охид/хөвгүүдийг хүмүүс авч орох ийм тохиолдол ажигласан байна.

## Үйлчилгээний газар ажиллагчдын асуудлууд

- Судалгаанд хамрагдсан үйлчилгээний газар ажиллагчдын дийлэнх нь 20 орчим насны залуучууд байгаа бөгөөд судалгаанд хамрагдагчдын дундаж нас 21 байв.
- Судалгаанд хамрагдсан залуучуудын талаас илүү хувь нь буюу 40.9 хувь нь сургуулиа төгссөн, 32.2 хувь нь одоо сургуульд сурч байгаа, үлдсэн хувь нь одоогоор сургуульд сураагүй гэсэн хариулт өгчээ.
- Сургууль завсардсан хүүхэд, залуучуудын 60.3 хувь нь ерөнхий боловсролын сургууль, 39.7 хувь нь их, дээд сургуулиас завсарджээ.
- Сургууль завсардах болон сургуульд огт сураагүй шалтгаанд дийлэнх нь санхүүгийн бэрхшээлийг нэрлэж байв. Эмэгтэйчүүдийн хувьд энэ бэрхшээл илүү тохиолдож байсан ба харин эрэгтэйчүүдийн хувьд ажил хийх зорилгоор сургуульд суралцаагүй болон завсардсан хувь харьцангуй өндөр байлаа
- Судалгаанд хамрагдсан үйлчилгээний газар ажиллагчдын 38 хувь нь тухайн газраа шилжин ирээд 5-аас багагүй жилийн хугацаанд амьдарч байгаа бөгөөд эдгээрийн тал нь (57.6 хувь) тухайн газраа бүртгүүлээгүй байв. Бүртгэл хийлгээгүй хамгийн түгээмэл шалтгаанд шилжигчид, түр амьдарч байгаа учраас гэсэн шалтгааныг нэрлэсэн байна.
- Судалгаанд хамрагдсан үйлчилгээний газар ажиллагчдын 67 хувь буюу 23015 ажиллагч баар, диско клубт, 29.2 хувь буюу 10013 ажиллагч зочид буудалд, 3.8 хувь буюу 1316 ажиллагч саун, массажны газар ажиллаж байв.
- Үйлчилгээний газар ажиллагчдын тухайн салбарт ажиллаж буй дундаж хугацаа 2 жил байна. Ажилласан хугацааг ажлын төрлөөр гаргасан вариаци бараг байхгүй байна.
- Үйлчилгээний газар ажиллагчдын 31.0 хувь нь компанийн зар сурталчилгааны дагуу ажилд орсон гэжээ. Мөн өмнө нь ажиллаж байсан найз нөхөд зуучилсан тохиолдол цөөнгүй байлаа.
- Нийт судалгаанд хамрагдагчдын 50.8 хувь нь ресторан/баар/шөнийн клубт зөөгч/бармен, 9.5 хувь нь буудалд үйлчлэгч, цэвэрлэгч, 5.4 хувь нь буудлын жижүүр, 10.3 хувь нь бааранд хамгаалагч, 12.0 хувь нь массажист, 9.1 хувь нь бүжигчин/дуучин/ширээний үйлчлэгч, 2.9 хувь нь бусад /буудалд ачаа зөөгч, зохион байгуулагч/ ажлуудыг хийж байна.
- Судалгаанд хамрагдагчдын 45.0 хувь бичгээр, 14.5 хувь амаар ажил олгогчтойгоо гэрээ байгуулсан гэсэн бол 40.5 хувь нь ямар нэгэн гэрээ хийгээгүй гэж хариулжээ. Ажиллагчид ажил олгогчтой гэрээ байгуулахдаа хамгийн гол нь цалин хөлс чухал гэсэн бол ажил олгогчид цалин хөлснөөс илүү ажлын хариуцлага, тогтвор суурьшилтай байдлыг илүү чухалчилсан байна.

- Үйлчилгээний газар ажиллагчдын сарын дундаж орлого үйлчилгээний газрын төрөл, хийж буй ажлаасаа хамааран ялгаатай байсан ба дундаж цалин 67270 төгрөг байна. Бүжигчин/дуучин/ширээний үйлчлэгч, массажист/гоо сайханчдын цалин бусдаас харьцангуй өндөр байна.
- Үйлчилгээний газар ажиллахын давуу тал нь цалин хөлс гэдгийг судалгаанд оролцогчдын 32.2 хувь хариулснаас хэлж болохоор байна. Үүний дараа ажлын цагийн хуваарь, эрх чөлөөтэй, дураар ажиллах боломж орж байгаа бол үйлчилгээний газар ажилласнаар үйлчлүүлэгчидтэй танилцах боломжтой гэж багагүй хувь нь (13.2 хувь) хариулжээ. Хэдийгээр цалин хөлс авч байгаа нь давуу тал боловч цалин хөлс бага гэж 29.6 хувь нь хариулжээ.
- Нийт судалгаанд хамрагдагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацаа 12 цаг байгаа нь тухайн салбарт ажиллагчдын ажлын цаг харьцангуй урт байгааг харуулж байна.
- Үйлчилгээний газар ажиллагчдын дийлэнх буюу 62.0 хувь нь ажлын нөхцлөө сайн, 31.8 хувь нь муу, 4.1 хувь нь маш сайн, 2.1 хувь нь маш муу гэж үнэлжээ. Ажлын нөхцлөө муу болон маш муу гэж үнэлэх болсон хамгийн түгээмэл шалтгаанд цалин бага, байнга зогсож ажилладаг, цалин дээр нэмэгдэл өгдөггүй, ажлын цаг урт, амралтын өдөр байхгүй, шөнийн цагаар ажилладаг, ажлын цагийг дутуу үнэлдэг зэрэг шалтгаанууд орж байна.
- Үйлчилгээний газар ажиллагчдын 69.0 хувь үйлчлүүлэгчдийн зүгээс ямар нэгэн дарамт шахалт үзүүлдэг гэсэн байна. Үйлчлүүлэгчдийн зүгээс хэл амаар доромжлох нь хамгийн түгээмэл тохиолддог бэрхшээл бөгөөд энэхүү бэрхшээлтэй тулгарч байсан ажиллагчдын хувь 94.6 байна. Түүнчлэн бэлгийн харьцаанд орохыг шаардах (17.4 хувь), зодох (7.8 хувь) зэрэг бэрхшээлүүдийг нэрлэж байлаа.
- Судалгаанд хамрагдсан үйлчилгээний газар ажиллагчдын 21.9 хувьд үйлчлүүлэгчдийн зүгээс секс үйлчилгээ үзүүлээч гэсэн санал тавьж байсан байна. Үйлчилгээний газрын төрлөөр авч үзвэл, ресторан/баар/шөнийн клубын зөөгч/бармен, массажистуудад бусад үйлчилгээний газрын ажиллагчдад илүү ийм санал ирдэг байна.
- Баарны хамгаалагчид өдөрт дунджаар хамгийн олон буюу 88 хүнд, зөөгч бармен дунджаар 47 хүнд, буудлын жижүүр, үйлчлэгч нар дунджаар 30 орчим хүнд, массажист 10 орчим хүнд үйлчилдэг байна. Нийт үйлчлүүлэгчдийн дундаж нас 23-42 нас байна.
- Үйлчилгээний газар ажиллагчдын 97.1 хувь БЗХӨ-ний талаар сонссон бөгөөд тэдний дийлэнх нь энэ талаарх мэдээллийг телевиз (47.2 хувь), сонин сэтгүүлээс (20.9 хувь) авдаг гэжээ. ДОХ-ын талаар судалгаанд хамрагдагчдын 99 орчим хувь сонссон бөгөөд БЗХӨ-ийн нэгэн адил ДОХ-ын талаарх мэдээллийн гол эх үүсвэрүүд нь телевиз (60.4 хувь), сонин, сэтгүүл (20 хувь) байна.

- Судалгаанд хамрагдагчдын 62.4 хувь тухайн салбарт үргэлжлүүлэн ажиллах сонирхолтой байгаа бөгөөд чухам ямар хугацаанд ажиллахаа төдийлөн хэлж мэдэхгүй (60.9 хувь) байлаа.
- Үйлчилгээний газар ажиллагчдын 66.9 хувь нь гадаадад ажиллах сонирхолтой гэжээ. Хэн нэгэн хүн гадаадад үйлчилгээний газар ажиллах санал тавьбал тэдний 60.7 хувь хүлээж авна гэсэн бөгөөд талаас илүү (50.3 хувь) хувь нь ямар ч хамаагүй ажлыг хийнэ гэжээ. Харин ямар улс руу явах вэ гэсэн асуултанд дийлэнх нь (62.6 хувь) Азийн улс орон руу явах сонирхолтой гэсэн байна.
- Үйлчилгээний газар ажиллагчдын 78.5 хувь хүн худалдах гэмт хэргийн талаар сонсож байсан байна. Харин тус салбарт ажилласнаар хүн худалдах гэмт хэрэгт өртөх эрсдлийг тодруулахад тэдний 57.4 хувь эрсдэл байхгүй гэж үзжээ. Эрсдэлтэй гэж үзсэн хариулагчдын 51.5 хувь олон хүмүүстэй харьцдаг, 20.4 хувь ер нь эрсдэлтэй ажил, 14.6 хувь эдийн засгийн сонирхолын улмаас гэж хариулсан нь хамгийн өндөр хувийг эзэлж байна.

#### **Ажил олгогчийн асуудлууд**

- Судалгаанд 20-60 насны нийт 180 ажил олгогч хамрагдсан бөгөөд тэдний дундаж нас 36, хүйсийн хувьд 63.3 хувь нь эмэгтэйчүүд байв.
- Байгууллагууд хэд хэдэн нэр төрлийн үйлчилгээ хослуулан эрхлэх нь элбэг бөгөөд нийт үйлчилгээний газруудын 55.5 хувь нь нэгээс дээш нэр төрлийн үйлчилгээ үзүүлдэг гэжээ. Судалгаанд хамрагдсан байгууллагуудын талаас илүү хувь нь баар, 40 орчим хувь нь зочид буудал ажиллуулдаг бөгөөд ресторан/зоогийн газар, массаж/сауна, шөний клуб ажиллуулдаг байгууллага тус тус 25.6, 22.2 ба 20.6 хувийг эзэлж байна.
- Охид, эмэгтэйчүүд компанийн зарлалын дагуу хандаж ажилд орох нь нэлээд түгээмэл (65 хувь) байдаг байна. Мөн ажил олгогчдын 15.6 хувь нь охид, эмэгтэйчүүд өөрсдөө хандаж ирдэг, 8.9 хувь нь найз нөхөд, хамаатан садныхаа зөвлөсний дагуу тэднийг ажилд авдаг гэж хариулсан байна.
- Давхардсан дүнгээр судалгаанд хамрагдсан ажил олгогчдын 76.1 хувь нь ажиллагчдыг ажилд авахдаа ажлын өндөр чадвартай байх шаардлагыг тавьдаг гэжээ. Тогтвортой ажиллах болон нас, хүйс зэргийг мөн чухалчилсан байлаа.
- Ажил олгогчдын 83.9 хувь ажиллагчидтай гэрээ байгуулдаг гэжээ. Гэрээ байгуулаагүй шалтгаанд шаардлагагүй (62.1 хувь), хувь хүмүүс байнга солигдож байдаг (20.7 хувь), амжаагүй (17.2 хувь) гэсэн шалтгаанууд орж байна.
- Нийт ажил олгогчдын 48.3 хувь охид, эмэгтэйчүүдийг ажиллуулахад ямар нэгэн сул тал байхгүй гэжээ. Охид, эмэгтэйчүүдийг ажиллуулах давуу тал нь нямбай зан чанар (72.2 хувь) гэсэн байна. Түүнчлэн, охид,



эмэгтэйчүүдийн хурдан шуурхай (58.3 хувь), дуулгавартай (28.9 хувь), харьцахад хялбар (27.2 хувь) зэрэг давуу талуудыг нэрлэжээ.

- Ажил олгогчдын 73.3 хувь тухайн үйлчилгээний газраар гадаад үйлчлүүлэгчид үйлчлүүлэх тохиолдол байдаг гэсэн бөгөөд тэд нийт үйлчлүүлэгчдийн дунджаар 16 орчим хувийг эзэлдэг гэсэн дүн гарчээ.
- Ажил олгогч нарын 61, ажиллагсдын 50 хувь гадаадын үйлчлүүлэгчид голдуу хаанахын хүмүүс байдаг вэ гэсэн асуултанд “Хятад” гэж хариулсан байв. Түүнчлэн Солонгос, Орос, Америк хүмүүс цөөнгүй үйлчлүүлдэг нь харагдаж байна.
- Ажил олгогчдын дийлэнх (51.1 хувь) үйлчлүүлэгчид ажилтнуудад ямар нэгэн санал огт тавьдаггүй гэж үзсэн байна. Гэхдээ болзох (23.3 хувь), найзлах (22.2 хувь), бэлэн мөнгө (14.4 хувь), бие үнэлэх (11.7 хувь) зэргийг санал болгох тохиолдол мөн байдаг гэж үзэж байгаа ажил олгогчид ч байв.

**Оршил****1.1 Үндэслэл**

1990-ээд оноос эхлэн Монгол улс нийгэм эдийн засгийн ихээхэн өөрчлөлтүүдийг даван туулж ирсэн. Зах зээлийн эдийн засгийн энэхүү шилжилт нь хүн амын дунд ажилгүйдэл, ядуурал, сургууль завсардалт, хүүхдийн хөдөлмөр зэрэг олон сөрөг үр дагавруудыг бий болгосон.

Дотоодод нийгэм эдийн засгийн байдал тогтворжихгүй байгаагийн нэг илрэл бол хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн нэг болох хүүхдийн бэлгийн мөлжлөг нэмэгдэж байгаа явдал юм. Цагдаагийн Газрын мэдээнээс харахад 2004 онд насанд хүрээгүй 18-аас доош насны биеэ үнэлэгчдийн тоо 2001 оноос даруй 6 дахин нэмэгджээ. Энэ нь Цагдаагийн Газрын бүртгэлд үндэслэсэн тоо баримт бөгөөд бүртгэгдээгүй тохиолдол хэд байгааг хэлэхэд бэрхшээлтэй. Насанд хүрээгүй биеэ үнэлэгчдийг илрүүлэхэд хүндрэлтэй бөгөөд түүний тархалт, цар хүрээг тогтооход хэцүү байдаг. Хамгийн сүүлийн тоо мэдээнээс үзэхэд, Цагдаагийн газраас явуулсан нэг удаагийн баривчилгааны үеэр 260 охид, эмэгтэйчүүд баривчлагдсанаас 25 хувь нь 13-18 насны байсан байна. Залуу насны охид, эмэгтэйчүүд биеэ үнэлэх явдал нэмэгдээд зогсохгүй биеэ үнэлэх арга зам, хэлбэр өөрчлөгдөж байна гэж мэргэжлийн хүмүүс дүгнэж байна.

Зочид буудал, баар, ресторан, шөнийн клуб, саун, массаж зэрэг олон төрлийн бизнес дэлгэрч байгаа нь биеэ үнэлэгчид, тэдний зуучлагч болон үйлчлүүлэгчдийн хувьд таатай орчин, нөхцлийг бий болгож байна. Эдгээр баар цэнгээний газар ажиллаж буй үйлчилгээний ажиллагчид голдуу залуу насны охид, эмэгтэйчүүд байгаа бөгөөд тэд биеэ үнэлэх, хүмүүст уруу татагдах эрсдэлд байгаа талаар сүүлийн үеийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр яригдаж байна. Мөн гадаад оронд цалин сайтай ажилд найдвартай зуучилна, гадаадын иргэдтэй гэрлүүлнэ гэх мэтээр хуурч мэхлэн охид, эмэгтэйчүүдийг хил давуулан худалдах явдал гарч байгаа талаар бүртгэгдсээр байна. Сүүлийн жилүүдэд хүн худалдах гэмт хэрэгт өртсөн эмэгтэйчүүдийн хэрэг баримтжан, энэ хэрэг улам нэмэгдэх хандлагатай байна.

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага-Хүүхдийн Хөдөлмөрийг Устгах (АЙПЕК) олон улсын хөтөлбөрийн нэг бүрэлдэхүүн хэсэг нь хүүхдийн хөдөлмөрийн талаарх олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх, хүүхдийг биеэ үнэлэх явдлаас урьдчилан сэргийлэх явдал юм. Охид эмэгтэйчүүд, хүүхдүүд бэлгийн мөлжлөг болон хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж байгаа эсэхийг тодруулах зорилготой энэхүү судалгааг Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (АЙПЕК)-ын санхүүжилтээр Хүйсийн Тэгш Эрхийн Төв, МУИС-ийн Хүн амын сургалт судалгааны төвийн судлаачид хамтран хийж гүйцэтгэсэн юм.

**1.2 Судалгааны зорилтууд**

- Сонгогдсон хот болон хилийн боомт дахь (Улаанбаатар, Дархан-Уул, Дорноговь аймгийн Замын-Үүд хот, Дорнод аймгийн Хавирга хилийн боомт) үйлчилгээний газар ажиллаж буй хүүхэд, залуучуудын тоог тооцоолох, тэдний бэлгийн мөлжлөгт өртөж буй эрсдэлийг судлах;
- Үйлчилгээний салбарын гадна биеэ үнэлж буй охид, эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг судлах;
- Үйлчилгээний салбарт ажил эрхэлж буй охид, эмэгтэйчүүдийн хүн худалдах гэмт хэрэгт өртөх эрсдэлийг тодорхойлох;

**Судалгааны арга зүй, зохион байгуулалт**

**2.1 Судалгааны түүвэрлэлт**

Судалгаанд магадлалт бус, зорилтот түүвэрлэлтийг ашигласан ба судалгааны хүн ам нь 25-аас доош насны охид, эмэгтэйчүүд байсан. Үйлчилгээний газар ажиллагчид болон ажил олгогчдыг үйлчилгээний газруудын бүртгэл, жагсаалтад үндэслэн үйл ажиллагааны цар хүрээ, төрөл, чиглэлийг харгалзан сонгосон. Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн хувьд Цагдаагийн газраас авсан биеэ үнэлэгч охид олноор цугладаг газрын бүртгэлийг үндэслэсэн түүвэрлэсэн. Судалгааны түүвэрлэлтийг Хүснэгт 2.1-р харууллаа.

**Хүснэгт 2.1 Судалгааны түүвэрлэлт**

Аймаг/хот	Судалгааны түүвэрлэлт			
	Үйлчилгээний газрын тоо	Үйлчилгээний газарт ажиллагчдын тоо	Үйлчилгээний газрын ажил олгогчид	Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүд
Улаанбаатар	125	250	125	60
Замын Үүд	20	40	20	10
Дархан	20	40	20	10
Дорнод	20	40	20	10
Хавирга				10
<b>Нийт тоо</b>	<b>185</b>	<b>370</b>	<b>185</b>	<b>100</b>

Үйлчилгээний газар тус бүрээс 2 ажиллагч, нэг ажил олгогчоос судалгааг авахаар нийт 185 үйлчилгээний газрыг сонгосон бөгөөд зочид буудал, саун массаж, баар/шөнийн клубын тоо тухайн хот, дүүрэг, аймаг, сумын онцлогоос хамааран сонголт өөр өөр байсан. Үйлчилгээний газрын түүвэрлэлтийг дараах хүснэгтээр харууллаа.

**Хүснэгт 2.2 Үйлчилгээний газрын түүвэрлэлт**

Аймаг/хот	Зочид буудлын тоо	Саун/Массажны тоо	Баар/шөнийн клуб	Нийт үйлчилгээний газрын тоо
<b>Улаанбаатар</b>				
Сонгино-Хайрхан	4	4	12	20
Баянгол	6	4	10	20
Чингэлтэй	6	4	10	20
Хан-Уул	4	4	12	20
Баянзүрх	4	4	12	20
Сүхбаатар	6	4	10	20
Налайх	1		4	5
<b>Замын Үүд</b>	10	4	6	20
<b>Дархан</b>	8	4	8	20
<b>Дорнод</b>	8	4	8	20
<b>Нийт тоо</b>	<b>57</b>	<b>36</b>	<b>92</b>	<b>185</b>

**2.2 Асуулга**

Судалгаанд гурван төрлийн асуулгын хуудсыг ашигласан (Хавсралтаас харна уу). Судалгааны асуулга боловсруулахад судалгааны багийн гишүүд, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Шинэ Дели дахь Бүсийн зөвлөх Ноён Дэби Прасад Мондалтай хамтран ажилласан.

### 2.3 Туршилтын судалгаа

Судалгааны төлөвлөгөө, загвар, асуулгын эхний хувилбарыг боловсруулсны дараагаар асуулгын зохиомж, бүтэц, асуулгыг хянах зорилгоор туршилтын судалгааг Улаанбаатар хотын үйлчилгээний 6 салбарын ажиллагчид, ажил олгогчид болон гудамжинд бие үнэлэгч 5 охидыг хамруулан явуулсан. Туршилтын судалгааны үр дүн, мэдээлэл боловсруулах программын туршилтын дүнд тулгуурлан судалгааны асуулгыг дахин хянаж, засварлан, зарим шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг оруулан асуулгыг эцэслэн боловсруулсан.

### 2.4 Сургалт

Судалгааны ажлыг чанартай сайн гүйцэтгэх, шаардлага хангасан мэдээлэл цуглуулах үүднээс судалгааг явуулахаас өмнө судалгааны багийн ахлагч, бүртгэгч нарт зориулсан сургалтыг хийсэн. Сургалтаар судалгааны үндсэн зорилго, түүвэрлэлтийн төрөл, хэлбэр, түүврийн хэмжээ, судалгааны үе шатны ажлууд болон асуулгад хэрэглэгдэж байгаа нэр томъёо, ойлголтуудыг тайлбарлан, асуулгын хуудсыг хэрхэн нөхөх тухай дэлгэрэнгүй зааварчилгааг өгч, асуулга нөхөхөд зориулсан гарын авлагыг бэлтгэсэн. Ёс суртахууны асуудал болон хүүхдээс судалгаа авахдаа онцгой нарийн мэдрэмжтэй байх талаар сургалтад онцлон анхааруулсан.

### 2.5 Мэдээлэл цуглуулалт, боловсруулалт

Судалгааны багийн гишүүд ахлагчаар Хүйсийн Тэгш эрхийн төв, МУИС-ын Хүн амын сургалт судалгааны төвийн судлаачид ажиллаж, МУИС-ийн магистрант оюутнууд болон цагдаагийн ажилтнууд ярилцлага авагчаар ажилласан.

Асуулгын хуудсуудыг судалгааны багийн гишүүд, оюутнуудын тусламжтайгаар хянан боловсруулсан. Асуулгын хуудсыг компьютерт шивэх ажлыг Олон Улсын Макро Институтэд боловсруулсан судалгааны мэдээлэл боловсруулах ISSA болон мэдээлэлд боловсруулалт хийх ажлыг SPSS багц програмуудын тусламжтайгаар тус тус хийж гүйцэтгэсэн. Судалгааны үндсэн тайланг судалгааны багийн гишүүд хамтран бичлээ.

### 2.6 Судалгааны хамрагдалт

Судалгаанд хамрагдсан үйлчилгээний газарт ажиллагчид, бие үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн тоог Хүснэгт 2.3-т харуулав.

#### Хүснэгт 2.3 Судалгааны хамрагдалт

Аймаг/хот	Судалгааны хамрагдалт					
	Үйлчилгээний газар ажиллагчид		Ажил олгогчид		Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүд	
	Төлөвлөсөн	Хамрагдсан	Төлөвлөсөн	Хамрагдсан	Төлөвлөсөн	Хамрагдсан
	н	н	н	н	н	н
Улаанбаатар	250	170	125	125	60	60
Дорноговь	40	18	20	16	10	2
Дархан	40	24	20	19	10	10
Дорнод	40	30	20	20	20	19
<b>Нийт</b>	<b>370</b>	<b>242</b>	<b>185</b>	<b>180</b>	<b>100</b>	<b>91</b>

Тухайн судалгаа хийж буй орон нутгийн онцлогтой холбоотойгоор үйлчилгээний газрын тоо, биеэ үнэлэгчдийн тоо төлөвлөснөөс өөрчлөгдөх явдал гарсан бөгөөд судалгааны багын ахлагчтай ярьж зөвлөснөөр (магадлалт бус түүврийн аргаар) бага зэрэг нэмэх, хасах тохиолдол гарсан. Жишээ нь: Дорноговь болон Дархан-Уул аймгуудаас тус тус 40 үйлчилгээний газрын ажиллагчид болон 20 ажил олгогчийг хамруулахаар тооцсон боловч тухайн аймгуудад үйлчилгээний газрын тоо харьцангуй цөөн байсан учир тус бүр 16, 19 ажил олгогч, 18, 24 ажиллагчдаас судалгааг авсан. Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн асуулгын хувьд Дорноговь аймгийн Замын-Үүд сумаас биеэ үнэлэгч 2-хон охинтой уулзаж судалгааг авсан нь тухайн газар хил ойр учир гадагш буюу урагшаа гарч илүү үнээр биеэ үнэлдэг учраас олон охид, эмэгтэйчүүдээс судалгаа авах боломжгүй байсан.

## **2.7 Судалгааны явцад тохиолдсон зарим бэрхшээлүүд**

Судалгаа авч байх үед гарч болзошгүй хүндрэлтэй асуудлуудыг урьдчилан харж тэдгээрийг зохицуулах арга хэмжээг авч байсан боловч тодорхой хүндрэл, бэрхшээлүүд гарч байлаа. Судалгааны явцад тохиолдсон зарим бэрхшээлийг дор харуулав.

- Зарим тохиолдолд үйлчилгээний газар ажиллагчид өөрсдийн сонирхлоор судалгаа өгөх боломж хязгаарлагдмал, ажил олгогчийн зөвшөөрлөөр судалгаанд оролцож байсан.
- Зочид буудалд ажиллагчдаас судалгаа авч байх явцад жижиг, дунд буудалд ихэвчлэн хамаатнууд хамтарч ажилладаг, тэдний нас ихэнхдээ 25-аас дээш байсан. Орон нутгуудын хувьд тухайн нутаг дэвсгэр дээр үйлчилгээ үзүүлж байгаа бүх л үйлчилгээний газруудаар орж ажилтан бүрээс судалгаа авсан учир насны бүлгийн хувьд зарим тохиолдолд 25-с дээш насны хүмүүс хамрагдахаас өөр боломж байгаагүй. Тийм учраас төлөвлөгдөж байснаас цөөн тооны ажиллагсад хамрагдсан болно.
- Зарим саун, массажны газраас судалгаа авах явцад массажист бараг байдаггүй, шаардлагатай тохиолдолд дуудлагаар үйлчилгээ үзүүлдэг учраас тэр хүмүүсийг дуудаж судалгаа авах боломжгүй байсан. Зарим нэг хүнтэй дуудаж уулзахыг хүссэн боловч ажил олгогчид нь ажил гарвал дууддаг, ихэнхдээ шөнийн цагаар ажилладаг гэсэн хариулт өгч байлаа.
- Зарим шөнийн цэнгээний газруудын ажил олгогчдын зүгээс судалгааны асуултад хариулахаас дургүйцэх, хөөх ч тохиолдол гарч байсан.
- Ширээний үйлчлэгч, зөөгч хоёрыг ялгахад хэцүү, ерөнхийдөө зөөгчөөр л ажилладаг гэж ярьж байсан. Ширээний үйлчлэгч зөвхөн Солонгос эзэдтэй газруудад л ажиллаж байсан.
- Бүжигчид, дуучдын хувьд шөнийн 23-01 цагийн хооронд 10 минут тухайн цэнгээний газар ирж бүжиглээд л явдаг, ер нь байнга захиалгатай байдаг болохоор тааралдах боломжгүй, уулзахад тун хүндрэлтэй байв.
- Орон нутгуудад сауны газар цөөн, зарим орон нутагт огт байхгүй. Мөн тэнд дуулдаг, бүжиглэдэг, ширээний үйлчлэгч охидууд цөөхөн байсан.

**Үйлчилгээний салбарт ажиллаж буй хүүхэд залуучуудын тоог тодорхойлох**

Энэ хэсэг нь Улаанбаатар болон сонгогдсон аймгууд дахь үйлчилгээний салбарт ажиллаж буй хүүхэд залуучуудын тоог тодорхойлно гэсэн судалгааны зорилтот хэсэг юм. Мөн түүнчлэн энэ хэсэгт бэлгийн мөлжлөгийн талаарх тодорхойлтууд орсон болно.

**3.1 Арга зүй, аргачлал**

Түрүүчийн бүлэгт дурьдсанчлан судалгаанд хамрагдагсадыг хоёр үе шат бүхий санамсаргүй түүвэрлэлтийн арга хэрэглэн сонгосон бөгөөд энэ нь бидэнд үйлчилгээний салбарт ажиллах залуучуудын тоо болон тархалтыг жигнэх байдлаар тодорхойлох боломжийг олгосон болно.

Эхний шатанд үйлчилгээний байгууллагууд Улаанбаатар болон аймгуудаас санамсаргүй байдлаар сонгогдсон. Доор үзүүлсэн хүснэгт нь судалгаанд оролцсон аймгуудын тоог судалгааны байршлаар үзүүлсэн болно.

**Хүснэгт 3.1 Үйлчилгээний газрын тоо, төрлөөр аймаг, дүүргээр**

Аймаг/Дүүргүүд	Зочид буудал		Сауна/массажны газрууд		Баар/Шөнийн клубууд		Нийт	
	Бүртгэгдсэн	хамрагдсан	Бүртгэгдсэн	хамрагдсан	Бүртгэгдсэн	хамрагдсан	Бүртгэгдсэн	хамрагдсан
<b>Улаанбаатар</b>								
Сонгинохайрхан	26	4	17	4	68	12	111	20
Баянгол	63	6	44	4	145	10	252	20
Чингэлтэй	31	6	8	4	84	10	123	20
Хан-Уул	18	4	7	4	50	12	75	20
Баянзүрх	59	4	23	4	119	12	201	20
Сүхбаатар	58	6	18	4	115	10	191	20
Налайх	2	1	0	0	11	4	13	5
<b>Замын-Үүд</b>	11	10	4	4	11	6	26	20
<b>Дархан</b>	18	8	4	4	22	8	44	20
<b>Дорнод</b>	17	8	4	4	15	8	36	20
<b>Нийт</b>	<b>303</b>	<b>57</b>	<b>129</b>	<b>36</b>	<b>640</b>	<b>92</b>	<b>1072</b>	<b>185</b>

**Хүснэгт 3.2-т 25-аас доош насны ажиллагсад, үйлчилгээний байгууллагын төрлөөр**

Аймаг/Дүүргүүд	Зочид буудал		Сауна/массажны газрууд		Баар/Шөнийн клубууд		Нийт	
	Бүртгэгдсэн	Хамрагдсан	Бүртгэгдсэн	Хамрагдсан	Бүртгэгдсэн	Хамрагдсан	Бүртгэгдсэн	Хамрагдсан
<b>Улаанбаатар</b>								
Сонгинохайрхан	65	4	34	3	254	19	353	26
Баянгол	272	8	57	4	406	20	735	32
Чингэлтэй	79	5	37	7	318	17	434	29
Хан-Уул	54	2	16	7	186	18	256	27
Баянзүрх	306	6	43	4	487	17	836	27
Сүхбаатар	151	5	39	6	608	15	798	26
Налайх	1	0	0	0	8	3	9	3
<b>Замын-Үүд</b>	17	10	1	1	31	7	49	18

Дархан	20	6	18	3	102	15	140	24
Дорнод	21	4	1	0	33	26	55	30
<b>Нийт</b>	<b>986</b>	<b>50</b>	<b>246</b>	<b>35</b>	<b>2433</b>	<b>157</b>	<b>3665</b>	<b>242</b>

Энэ хэсэгт үйлчилгээний салбарт ажилладаг залуучуудын тоог тодорхойлон хавсаргав. Ерөнхийдөө гарсан үр дүнд сэтгэл хангалуун байгаа бөгөөд энэ нь үндэслэл сайтай гэж үзэж байна.

$$W^{i,j} = W_{establishment}^{i,j} \times W_{employees}^{i,j} \quad \text{where,}$$

$$W_{establishment}^{i,j} = \frac{M^{i,j}}{m^{i,j}} \quad W_{employees}^{i,j} = \frac{N^{i,j}}{n^{i,j}}$$

Энд,  $M^{i,j}$  - үйлчилгээний байгууллагын тоо, төрлөөр (аймаг/дүүрэг)

$m^{i,j}$  - судалгаанд хамрагдсан үйлчилгээний байгууллагын тоо төрөл (аймаг/дүүрэг)

$N^{i,j}$  - үйлчилгээний байгууллагад ажиллагсадын тоо үйлчилгээний газрын төрлөөр (аймаг/дүүрэг)

$n^{i,j}$  - судалгаанд хамрагдсан хүмүүсийн тоо үйлчилгээний газрын төрлөөр (аймаг/дүүрэг)

### 3.2 Судалгааны хамрагдалт

Судалгаанд сонгогдсон аймаг, хотуудын үйлчилгээний газруудад нийт 34341 хүн ажиллаж байгаагийн дийлэнх олонх нь (81.2%) эмэгтэй ажиллагчид байна. Тэдний тархалт сонгогдсон аймаг, хотуудад нэлээн ялгаатай буюу нийт үйлчилгээний газар ажиллагчдын 98 хувь нь Улаанбаатар хотод ажиллаж байгаа бөгөөд тэдний тархалт Баянгол, Баянзүрх, Сүхбаатар дүүргүүдэд хамгийн өндөр харин Налайх дүүрэгт хамгийн бага байна.

Улаанбаатар хотын хувьд үйлчилгээний салбар нэлээн хөгжиж бусад аймаг хоттой харьцуулахад төвлөрсөн нь харагдаж байгаа ба дүүргүүдийн хувьд ч ялгаа ажиглагдаж байна. Жишээ нь Баянгол, Баянзүрх, Сүхбаатар дүүргүүдийн хувьд үйлчилгээний салбар нэлээн төвлөрсөн байхад Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн хувьд хуучин үйлдвэрийн район байсантай холбоотой үйлчилгээний газрын тоо харьцангуй цөөн байна. Улаанбаатар хотын Баянгол /9371/, Баянзүрх /9590/, Сүхбаатар /8627/ дүүргүүдэд тус бүр нийт ажиллагчдын 30 орчим хувь ажиллаж байхад Чингэлтэй дүүрэгт /3153/ 9.2 хувь, Сонгинохайрхан дүүрэгт /2006/ 5.8 хувь, Хан-Уул дүүрэгт /1046/ 3 хувь ажиллаж байна. Ийнхүү Улаанбаатар хотод төвлөрөл хамгийн өндөр байхад үйлчилгээний газар ажиллагчдын тархалт судалгаанд хамрагдсан хилийн боомт хотууд болох Дорноговь/Замын Үүд болон Дорнод аймгуудад харьцангуй бага байлаа. Дархан-Уул аймгийн хувьд дээрх 2 аймагтай харьцуулахад арай төвлөрсөн буюу нийт 343 хүн үйлчилгээний салбарт ажиллаж байгаагийн 92.4 хувь нь эмэгтэй үлдсэн 7.6 хувь нь эрэгтэй ажиллагч байна. Эндээс харахад судалгаанд хамрагдсан аймаг, хотуудын үйлчилгээний газар ажиллагчдын тархалт тухайн орон нутгийн онцлогтой холбоотой харьцангуй ялгаатай байлаа.

**Хүснэгт 3.3 Үйлчилгээний газар ажиллагчдын тархалт, сонгогдсон хот, аймгуудаар, хүйсээр**

Аймаг/хот	Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо
<b>Улаанбаатар</b>					
Сонгинохайрхан	590	29.4	1416	70.6	2006
Баянгол	3057	32.6	6314	67.4	9371
Чингэлтэй	710	22.5	2443	77.5	3153
Хан-Уул	208	19.9	838	80.1	1046
Баянзүрх	1036	10.8	8554	89.2	9590
Сүхбаатар	787	9.1	7840	90.9	8627
Налайх	0	0.0	22	100.0	22
<b>Дорноговь/Замын Үүд</b>	32	42.1	44	57.9	76
<b>Дархан-Уул</b>	26	7.6	317	92.4	343
<b>Дорнод</b>	17	15.9	90	84.1	107
<b>Нийт</b>	<b>6463</b>	<b>18.8</b>	<b>27878</b>	<b>81.2</b>	<b>34341</b>

Үйлчилгээний газар ажиллагчдын тархалтыг үйлчилгээний газрын төрлөөр авч үзвэл нийт үйлчилгээний газар ажиллагчдын 67 хувь буюу 23015 ажиллагч баар, диско клубт, 29.2 хувь буюу 10013 ажиллагч зочид буудалд, 3.8 хувь буюу 1316 ажиллагч саун, массажны газар ажиллаж байлаа. Улаанбаатар хотын хувьд, үйлчилгээний газрын тоо болон тэнд ажиллагчдын тоогоор хамгийн өндөр Баянзүрх дүүрэгт 4829 хүн баар диско клубт, 4514 хүн зочид буудалд, 247 хүн саун массажны газруудад ажиллаж байна. Үйлчилгээний газар ажиллагчдын тоогоор Баянзүрх дүүргийн дараа орж байгаа Баянгол дүүрэгт саун массажны газар ажиллагчдын тоо бусад дүүргүүдээс хамгийн өндөр буюу нийт 627 хүн саун массажны газар ажиллаж байна.

Нийт дүнд харьцуулсан байдлаас авч үзвэл, нийт үйлчилгээний газар ажиллагчдын ихэнх нь баар диско клубуудад ажиллаж байгаа ба энэ хувь Сүхбаатар дүүрэгт 20.4, Баянгол дүүрэгт 17.1, Баянзүрх дүүрэгт 14.1 байгаа нь хамгийн өндөр байна. Харин Баянзүрх дүүрэгт нийт үйлчилгээний газар ажиллагчдын 13.1 хувь буюу 4514 хүн зочид буудалд ажиллаж байгаа нь бусад дүүргүүдээс өндөр байна. Зочид буудалд ажиллагчдын тоогоор Баянзүрх дүүргийн дараа Баянгол дүүрэг /2856 ажиллагч буюу 8.3 хувь/ орж байна.

Судалгаанд сонгогдсон Дархан-Уул болон Замын Үүд, Дорнод аймгуудын хувьд Дархан-Уул аймагт ажиллаж буй үйлчилгээний газар болон тэнд ажиллагчдын тоо бусад 2 аймгаас их буюу нийт 343 хүн үйлчилгээний салбарт ажиллаж байгаагийн 281 хүн баар, диско клубт, 45 хүн зочид буудал, 18 хүн саун массажны газар ажиллаж байна.

**Хүснэгт 3.4 Үйлчилгээний газар ажиллагчдын тархалт, сонгогдсон хот, аймгуудаар, үйлчилгээний газрын төрлөөр**

Аймаг/хот	Зочид буудал		Саун массаж		Баар, диско клуб		Бүгд	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь



<b>Улаанбаатар</b>								
Сонгинохайрхан	423	1.2	145	0.4	1439	4.2	2007	5.8
Баянгол	2856	8.3	627	1.8	5887	17.1	9370	27.3
Чингэлтэй	408	1.2	74	0.2	2671	7.8	3153	9.2
Хан-Уул	243	0.7	28	0.1	775	2.3	1046	3.0
Баянзүрх	4514	13.1	247	0.7	4829	14.1	9590	27.9
Сүхбаатар	1460	4.3	176	0.5	6992	20.4	8628	25.1
Налайх	0	0.0	0	0.0	22	0.1	22	.1
<b>Дорноговь/Замын</b>	19	0.1	1	0.0	57	0.2	77	.2
<b>Үүд</b>								
<b>Дархан-Уул</b>	45	0.1	18	0.1	281	0.8	343	1.0
<b>Дорнод</b>	45	0.1	0	0.0	62	0.2	107	0.3
<b>Нийт</b>	<b>10013</b>	<b>29.2</b>	<b>1316</b>	<b>3.8</b>	<b>23015</b>	<b>67.0</b>	<b>34343</b>	<b>100.0</b>

Дүгнэж үзэхэд 25 доош насны 30000 гаруй залуучууд Улаанбаатар, Замын-Үүд, Дархан, Дорнод аймгууд дахь үйлчилгээний салбарт ажиллаж байгаагаар тооцологдсоноос 18 нас хүрээгүй хүүхэд үйлчилгээний салбарт ажиллах нь цөөн байна. Гэвч хөдөөд явуулсан ажлын туршлагаас үзэхэд энэхүү үзэгдэл нь нууцлагдмал байх гэсэн болгоомжлол төрөх бөгөөд гарсан үр дүнгээс үзэхэд үүнд илүү анхаарал хандуулах хэрэгтэй байна.

Мөн түүнчлэн үйлчилгээний салбарт ажиллаж буй залуучууд тухайн байгууллагын эрхэлдэг үйлчилгээний төрлөөс үл хамааран мөнгөтөй болох хүсэл эсвэл эдийн засгийн эмзэг байдлаасаа хамааран бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэлд байна.

**Үйлчилгээний газар ажиллагчдын асуудлууд**

Тайлангийн энэхүү хэсэгт үйлчилгээний газар ажиллагчдын ерөнхий шинж байдал, үйлчилгээний газар ажилд орох үйл явц, ажлын болон эрүүл мэндийн нөхцөл байдал, үйлчлүүлэгчдийн шинж байдал, ДОХ/БЗХӨ-ний талаарх мэдлэг, хандлага, хүн худалдаалах гэмт хэргийн талаарх тэдний үзэл бодлыг харуулахыг зорилоо. Түүнчлэн энэхүү хэсэгт нийслэл Улаанбаатар болон сонгогдсон газруудын үйлчилгээний газрын бүртгэлийн талаар танилцуулах болно.

**4.1 Үйлчилгээний газруудын бүртгэл**

Судалгааны нэг зорилго нь Улаанбаатар хот, хилийн боомт хот болох Замын-Үүд (Дорноговь), Харгант (Дорнод) болон Дархан-Уул аймгуудад үйл ажиллагаа явуулж буй үйлчилгээний газруудын бүртгэл, жагсаалтыг гаргах байлаа. Энэ хэсэгт бид дээрх газруудын бүртгэлийг гаргадаг албан болон албан бус эр үүсвэрүүдээс авсан тоо, бүртгэлийг танилцуулахыг зорьлоо.

Улаанбаатар хотод үйлчилгээ явуулж буй баар, шөнийн цэнгээний газар, зочид буудал болон саун массажны газруудын бүртгэлийг Үндэсний Статистикийн Газар (ҮСГ), Улаанбаатар хотын ажлын албаны үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс, сонгогдсон аймгуудын Засаг Даргын Тамгын Газарын (ЗДТГ) үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс, 2005 оны 03-05 сарын хооронд үйлчилгээний газруудад хийсэн аттестатчилалын дүн мэдээ, Цагдаагийн Ерөнхий Газрын Олон нийтийн харилцааны хэлтэсээс албан бүртгэлийг гаргалаа. Албан ёсны бүртгэлгүй, хууль бусаар үйл ажиллагаа явуулж буй газруудын жагсаалтыг гаргах үүднээс орон нутгийн цагдаагийн хэсгийн байцаагчид, хороодын хэсгийн дарга нар болон лавлах утаснуудаас тус тус мэдээлэл авсан болно. Дээрх эх үүсвэрүүдээс авсан тоо мэдээллийг доорх хүснэгтэнд нэгтгэн харууллаа.

**Хүснэгт 4.1** Үйлчилгээний газруудын тоо бүртгэл, үйлчилгээний газруудын нэр төрөл, байршил, тоо мэдээллийн эх үүсвэрээр

Дүүрэг	Үйлчилгээний газрын нэр төрөл	ҮСГ	Нийслэлийн ЗДТГ-ын ҮҮХ	ЦЕГ ОНХХ, дүүргүүдийн цагдаагийн хэлтэс, дүүргүүдийн ЗДТГ	Албан бус бүртгэл	
Улаанбаатар	БГД	Зочид буудал	16	52		63
		Баар диско клуб	71	132	125	145
		Сауна массаж	-	27		44
	ЧД	Зочид буудал		21	27	31
		Баар диско клуб	59	49	48	84
		Сауна массаж	-	8		23
	СБД	Зочид буудал		46		58
		Баар диско клуб		106	115	160
		Сауна массаж	-	18		29
	ХУД	Зочид буудал	8	12		18
		Баар диско клуб	18	47	42	50
		Сауна массаж	-	4		7
	СХД	Зочид буудал		13		25
		Баар диско клуб	47	53	58	67
		Сауна массаж	-	9		18
	БЗД	Зочид буудал		39		59
		Баар диско клуб	66	104	101	111
		Сауна массаж	-	15		23
	Налайх	Зочид буудал		1	1	2
		Баар диско клуб		5	8	11
		Сауна массаж	-			-
Дорнод	Зочид буудал	5		17	17	
	Баар диско клуб	16		14	15	
	Сауна массаж			1	1	

**Хүснэгт 4.1** Үйлчилгээний газруудын тоо бүртгэл, үйлчилгээний газруудын нэр төрөл, байршил, тоо мэдээллийн эх үүсвэрээр

Дархан	Зочид буудал	7		19	23
	Баар диско клуб	47		45	50
	Сауна массаж			6	10
Дорноговь/ Замын-Үүд	Зочид буудал	11		11	12
	Баар диско клуб	10		10	11
	Сауна массаж			-	1

Хүснэгтээс харахад үйлчилгээний газруудын бүртгэл нэлээд учир дутагдалтай явагддаг нь тодорхой байна. Тухайлбал, дээрх албан эс үүсвэрүүдийн тоо, мэдээлэл өөр хоорондоо нэлээд зөрүүтэй байгаа юм. Энэ нь нэг талаас бүртгэл дутуу хийгддэг, нөгөө талаас эдгээр газруудын бүртгэлийн хэв маяг өөр байдагтай холбоотой тайлбарлагдаж болох юм. Тухайлбал, Үндэсний статистикийн газар тус бүртгэлийг тухайн бизнесийг эрхэлж буй байгууллага, компанийн нэрээр гаргадаг бол бусад эх үүсвэрүүд нь үйлчилгээний газрын нэрээр гаргадаг юм байна.

Судалгаанд хамрагдсан аймаг, хотын ЗДТГ-ын бүртгэлийг албан бүртгэлд хамрагдаагүй газруудын тоо мэдээлэлтэй харьцуулан үзэхэд баар, диско клубын бүртгэл бусад газруудын бүртгэлээс нэлээд дутагдалтай гарч байгаа нь харагдаж байлаа. Тухайлбал, Улаанбаатар хотод албан бүртгэлд хамрагдаагүй 132 баар, диско клуб үйл ажиллагаа явуулж байгаа дүн гарчээ. Бүртгэлтэй, бүртгэлгүй зочид буудал, сауна, массажны газруудын зөрүү Улаанбаатарт тус тус 72, 63 байна. Харин аймаг, орон нутагт бүртгэлтэй, бүртгэлгүй газруудын зөрүү харьцангуй бага байгаа нь мөн харагдаж байлаа.


**4.2 Үйлчилгээний газар ажиллагчдын ерөнхий шинж байдал**

Судалгаанд үйлчилгээний газар ажиллаж буй нийт 242 хүн хамрагдсаны 170 буюу 70.2 хувь нь үйлчилгээний газар ихээр төвлөрсөн Улаанбаатар хот, 30 буюу 12.4 хувь нь Дорнод, 24 буюу 9.9 хувь нь Дархан-Уул, 18 буюу 7.4 хувь нь Дорноговь аймгийн Замын-Үүдээс хамрагдлаа.

Үйлчилгээний газар ажиллагчдын дийлэнх буюу 82.2 хувь нь эмэгтэйчүүд байна. Насны бүтцийн хувьд 25-с доош насны ажиллагчдаас судалгааг авахаар байсан боловч зарим аймгуудад 25-с доош насны зочид буудлын үйлчлэгч, жижүүр олдохгүй байсан тул 25-с дээш насны эмэгтэйчүүдээс асуулгыг авах шаардлагатай болсон гэдгийг энд тэмдэглэх хэрэгтэй. Энэ талаар судалгааны явцад тохиолдсон зарим бэрхшээлүүд гэсэн 2.7-д тэмдэглэсэн байгаа.

Судалгаанд хамрагдсан үйлчилгээний газар ажиллагчдын дийлэнх нь 20 орчим насны залуучууд байгаа бөгөөд судалгаанд хамрагдагчдын дундаж нас 21 байв (Зураг 4.1).

**Зураг 4.1** Судалгаанд хамрагдсан үйлчилгээний газар ажиллагчид, нас, хүйсээр



Үйлчилгээний газар насанд хүрээгүй охид, эмэгтэйчүүд ихээр ажилладаг гэсэн таамаглалтай байсан хэдий ч судалгаанд 200 оролцогчид 40-аас 50-ух, нэмж хэлэх тохиолдол нэлээд ажиглагдсан. 19-с доош насны 15 охид, хөвгүүд судалгаанд

хамрагдсаны 1 нь 16 настай, 3 нь 17 настай, 11 нь 18 настай байсны 2 нь эрэгтэй, 13 нь эмэгтэй байлаа.


Судалгаанд хамрагдсан залуучуудын талаас илүү хувь нь буюу 40.9 хувь нь (99) сургуулиа төгссөн, 32.2 хувь нь (78) одоо сургуульд сурч байгаа, үлдсэн 26.9 хувь нь (65) одоогоор сургуульд сураагүй гэсэн хариулт өгчээ.

Одоогоор сургуульд суралцаагүй залуучуудаас 7 хүүхэд огт сургуульд суралцаж байгаагүй бөгөөд эдгээр хүүхдүүдийн 1 нь эрэгтэй, 6 нь эмэгтэй хүүхэд байна. Харин сургууль завсардсан үлдсэн 58 хүүхэд, залуучуудын 60.3 хувь нь ерөнхий боловсролын сургууль, 39.7 хувь нь их, дээд сургуулиас завсардсан байна. Хэдийгээр судалгаанд эрэгтэй хүүхдүүд цөөн хамрагдсан хэдий ч эмэгтэй хүүхдүүдтэй харьцуулбал ерөнхий боловсролын сургуулиас эрэгтэй хүүхдүүд илүү, харин их дээд сургуулиас эмэгтэй хүүхдүүд илүү завсардсан байна.

Ерөнхий боловсролын сургууль завсардсан 35 хүүхдийн дийлэнх нь буюу 71.4 хувь нь 9-10-р анги, 17.1 хувь нь 8-р анги үлдсэн 11.2 хувь нь 5-7-р ангиас завсардсан байна. Харин их дээд сургуулиас завсардсан хүүхдүүдийн хагасаас илүү буюу 65.2 хувь нь нэг, 21.7 хувь нь хоёр, үлдсэн 13.0 хувь нь гуравдугаар дамжаанаас тус тус завсарджээ.

Сургууль завсардсан болон сургуульд сураагүй шалтгааныг Зураг 4.2-т харуулав.

**Зураг 4.2** Сургуульд суралцаж байгаагүй болон сургууль завсардсан хүмүүсийн хувь, шалтгаанаар, хүйсээр



Сургууль завсардах болон сургуульд огт сураагүй шалтгаанд судалгаанд хамрагдагчдын дийлэнх нь (64.6 хувь) санхүүгийн бэрхшээлийг нэрлэж байв. Эмэгтэйчүүдийн хувьд энэ бэрхшээл арай илүү тохиолдож байгаа бөгөөд тэдний 65.5 хувь санхүүгийн бэрхшээлийн улмаас боловсролын аль нэг шатны сургуульд суралцахаа больсон эсвэл огт сураагүй байна. Харин эрэгтэйчүүдийн хувьд бүртгэл/иргэний үнэмлэхгүйн улмаас (20.0 хувь) сургуульд суралцаагүй болон завсардсан хувь нь эмэгтэйчүүдийнхтэй /1,8 хувь/ харьцуулахад өндөр байлаа. Сургуульд сурч байгаагүй болон завсардсан хүүхдүүдийн дөнгөж 15,4 орчим хувь ямар нэгэн албан бус сургалтанд хамрагдсан байна.

Ерөнхий боловсролын сургууль завсардсан хариулагчдын хувьд санхүүгийн бэрхшээл (51.4%), ажил хийх гээд (31.4 %), сонирхолгүй (8.6 %), өвчтэй (2.9 %) гэсэн шалтгаануудыг нэрлэсэн бол их дээд сургуульд үргэлжлүүлэн суралцах боломжгүй болсон шалтгаанд хариулагчдын хувьд санхүүгийн бэрхшээл (82.6 %), ажил хийх гээд (8.7%), сонирхолгүй (4.3 %), найз уруу татсан (4.3 %) гэсэн хариултуудыг өгчээ.


**Хүснэгт 4.2** Сургууль завсардсан хүмүүсийн хувь, шалтгаан, сургуулийн төрлөөр

Шалтгаан	ЕБС	Их, дээд сургууль	Бүгд
Санхүүгийн бэрхшээл	51.4	82.6	63.8
Ажил хийх гээд	31.4	8.7	22.4
Бичиг баримт/бүртгэл байхгүй	2.9	0.0	1.7
Эцэг эх явуулаагүй	2.9	0.0	1.7
Сонирхолгүй	8.6	4.3	6.9
Өвчтэй	2.9	0.0	1.7
Найз уруу татсан	0.0	4.3	1.7
<b>Нийт</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

Судалгаанд хамрагдсан үйлчилгээний газар ажиллагчдын 38.0 хувь тухайн газраа шилжин ирээд 5-аас бага жилийн хугацаанд амьдарч байгаа бөгөөд эдгээрийн талаас дээш нь (57.6 хувь) тухайн газраа бүртгүүлээгүй байв. Бүртгэл хийлгээгүй хамгийн түгээмэл шалтгаанд шилжигчид түр амьдарч байгаа учраас (41.5 хувь) гэсэн шалтгааныг нэрлэсэн байна. Түүнчлэн шилжин ирэгчдийн багагүй хувь буюу 39.6 хувь шилжүүлэг байхгүй болон бичиг баримтгүйн улмаас бүртгэл хийлгээгүй гэжээ. Шилжигчид гол төлөв гэр бүлийнхэнтэйгээ (51.1 хувь) шилжин ирдэг ба ганцаараа шилжсэн хүмүүсийн хувь 42.4 байна. Харин шилжих болсон хамгийн түгээмэл шалтгаан нь суралцах (47.8 хувь) байсан бөгөөд шилжигчдийн 29.3 хувь нь ажил хайх мөн 18.5 хувь нь эцэг эхээ дагаад шилжих хөдөлгөөнд орсон гэсэн хариултыг өгчээ.

Судалгаанд хамрагдсан үйлчилгээний газар ажиллагчдын 67 хувь буюу 23015 ажиллагч баар, диско клубт, 29.2 хувь буюу 10013 ажиллагч зочид буудалд, 3.8 хувь буюу 1316 ажиллагч саун, массажны газар ажиллаж байлаа. Ажиллаж буй газрыг хүйсийн ялгаатайгаар үзэхэд ерөнхий хэв маягаас төдийлөн ялгаатай биш байгаа боловч зөвхөн саун, массажны газар ажиллаж буй эмэгтэйчүүдийн хувийн жин эрэгтэйчүүдийнхтэй харьцуулахад нэлээд өндөр байна. Тухайлбал, эмэгтэйчүүдийн 16.6 орчим хувь нь саун, массажны газар ажилладаг байхад, эрэгтэйчүүдийн зөвхөн 4.7 хувь тус газар ажиллаж байв. Үйлчилгээний газар ажиллагчдыг ажиллаж буй газрын төрлөөр, хүйсээр Зураг 4.3-т харууллаа.

**Зураг 4.3** Үйлчилгээний газар ажиллагчдын хувь, ажиллаж буй газрын төрлөөр, хүйсээр



#### 4.3 Ажил эрхлэлт, ажилд авах үйл явц

Судалгаанд хамрагдсан үйлчилгээний газар ажиллагчдын тухайн салбарт ажиллаж буй дундаж хугацаа 2 жил байв. Гэхдээ судалгаанд хамрагдагчдын 48.3 хувь нь үйлчилгээний салбарт 1 жил, 39.3 хувь нь 2-3 жил, 12.4 хувь нь 4, түүнээс дээш ажиллаж байгаа хүмүүс байна. Судалгаанаас гарсан тооноос харахад хүмүүсийн

ажил эрхлэлтийн хугацаа ямар ажил эрхэлж байгаагаас шалтгаалахгүй байна. Үүнээс үйлчилгээний газар ажиллагчдын ажиллаж буй хугацааг үйлчилгээний газрын төрлөөр авч үзвэл, зочид буудалд ажиллагчид бусад үйлчилгээний газар ажиллагчдаас харьцангуй удаан буюу дунджаар 2.0 жил, саун, массажид ажиллагчид дунджаар 2.2 жил, бааранд ажиллагчид дунджаар 2.03 жил, шөнийн клубт ажиллагчид дунджаар 2.0 жил ажиллаж байна.

Нийт судалгаанд хамрагдагчдын 40.9 хувь өмнө нь үйлчилгээний салбарт ажиллаж байсан туршлагатай байна. Харин өмнө нь үйлчилгээний газар ажил хийж байсан ажиллагчдын 1/3 орчим нь цалин бага байсан учраас ажлаа солих болсон байна. Түүнчлэн, суралцах болсон (23.2 хувь) болон халагдсан (13.1 хувь) зэрэг шалтгаануудыг нэрлэж байв. Зураг 4.4-д үйлчилгээний газар ажиллагчдын ажлаа солих болсон шалтгааныг харуулав.

**Зураг 4.4** Ажлаа сольсон үйлчилгээний газар ажиллагчдын хувь, шалтгаанаар



Үйлчилгээний газар ажиллагчдын ихэнх нь буюу 65.6 хувь нь 18-20 насандаа, 12.4 хувь нь 21-с дээш насандаа, 14.5 хувь нь 18-с доош насандаа нь анх ажил хийж эхэлсэн байна. 18-с доош насандаа анх ажил хийж эхэлсэн хариулагчдаас 1 хариулагч 12 настайдаа, 1 хариулагч 14 настайдаа, 3 хариулагч 15 настайдаа, 10 хариулагч 16 настайдаа, 20 хариулагч 17 настайдаа анх ажил хийж эхэлсэн байна.

Үйлчилгээний газар ажиллагчид ажлаа хэрхэн олж авдаг талаар сонирхоход 31.0 хувь нь компанийн зар сурталчилгааны дагуу ажилд оржээ. Мөн өмнө нь ажиллаж байсан найз нөхөд нь зуучилсан тохиолдол цөөнгүй байлаа. Тухайлбал, тус хариултыг өгсөн хүмүүсийн хувь 30.2 байна. Гэр бүлийн гишүүд болон хамаатан, найз нөхдийн зөвлөснөөр нийт ажиллагчдын 20.7 хувь ажилд орсон бол хөдөлмөр эрхлэлтийн албаар зуучлуулан ажилд орсон хүмүүс хамгийн цөөн (2.1 хувь буюу 5 хүн) байлаа.

Одоогийн ажиллаж буй газраа хир удаан ажиллаж байгаа талаар сонирхоход, судалгаанд хамрагдсан үйлчилгээний газар ажиллагчдын тухайн газар ажиллаж буй дундаж хугацаа 8.4 сар байлаа. Ерөнхийдөө, үйлчилгээний газар ажиллагчдын нас харьцангуй залуу байдагтай холбоотойгоор ажиллаж буй хугацаа нь мөн богино байсан.


Үйлчилгээний газар ажиллагчдын одоо эрхэлж буй ажлыг хүйсээр Хүснэгт 4.3-д харуулав. Нийт судалгаанд хамрагдагчдын ихэнх нь буюу 50.8 хувь нь ресторан/баар/шөнийн клубт зөөгч/бармен, 9.5 хувь нь буудалд үйлчлэгч, цэвэрлэгч, 5.4 хувь нь буудлын жижүүр, 10.3 хувь нь бааранд хамгаалагч, 12.0 хувь нь массажист, 9.1 хувь нь бүжигчин/дуучин/ширээний үйлчлэгч, 2.9 хувь нь бусад /буудалд ачаа зөөгч, зохион байгуулагч/ ажлуудыг хийж байна. Хүйсээр ялгаатай авч үзвэл, эрэгтэйчүүд ихэвчлэн бааранд хамгаалагч буудлын жижүүр, ресторан/баар/шөнийн клубт зөөгч/бармений ажил хийж байгаа бол эмэгтэйчүүд ихэвчлэн ресторан/ баар/ шөнийн клубт зөөгч/ бармен, буудалд үйлчлэгч/ цэвэрлэгч, массажист, буудлын жижүүр хийж байна.

**Хүснэгт 4.3** Үйлчилгээний газар ажиллагчдын хувь, одоогийн эрхэлж буй ажил, хүйсээр

Одоогийн эрхэлж буй ажил	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Буудлын жижүүр	4.7	5.5	5.4
Буудалд үйлчлэгч/цэвэрлэгч	7.0	10.1	9.5
Бааранд хамгаалагч	53.5	1.0	10.3
Массажист/гоо сайханч	0.0	14.6	12.0
Зөөгч/бармен	27.9	55.8	50.8
Бүжигчин/дуучин/ширээний үйлчлэгч	2.3	10.6	9.1
Бусад	4.7	2.5	2.9
<b>Нийт</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

Судалгаанд хамрагдагчдын 45.0 хувь бичгээр, 14.5 хувь амаар ажил олгогчтойгоо гэрээ байгуулсан бол 40.5 хувь нь ямар нэгэн гэрээ хийгээгүй гэж хариулжээ. Гэрээнд тусгагддаг хамгийн чухал зүйлсийг ажиллагчид болон ажил олгогчдын хариултыг харьцуулсан байдлаар Зураг 4.5-д харууллаа.

**Зураг 4.5** Ажиллагчид болон ажил олгогчын хувь, гэрээнд тохирсон хамгийн чухал зүйлээр




Ажиллагчид ажил олгогчтой гэрээ байгуулахдаа цалин хөлсийг хамгийн чухалд үзэж буйг тэдний 50 хувь нь нэрлэснээс харж болохоор байна. Харин ажил олгогчид цалин хөлснөөс илүү ажлын хариуцлага, тогтвор суурьшилтай байдлыг (37.1 хувь) илүү чухалчилсан байна. Ажиллагчдын 46.6 хувь, ажил олгогчдын 6.6 хувь байгууллагын дотоод дүрэм, журмыг баримтлах нь хөдөлмөрийн гэрээнд заагддаг бас нэгэн чухал зүйл гэжээ.

Үйлчилгээний газар ажиллагчдын цалин хөлс бэлэн мөнгөөр олгогддог бөгөөд зөвхөн нэг хариулагч мөнгөн бус хэлбэрээр цалингаа авдаг гэж хариулсан байна.

Үйлчилгээний газар ажил эрхэлснээр ажиллагчид ямар цалин хөлс авдаг талаар бид асуусан юм. Сарын дундаж орлогыг сонирхоход нэг хүн хариулт өгөхөөс татгалзсан бөгөөд хариулагчдын сарын дундаж орлого 67,269.71 төгрөг байна. Сарын орлогыг Зураг 4.6-р харууллаа.

**Зураг 4.6** Үйлчилгээний газар ажиллагчдын хувийн жин, сарын дундаж орлогоор



Сарын дундаж орлого, хүйс, эрхэлж буй ажил, ажиллаж буй газраасаа хамааран ямар ялгаатай байгааг Хүснэгт 4.4-т харууллаа.

<b>Хүснэгт 4.4</b> Үйлчилгээний газар ажиллагчдын хувийн жин, сарын дундаж орлогоор, хүйсээр, ажиллаж буй газар болон хийж буй ажлын төрлөөр							
Үзүүлэлтүүд	< 45000	45000-59999	60000-69999	70000-79999	80000+	Нийт	Тоо
<b>Хүйс</b>							
Эрэгтэй	14.0	9.3	18.6	18.6	39.5	100.0	43
Эмэгтэй	16.2	19.7	23.7	14.6	25.8	100.0	198
<b>Эрхэлж буй ажил</b>							
Буудлын жижүүр	7.7	23.1	38.5	15.4	15.4	100.0	13
Буудалд үйлчлэгч	17.4	43.5	13.0	21.7	4.3	100.0	23
Бааранд хамгаалагч	12.5	12.5	29.2	12.5	33.3	100.0	24
Зөөгч/бармен	22.8	17.9	24.4	14.6	20.3	100.0	123
Массажист/гоо сайханч	3.4	17.2	10.3	10.3	58.6	100.0	29
Бүжигчин/дуучин/ширээний үйлчлэгч	4.5	0.0	13.6	18.2	63.6	100.0	22
Бусад	0.0	0.0	57.1	28.6	14.3	100.0	7
<b>Ажиллаж буй газрын төрөл</b>							
Зочид буудал	12.0	22.0	22.0	20.0	24.0	100.0	50
Сауна/массаж	5.9	17.6	11.8	11.8	52.9	100.0	34
Баар	19.8	17.2	25.0	18.1	19.8	100.0	116
Шөнийн клуб	17.1	14.6	26.8	4.9	36.6	100.0	41
<b>Нийт</b>	<b>15.8</b>	<b>17.8</b>	<b>22.8</b>	<b>15.4</b>	<b>28.2</b>	<b>100.0</b>	<b>241</b>

Эрхэлж буй ажил нь тухайн цалингийн хэмжээнд нөлөөлөх нь гарцаагүй. Харин ямар ялгаа байгааг ажиглавал, бүжигчин/дуучин/ширээний үйлчлэгч, массажист/гоо сайханчид цалин харьцангуй өндөр байна. Эдгээрээс 80000 төгрөгөөс дээш цалинтай ажиллагчдын хувь тус тус 63.6 хувь, 58.6 хувь буюу орлогын бусад ангиллуудаас хамгийн өндөр хувийг эзэлж байв. Харин буудлын үйлчлэгчийн цалин харьцангуй бага, 43.5 хувь нь 45000-59999 төгрөг, 17.4 хувь нь 45000 төгрөгөөс бага цалин авдаг гэжээ. Хүснэгтээс харахад зөөгч/бармений цалин харьцангуй ялгаа багатай байгаа нь ангилагдсан байдлаас илт байна.



Цалин хөлс хүйсийн хувьд нэлээд ялгаатай олгогддог гэсэн судалгааны үр дүн цөөнгүй гарсан байдаг бөгөөд бидний судалгааны дүнгээр ч баталгаажиж байна. Учир нь 80000 төгрөгнөөс дээш цалинтай эрэгтэйчүүдийн хувь 39.5 байхад орлогын тухайн бүлэглэлд багтаж буй эмэгтэйчүүдийн хувь 25.8 байгаа юм. Харин харцангуй бага цалинтай бүлгүүдийг үзэхэд, нийт эмэгтэйчүүдийн 1/5 орчим нь 45000-59999 төгрөгний сарын дундаж орлоготой гэсэн байхад нийт эрэгтэйчүүдийн 9.3 хувь л тухайн бүлэгт багтах ажээ. Ижил төстэй ажил эрхэлж буй хүмүүс ижил хэмжээний цалин авч чадаж байгаа эсэхийг тодруулах зорилгоор эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн цалингийн хэмжээг тэдний эрхэлж буй ажлын нэр төрлөөр Хүснэгт 4.5-т харууллаа.

**Хүснэгт 4.5** Үйлчилгээний салбарт ажиллагчдын хувийн жин эрхэлж буй ажлаар, хүйсээр, сарын дундаж орлогоор

Эрхэлж буй ажил		< 45000	45000-59999	60000-69999	70000-79999	80000+	Бүгд	Тоо
Буудлын жижүүр	Эрэгтэй	0.0	0.0	0.0	50.0	50.0	100.0	2
	Эмэгтэй	9.1	27.3	45.4	9.1	9.1	100.0	11
Буудалд үйлчлэгч/цэвэрлэгч	Эрэгтэй	33.3	0.0	33.4	33.3	0.0	100.0	3
	Эмэгтэй	15.0	50.0	10.0	20.0	5.0	100.0	20
Бааранд хамгаалагч	Эрэгтэй	13.0	13.0	26.1	13.0	34.8	100.0	23
	Эмэгтэй	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0	1
Зөөгч/ бармен	Эрэгтэй	16.7	8.3	0.0	25.0	50.0	100.0	12
	Эмэгтэй	23.4	18.9	27.0	13.5	17.2	100.0	111
Массажист/ гоо сайханч	Эрэгтэй	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0
	Эмэгтэй	3.4	17.2	10.3	10.3	58.8	100.0	29
Бүжигчин/ дуучин/ ширээний үйлчлэгч	Эрэгтэй	0.0	0.0	0.0	0.0	100.0	100.0	1
	Эмэгтэй	4.8	0.0	14.3	19.0	61.9	100.0	21
Бусад	Эрэгтэй	0.0	0.0	50.0	0.0	50.0	100.0	2
	Эмэгтэй	0.0	0.0	60.0	40.0	0.0	100.0	5
<b>Бүгд</b>	Эрэгтэй	14.0	9.3	18.6	18.6	39.5	100.0	43
	Эмэгтэй	16.2	19.7	23.7	14.6	25.8	100.0	198


Судалгаанд оролцсон эрэгтэйчүүдийн тоо харьцангуй цөөн тул хүйсийн хооронд харьцуулсан үзүүлэлт гаргахад хүндрэлтэй тул бааранд зөөгч болон бармен хийж буй эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн цалинг харьцуулахад хамгийн их ялгаатай байна. Тус ажлыг эрхэлж буй эрэгтэйчүүдийн 50 хувь 80000-аас дээш төгрөгийн цалинтай байхад эмэгтэйчүүдийн 69.3 хувь 70,000-аас бага цалинтай байна. Түүнчлэн, хамгаалагч болон үйлчлэгч/цэвэрлэгч эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн цалин нэлээд зөрүүтэй байгаа нь ажиглагдаж байна. Тухайлбал, эдгээр ажлыг эрхэлж буй эрэгтэйчүүд эмэгтэйчүүдтэй харьцуулахад илүү өндөр цалинтай байгаа юм. Мөн ижил төрлийн ажил хийж буй эрэгтэйчүүдийн сарын дундаж цалингийн хэмжээ нэлээд хэлбэлзэл ихтэй байгааг тэмдэглэх нь зүйтэй. Тухайлбал, цалингийн ангилал тус бүрт байгаа зөөгч/ бармен эмэгтэйчүүдийн хувь харьцангуй ойролцоо байхад ижил ажил эрхэлж буй эрэгтэйчүүдийн хувь цалингийн ангиллаас хамааран нэлээд хэлбэлзэл ихтэй байгаа юм.

Орлогоо хэрхэн зарцуулдаг талаар сонирхоход үйлчилгээний газар ажиллагчдын 37.8 хувь өрхийн хэрэгцээнд, 53.5 хувь өөрийн хэрэгцээнд, 7.5 хувь боловсрол эзэмшихэд, 1.2 хувь хадгалдаг гэж хариулжээ.


Үйлчилгээний газар ажиллагчдаас давхар ажил хийдэг эсэх талаар асуухад, тэдгээрийн дийлэнх буюу 94.6 хувь “үгүй” гэсэн хариулт өгсөн байна. Харин давхар ажил хийж байгаа судалгаанд оролцогч 13 хүнээс тухайн ажилдаа 7 хоногт хэдэн цаг зарцуулдаг вэ гэж лавлахад, дунджаар 39.2 цаг зарцуулдаг байна.

Үйлчилгээний газар ажиллахад таалагддаг болон таалагддаггүй зүйлийн талаар Зураг 4.7а, б-д харууллаа.

**Зураг 4.7 а** Үйлчилгээний газар ажиллагчдын хувийн жин, тухайн салбарт ажиллахад таалагддаг зүйлээр



**Зураг 4.7 б** Үйлчилгээний газар ажиллагчдын хувийн жин, тухайн салбарт ажиллахад таалагддаггүй зүйлээр




Үйлчилгээний газар ажиллахын давуу тал нь цалин хөлс гэж судалгаанд оролцогчдын 32.2 хувь нь хариулсан байна. Үүний дараа ажлын цагийн хуваарь, эрх чөлөөтэй, дураар ажиллах боломж орж байгаа бол үйлчилгээний газар ажилласнаар үйлчлүүлэгчидтэй танилцах боломжтой гэж багагүй хувь нь (13.2 хувь) хариулжээ. Хэдийгээр цалин хөлс авч байгаа нь давуу тал боловч цалин хөлс бага гэж 26.9 хувь нь хариулжээ. Энэ нь ажлын байрны хомсдолтой холбоотой болов уу. Түүнчлэн үйлчилгээний газар ажиллахад хамгийн тааламжгүй зүйл нь үйлчлүүлэгчдийн харьцаа байдаг юм байна. Энэхүү хариултыг хариулагчдын 1/3-ээс илүү хувь нь өгсөн байлаа. Судалгаанд хамрагдагчдын 1/5 орчим нь ажлын цаг болон эрх чөлөөтэй, дураар ажиллах боломж зэргийг тус салбарт ажиллахад таалагддаг зүйлүүд гэжээ. Мөн тухайн салбарт ажиллахад таалагддаггүй зүйлд ажлын цаг урт (15.3 хувь) болон ажлын нөхцөл муу (12.8 хувь) гэсэн зүйлүүдийг нэрлэж байсан юм.

#### 4.4 Ажлын болон эрүүл мэндийн нөхцөл байдал

Үйлчилгээний газар ажиллагчдын ажлын нөхцөл байдлыг өдөрт ажиллаж буй хугацаа, шөнийн цагаар ажиллаж байгаа эсэх, ажлын нөхцлөө тэд хэрхэн үнэлж байгаа зэрэг асуултуудын тусламжтай тодорхойлохыг зорилго. Мөн хийж буй ажлаасаа шалтгаалан ямар нэгэн эрүүл мэндийн болон бусад бэрхшээлүүд, дарамт шахалттай тулгарч байгаа талаар тодруулсан.


Судалгаанд хамрагдагчдын 13.2 хувь нь ээлжийн ажилтай бөгөөд нэг удаагийн ээлжийн үргэлжлэх цаг нь 24 цаг байдаг байна. Нийт судалгаанд хамрагдагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацаа 12цаг байгаа нь тухайн салбарт ажиллагчдын ажлын цаг харьцангуй урт байгааг харуулж байна. Үйлчилгээний газар ажиллагчдын хувьд шөнийн цагаар ажиллах шаардлага гарах нь элбэг. Судалгаанд хамрагдагчдын 55.8 хувь нь шөнийн цагаар ажилладаг гэж хариулсан байна. Цаашилбал, шөнийн цагаар ямар ажил хийдэг талаар асуухад тэдний 56.3 хувь нь зөөгч/бармен хийдэг, 14 орчим хувь нь жижүүр, 14.1 хувь нь хамгаалагч хийдэг байна (Зураг 4.8).

**Зураг 4.8** Үйлчилгээний газар ажиллагчдын хувь, шөнө хийдэг ажлын төрлөөр



Үйлчилгээний газар ажиллагчдын 62.0 хувь нь ажлын нөхцлөө сайн, 31.8 хувь нь муу, 4.1 хувь нь маш сайн, 2.1 хувь нь маш муу гэж үнэлжээ. Ажлын нөхцлөө маш муу болон муу гэж үнэлсэн хариулагчдаас яагаад ажлын нөхцлөө ийнхүү үнэлснийг нь Зураг 4.9-р харууллаа.

**Зураг 4.9** Үйлчилгээний газар ажиллагчдын хувь, ажлын нөхцлөө муу/маш муу гэж үнэлсэн шалтгаанаар



Ажлын нөхцлөө муу болон маш муу гэж үнэлэх болсон хамгийн түгээмэл шалтгаанд цалин бага болон байнга зогсож ажилладаг (48.8 болон 48.8 хувь) гэсэн шалтгааныг нэрлэж байлаа. Үүний цалин дээр нэмэгдэл өгдөггүй (36.6 хувь), ажлын цаг урт (39.0 хувь), амралтын өдөр байхгүй (32.9 хувь), шөнийн цагаар ажилладаг (31.7 хувь), ажлын цагийг дутуу үнэлдэг (24.4 хувь) зэрэг шалтгаанууд орж байна.


Нийт судалгаанд хамрагдагчдын 73.6 хувь нь эрүүл мэндийн ямар нэгэн хүндрэл, бэрхшээлтэй асуудал тулгарч байгаагүй гэжээ. Харин эрүүл мэндийн асуудал, бэрхшээлтэй тулгарч байсан хариулагчдын хувьд хамгийн түгээмэл тохиолддог бэрхшээл нь амьсгалын замын өвчин (37.5%), нуруу өвдөх (37.5%), мэдрэл, ядаргаа эдгээрийн дараа 3-рт орж байна. Эрүүл мэндийн бэрхшээлтэй тулгарч байсан 64

хүнээс 35.9% энэ асуудалтай тулгарсан байна. Түүнчлэн хариулагчдын 1/4 орчим нь бөөр, шээсний замын өвчин, 15.6 хувь арьсны өвчин, 14.1 хувь чих, хамар хоолой, 3.13 хувь зүрх судасны өвчин, 3.13 хувь нь бэлгийн замын халдвар зэрэг эрүүл мэндийн бэрхшээлүүдийг нэрлэсэн байв.

Эрүүл мэндийн бэрхшээлтэй асуудал тулгарахад 56.3 хувь нь эмийн сан, 31.3 хувь нь эмчид/эмнэлэгт, 7.8 хувь хамаатан садан/найз нөхөддөө, нэг хүн бариачид ханддаг гэсэн бол үлдсэн 4.1 хувь нь хэн нэгэнд ханддаггүй гэсэн байна.

Бид өмнө нь үйлчилгээний газар ажиллахад таалагддаггүй зүйлүүд болон ажлын нөхцлийн талаар тодруулахад үйлчлүүлэгчдийн харьцаа муу байдаг талаар хариулагчдын багагүй хувь нь дурьдаж байсан. Энд үйлчлүүлэгчдийн зүгээс үзүүлдэг дарамт, шахалтын талаар тодруулсан юм. Үйлчилгээний газар ажиллагчдын 31.0 хувь заримдаа, 34.7 хувь хааяа, 3.3 хувь үргэлж, өөрөөр хэлбэл нийт хариулагчдын 69.0 хувь үйлчлүүлэгчдийн зүгээс ямар нэгэн дарамт шахалт үзүүлдэг гэсэн байна. Харин ямар дарамт, шахалт үзүүлдгийг Зураг 4.10-с харна уу.


**Зураг 4.10** Үйлчилгээний газар ажиллагчдын хувь, үйлчлүүлэгчдийн зүгээс үзүүлж буй дарамт, шахалтаар



Үйлчлүүлэгчдийн зүгээс хэл амаар доромжлох нь хамгийн түгээмэл тохиолддог бэрхшээл бөгөөд энэхүү бэрхшээлтэй тулгарч байсан ажиллагчдын хувь 94.6 байна. Түүнчлэн бэлгийн харьцаанд орохыг шаардах (17.4 хувь), зодох (7.8 хувь) зэрэг бэрхшээлүүдийг нэрлэж байлаа.

Судалгаанд хамрагдсан үйлчилгээний газар ажиллагчдын 44.6 хувь нь хааяа, 22.3 хувь нь огт үгүй, 18.6 хувь нь заримдаа, 14.5 хувь нь байнга үйлчлүүлэгчдийнхээ анхааралд өртдөг гэж хариулсан байна. Тэдэнд үйлчлүүлэгчдийн зүгээс ямар нэгэн санал тавьдаг эсэх болон ямар санал тавьдаг талаар Зураг 4.11-д харуулав.


**Зураг 4.11** Үйлчилгээний газар ажиллагчдын хувь үйлчлүүлэгчдийн зүгээс тавьдаг саналаар



Нийт судалгаанд хамрагдагчдын 34.3 хувь нь үйлчлүүлэгчдийн зүгээс ямар нэгэн санал аваагүй бөгөөд тал хувь нь болзох, 1/4 нь мөнгө өгөх, 21.9 хувь нь бэлгийн харьцаанд орох зэрэг саналуудыг тавьдаг гэжээ. Хэдийгээр, гар цайлгах буюу цайны мөнгө өгөх явдал үйлчилгээний салбарт нэлээд элбэг тохиолддог үзэгдэл боловч Монголын хувьд энэ нь төдийлөн түгээмэл биш бөгөөд ялангуяа жижиг, дунд хэмжээний, мөн хөдөө орон нутгийн үйлчилгээний газруудад цайны мөнгө өгөх нь нэлээд ховор илрэх үзэгдэл юм. Энд хариулагчдын 12 орчим хувь гадаадад ажил эрхлэх санал тавьж байсан гэсэн хариултыг өгсөн байна. Судалгаанд хамрагдсан ажиллагчдаас үйлчлүүлэгчдийн зүгээс ямар нэгэн санал авч байгаагүй бол бусад ажиллагчдад үйлчлүүлэгчдийн зүгээс ямар санал тавьдаг талаар санал бодлыг нь сонирхсон юм. Тэдний талаас илүү хувь (55.4 хувь) секс үйлчилгээ үзүүлэх санал тавьдаг, харин 36 орчим хувь нь сайн хэлж мэдэхгүй, 7.2 хувь гадаадад ажил эрхлэх, 6.0 хувь гэрлэх, 8.4 хувь болзох зэрэг санал тавьдаг гэсэн хариултыг өгсөн байна.

Тус судалгаагаар бэлгийн мөлжлөг, цаашилбал хүн худалдах гэмт хэргийн талаар тандаж мэдээлэл цуглуулахыг зорьж байгаа билээ. Тиймээс секс үйлчилгээний талаар илүү дэлгэрэнгүй асуусан юм. Судалгаанд хамрагдсан үйлчилгээний газар ажиллагчдын 1/3-д үйлчлүүлэгчдийн зүгээс секс үйлчилгээ үзүүлээч гэсэн санал тавьж байсан байна. Үйлчилгээний газрын төрлөөр авч үзвэл, ресторан/баар/шөнийн клубын зөөгч/бармен, массажистуудад бусад үйлчилгээний газрын ажиллагчдад илүү ийм санал ирдэг байна. Доор харуулсан Зураг 4.12-оос секс үйлчилгээний санал авч байсан үйлчилгээний салбарт ажиллагчдын хувь байршлаар ялгаатай байгааг харж болно.

**Зураг 4.12.** Үйлчлүүлэгчдийн зүгээс секс үйлчилгээ үзүүлэх санал авч байсан хариулагчдын хувь байршлаар



Сексийн үйлчилгээ үзүүлэх санал авч байсан хариулагчдын хувь Замын-Үүдэд бусад газруудтай харьцуулахад харьцангуй зэрэг өндөр байна. Мөн тус саналыг авч байсан хариулагчдын хувь Улаанбаатар болон Дархан-Уул аймагт өндөр байгаа юм.


Секс үйлчилгээ үзүүлээч гэсэн санал тавьсан тохиолдолд ажиллагчид хэрхэн хүлээж авсан байдлыг сонирхоход, тэдний 70.7 хувь огт хүлээж аваагүй, 22.9 орчим хувь зарим тохиолдолд, хааяа секс үйлчилгээ үзүүлдэг гэсэн бөгөөд 6.5 хувь нь нэлээд хэдэн удаа секс үйлчилгээ үзүүлсэн гэсэн байна. Тэдний 85.2 хувь нь мөнгө олохын

тулд үлдсэн хувь нь сонирхоод, уруу татагдаад болон ажил олгогч дарамталсан учраас секс үйлчилгээ үзүүлсэн гэжээ.

Үйлчилгээний газрын бусад ажиллагчид үйлчлүүлэгчиддээ секс үйлчилгээ үзүүлдэг үү гэсэн асуултад тэдний 44.6 хувь мэдэхгүй гэсэн бол 38 хувь нь “Тийм” тэд секс үйлчилгээ үзүүлдэг гэжээ. Тэдний секс үйлчилгээ үзүүлж байгаа шалтгаан нь (89.1 хувь) эдийн засгийн сонирхол гэжээ.

Үйлчилгээний газар ажиллагчдын хувьд ажил олгогч нарын зүгээс ямар дарамт, шахалт байдаг талаар авч үзье. Судалгаанд хамрагдагчдын дийлэнх нь (69.8 хувь) ажил олгогч нарын зүгээс ямар нэгэн дарамт, шахалт үзүүлдэггүй гэсэн байна. Хааяа дарамт үзүүлдэг гэж хариулсан ажиллагчдын хувь 16.5, зарим тохиолдолд дарамт үзүүлдэг гэж 12.4 хувь хариулжээ. Харин үргэлж дарамт, шахалт үзүүлдэг гэсэн ажиллагчдын хувь хамгийн бага 1.2 хувь л байна. Ажил олгогчид ажилчиддаа чухам ямар дарамт шахалт үзүүлдгийг Зураг 4.13-д харууллаа.

**Зураг 4.13** Үйлчилгээний газар ажиллагчдын хувь ажил олгогчийн зүгээс үзүүлж буй дарамт, шахалтаар



Ажил олгогчийн зүгээс ямар нэгэн дарамт, шахалттай байдаг хариулагчдын 52.1 хувь нь хэл амаар доромжилдог гэсэн бол цалингаа цагтаа өгдөггүй болон ажлын цагийг дутуу үнэлдэг гэж тус тус 46.6, 46.6 хувь хариулжээ. Үйлчлүүлэгчидтэйгээ бэлгийн харьцаанд орохыг шаардах, ажил олгогч өөрөө бэлгийн харьцаагаар дарамтлах, гадуурхах, тэр бүү хэл зодох, худалдахыг оролдох зэрэг тохиолдол ч байдаг байна. Ажил олгогч секс үйлчилгээ үзүүлэх шаардлага тавьж байсан эсэхийг тодруулахад нийт судалгаанд хамрагдагчдаас 9 хүн “тийм” гэж хариулсан ба энэ нь тухайн үйлчилгээний газрын орлогыг нэмэгдүүлэх зорилготой байдаг ажээ.

Ажил олгогчийн зүгээс ажиллагчиддаа ямар нэгэн туслалцаа, дэмжлэг үзүүлдэг гэсэн хувь 80 орчим, үнэгүй хоол өгдөг- 81.3%, шөнийн цагаар унаагаар үйлчилдэг- 34.2% байна. Түүнчлэн үнэгүй хувцас өгдөг (22.8 хувь), шөнө ажил дээрээ хонохыг зөвшөөрдөг (20.7 хувь), үнэгүй гоо сайханы бүтээгдэхүүн өгдөг (6.74 хувь), урамшуулал/эд материалын туслалцаа (5 5.7 хувь), сэтгэл санааны дэмжлэг үзүүлдэг (1 хүн) гэжээ.

Харин судалгаанд хамрагдагчдад ямар нэгэн дарамт, шахалт, хүндрэл гарахад 17.8 хувь нь цагдаад, 20.2 хувь нь хамтран ажиллагсад, 23.1 хувь нь хамгаалагч, 19.0 хувь нь эцэг эх, ах эгч дүү, 14.5 хувь нь найз нөхөддөө ханддаг гэсэн бол хэнд ч ханддаггүй хариулагчдын хувь 5.4 байна.


#### 4.5 Үйлчлүүлэгчдийн шинж байдал

Тухайн үйлчилгээний газраар үйлчлүүлж буй хүний тоо үйлчилгээний газрын хэмжээ, үйлчилгээний төрөл зэргээс хамааран харилцан адилгүй байх нь ойлгомжтой. Түүнчлэн хийж буй ажлаасаа хамааран ажиллагчдын нэг өдөрт үйлчлэх хүний тоо нэлээд зөрүүтэй. Баарны хамгаалагчид өдөрт дунджаар хамгийн олон буюу 88 хүнд, зөөгч бармен дунджаар 47 хүнд, буудлын жижүүр, үйлчлэгч нар дунджаар 30 орчим хүнд, массажистууд 10 орчим хүнд үйлчилдэг байна.

Судалгаанд хамрагдсан үйлчилгээний газруудаар үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдийн насыг сонирхоход, хамгийн бага нь 15 харин хамгийн ахмад үйлчлүүлэгч 65 настай, нийт үйлчлүүлэгчдийн дундаж нас 23-42 нас байна. Нийт үйлчлүүлэгчдийн дунджаар 33 орчим хувийг байнгын үйлчлүүлэгчид эзэлнэ гэж тэд хариулжээ.

Хүн худалдах гэмт хэрэг нь үйлчилгээний газруудаар дамжихын сацуу ихэнхдээ хил давсан шинж чанартай байдаг тул гадаадын хүмүүс хир их үйлчлүүлдэг нь сонирхол татаж байлаа. Нийт судалгаанд хамрагдагчдын 72.3 хувь нь тэдний ажиллаж байгаа үйлчилгээний газраар гадаадын хүмүүс үйлчлүүлдэг гэсэн бөгөөд нийт үйлчлүүлэгчдийн дунд гадаадынхны эзлэх хувь дунджаар 11орчим байна.

Зураг 4.14 Үйлчлүүлэгчдийн хувь, улсаар



Гадаадын үйлчлүүлэгчдийн тал хувь нь Хятад үйлчлүүлэгчид байна. Түүнчлэн Солонгос, Орос, Америк хүмүүс цөөнгүй үйлчлүүлдэг нь харагдаж байна.

Тухайн үйлчилгээний газар биеэ үнэлэгчид ирдэг эсэх талаар тодруулахад тэдний 48.3 хувь тус асуултанд тийм, 27.3 хувь нь үгүй, 1/4 орчим нь мэдэхгүй гэсэн хариулт өгчээ. “Тийм” гэж хариулсан ажиллагчдаас биеэ үнэлэгчид зуучлагчтай байдаг эсэхийг тодруулахад, 30.8 хувь нь тийм, 17.9 орчим хувь нь үгүй, талаас дээш хувь нь (51.3%) мэдэхгүй гэж хариулсан байна.

#### 4.6 ДОХ, БЗХӨ-ний талаарх мэдлэг, хандлага

Судалгаанд хамрагдсан үйлчилгээний газар ажиллагчдын 97.1 хувь БЗХӨ-ний талаар сонссон бөгөөд тэдний дийлэнх нь энэ талаарх мэдээллийг телевиз (47.2 хувь), сонин сэтгүүлээс (20.9 хувь) авдаг гэжээ. БЗХӨ халдварлаж болох замууд, илрэх шинж тэмдгийн талаарх судалгаанд хамрагдагчдын мэдлэг харьцангуй сайн байна гэж хэлж болохоор байна. Учир нь тэдний 87.7 хувь бэлгийн хавьталд орсноор БЗХӨ-өөр халдварлана гэжээ. Гэвч ахуйн замаар, үнсэлцэх, эмнэлэгийн багаж төхөөрөмжөөр халдвар дамжина гэсэн ойлголттой хариулагчид байсаар байна.

Нийт судалгаанд хамрагдагчдын 60.0 хувь нь БЗХӨ-ний үед илрэх шинж тэмдгүүдийг мэднэ, үлдсэн 40.0 хувь нь мэдэхгүй гэжээ. Тэдний 94.5 хувь БЗХӨ-өөс сэргийлэх

боломжтой гэсэн бөгөөд 67.6 хувь нь л бэлгэвч хэрэглэх замаар сэргийлэх боломжтой гэсэн бол 22.1 хувь нь бэлгийн харьцааны зөвхөн нэг хавьтагчтай байснаар сэргийлж болно гэсэн нь энэ талаарх мэдлэг, ойлголт бас л дутмаг байгааг харуулж байна.

ДОХ-ын талаар судалгаанд хамрагдагчдын 99 орчим хувь сонссон бөгөөд БЗХӨ-ийн нэгэн адил ДОХ-ын талаарх мэдээллийн гол эх үүсвэрүүд нь телевиз (60.4 хувь), сонин, сэтгүүл (20 хувь) болж байна. Эдгээр хариулагчдын 90.0 хувь ДОХ-оос сэргийлэх боломжтой гэж хариулсан бөгөөд бэлгэвч хэрэглэснээр сэргийлж чадна гэж үзэж буй хүмүүсийн хувь хамгийн өндөр 67.1 байлаа. Түүнчлэн бэлгийн харьцааны зөвхөн нэг хавьтагчтай байх, бэлгийн харьцааг тэвчих гэж хариулсан үйлчилгээний салбарт ажиллагсдын хувь тус тус 18.5, 11.6% байна.

Судалгаанд хамрагдагчдын талаас дээш хувь БЗХӨ/ХДХВ-ын шинжилгээ огт өгч байгаагүй, 21.5 хувь нь 1-3 сарын өмнө бусад нь 3 сараас илүү хугацаанд шинжилгээнд хамрагдаагүй гэсэн дүн гарчээ.

#### **4.7 Ирээдүйн талаар**


Үйлчилгээний газар ажиллагчдаас цаашид энэ ажлаа үргэлжлүүлэн хийх эсэх, түүнчлэн тэдний ирээдүйн зорилго, хүсэл мөрөөдлийн талаар сонирхож ярилцсан юм. Тэдний 62.4 хувь тухайн салбарт үргэлжлүүлэн ажиллах сонирхолтой байгаа бөгөөд чухам ямар хугацаанд ажиллахаа төдийлөн хэлж мэдэхгүй (60.9 хувь) байлаа. Цаашид ажиллахыг хүсэхгүй байгаагийн гол шалтгаан сурах сонирхол (62.6 хувь) байгаа нь тухайн салбарт ажиллаж буй хүмүүсийн дийлэнх залуучууд байдагтай холбоотой болов уу.

Судалгаанд хамрагдагчдаас цаашид гадаадад ажиллах сонирхол, гадаадад ажиллах санал тавьбал хүлээж авах эсэх, ямар ажил хийх болон аль улс руу явах сонирхолтой байгаа талаар асуусан юм. Үйлчилгээний газар ажиллагчдын 66.9 хувь нь гадаадад ажиллах сонирхолтой гэжээ. Хэн нэгэн хүн гадаадад үйлчилгээний газар ажиллах санал тавьбал тэдний 60.7 хувь хүлээж авна гэсэн бөгөөд тал нь (50.3 хувь) хувь нь ямар ч хамаагүй ажлыг хийнэ гэжээ. Харин ямар улс руу явах вэ гэсэн асуултад дийлэнх нь (62.6 хувь) Азийн улс орон руу явах сонирхолтой гэсэн байна.

Судалгаанд хамрагдагчдын цаашдын зорилгын талаар Зураг 4.15-д харуулав.

**Зураг 4.15** Үйлчилгээний газар ажиллагчдын хувийн жин, цаашдын зорилгоор





Үйлчилгээний газар ажиллагчдын 40.9 хувь цаашид суралцах, мэргэжил эзэмших зорилготой байгаа нь хамгийн өндөр хувийн эзэлж байна. Мөнгөтэй болох, сайхан амьдрах хүсэлтэй гэсэн хүмүүс цөөнгүй буюу тус тус 20.2 ба 15.3 хувь байгаа юм.

#### 4.8 Үйлчилгээний газар ажиллагчид хүн худалдаалах асуудлын талаар

Үйлчилгээний газар ажилласнаар тэд хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх, оролцох тодорхой эрсдэлтэй болох талаар бид өмнө тэмдэглэж байсан. Түүнчлэн үйлчилгээний салбарт ажиллагчид энэ талаарх мэдээллийн чухал эх үүсвэр байж болох талаар дурьдсан. Тиймээс энэхүү хэсэгтээ үйлчилгээний газар ажиллагчид өөрсдийнхөө эрсдлийг хэрхэн үнэлж байгаа болон хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн байж болзошгүй хохирогч нарын талаар мэдээллийг тодруулахыг зорилоо.

Үйлчилгээний газар ажиллагчдын 78.5 хувь нь хүн худалдаалах гэмт хэргийн талаар сонссон байна. Харин тус салбарт ажилласнаар хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэл бий эсэхийг тодруулахад тэдний 57.4 хувь эрсдэл байхгүй гэж үзжээ. Эрсдэлтэй гэж үзсэн хариулагчдын 51.5 хувь олон хүмүүстэй харьцдаг, 20.4 хувь ер нь эрсдэлтэй ажил, 14.6 хувь эдийн засгийн сонирхолын улмаас гэж хариулсан нь хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Судалгаанд хамрагдагчдын 16.5 хувь буюу 40 хариулагч хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн охид, эмэгтэйчүүдийг мэддэг гэжээ. Энэ талаар тэд голдуу найз нөхөд, хамаатан саднаасаа (57.5 хувь) сонсож байсан байна. Мөн найз нь энэхүү гэмт хэрэгт өртсөн гэж 20 орчим хувь хариулсан бөгөөд хэвлэл мэдээллээс энэ талаар сонссон хүмүүсийн хувь цөөнгүй (17.5 хувь) байлаа. Эдгээр охид, эмэгтэйчүүдийг хаашаа худалдсан талаар тодруулахад тал хувь нь Хятад руу, 30.0 хувь нь мэдэхгүй гэсэн хариулт өгчээ.

Түүнчлэн, Монгол дотроо, Япон, Герман, Солонгос, Тайланд руу худалдагдсан гэж 1-2 хүн хариулсан байна. Харин ямар хүн тэднийг худалдсан бэ гэсэн асуултанд 57.5 хувь нь Монгол зуучлагч, 22.5 хувь нь мэдэхгүй, 17.5 хувь нь гадаадын зуучлагч гэжээ. Найз нөхөд, хамаатан садан нь хүртэл худалдсан тохиолдол байх бөгөөд тус судалгаанд хамрагдсан 1 хариулагч эдгээр ийнхүү охид, эмэгтэйчүүдийг найз нөхөд, хамаатан садан нь худалдсан гэж ярьж байв.

Хүн худалдах гэмт хэрэгт өртсөн охид, эмэгтэйчүүд одоо хаана байгаа талаар сонирхоход дийлэнх нь (47.5 хувь) хэлж мэдэхгүй гэсэн бол үлдсэн хувь нь тэднийг одоо Монгол (6), Хятад(2), Солонгос(3), Япон(2), Германд(2) байгаа гэсэн байна.

Мөн тэднийг нас барсан байх гэж таамагласан хариулагчид (6) байсан. Судалгаа явагдахаас өмнөх нэг жилийн хугацаанд хичнээн охид, эмэгтэйчүүд худалдагдсан талаар асуухад 82.5 орчим хувь нь хэлж мэдэхгүй байв. Харин үлдсэн 17.5 хувь нь худалдаалагдсан охид, эмэгтэйчүүдийн тухай мэддэг гэсэн бөгөөд хамгийн бага нь 2, хамгийн их нь 5 охидыг худалдагдсаныг мэднэ гэжээ.

Цаашилбал, судалгаанд хамрагдсан үйлчилгээний газар ажиллагчдын 59.5 хувь нь үйлчлүүлэгчид тэднээс охид, эмэгтэйчүүдийг олж өгөх санал тавьдаг гэжээ. Судалгаанд хамрагдагчдын 45.5 хувь нь зочид буудал болон бусад үйлчилгээний газруудад насанд хүрээгүй охид/хөвгүүдийг хүмүүс авч орж байсныг харсан гэсэн ба тэдний ажигласнаар эдгээр хүмүүс голдуу 29-43 насны хүмүүс бөгөөд дийлэнх нь монголчууд байдаг ажээ.

Эдгээр охид хөвгүүдэд ихэнхдээ бэлгийн харьцаанд орох (82.7 хувь), наргиж цэнгэх (2.7 хувь) саналуудыг тавьдаг байх гэж таамаглаж байна. Охид, эмэгтэйчүүдийг олж өгөх санал тавьдаг эсэх талаарх асуултанд хариулсан байдлыг хариулагчдын нас, хүйс, байршил, үйлчилгээний газрын төрлөөр Хүснэгт 4.6-д харуулсан бөгөөд нэлээд сонирхолтой үр дүн ажиглагдаж байгаа юм.

**Хүснэгт 4.6** Охид, эмэгтэйчүүдийг олж өгөх санал авч байсан эсэх хариулагчдын нас, хүйс, байршил, үйлчилгээний газрын төрлөөр

Үзүүлэлтүүд	Охид, эмэгтэйчүүдийг олж өгөх санал авч байсан эсэх		Бүгд	Тоо
	тийм	Үгүй		
<b>Нас</b>				
18-аас доош	100.0	0.0	100.0	4
18-24	58.8	41.2	100.0	238
<b>Хүйс</b>				
Эрэгтэй	60.5	39.5	100.0	43
Эмэгтэй	59.3	40.7	100.0	199
<b>Байршил</b>				
Улаанбаатар	51.2	48.8	100.0	170
Замын-Үүд	94.4	5.6	100.0	18
Дархан-Уул	75.0	25.0	100.0	24
Дорнод	73.3	26.7	100.0	30
<b>Үйлчилгээний газрын төрөл</b>				
Зочид буудал	74.0	26.0	100.0	50
Сауна/массаж	57.1	42.9	100.0	35
Баар	50.0	50.0	100.0	116
Шөнийн клуб	70.7	29.3	100.0	41
<b>Бүгд</b>	<b>59.5</b>	<b>40.5</b>	<b>100.0</b>	<b>242</b>

Хүснэгтээс харахад, хариулагчийн охид эмэгтэйчүүдээс охид, эмэгтэйчүүдийг олж өгөх санал илүү олон тавьсан байгаа нь харагдаж байна. Түүнчлэн, дээрх саналыг эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдтэй харьцуулахад илүү түгээмэл тавьжээ. Охид, эмэгтэйчүүдийг олж өгөх санал тавьж байсан эсэх асуултанд “тийм” гэж хариулсан хариулагчдын хувь Замын-Үүд, Дорнод, Дархан-Уул аймгуудад Улаанбаатар хоттой харьцуулахад нэлээд өндөр байгаа нь ихээхэн сонирхол татаж байна. Хүснэгтийг ажиглавал зочид буудалд ажиллагсадын 74.0% -д нь охид эмэгтэйчүүд олж өгөх санал тавьж байсан байгаа нь үйлчилгээний салбарын бусад байгууллагуудаас хамгийн их нь байна.

## Дүгнэлт

Үйлчилгээний газар ажиллагчид 20 орчим насны залуучууд байгаа бөгөөд тэдний дундаж нас 21 байна. Тэдний дийлэнх нь шилжин ирсэн, ерөнхий боловсролын болон их дээд сургуулийн аль нэг ангиас завсардсан, эсвэл төгсөөд ажилгүй олохгүйн улмаас энэ салбарт ажиллаж байгаа хүмүүс байна.

Тухайн салбарт ажиллаж буй дундаж хугацаа 2 жил байгаа бөгөөд тэдний талаас бага буюу 45 хувь нь ажил олгогчтойгоо бичгээр, 14.5 хувь нь амаар гэрээ хийсэн ба үлдсэн 40.5 хувь нь ямар нэгэн гэрээгүй ажиллаж байна. Ажиллагчид ажил олгогчтой гэрээ байгуулахдаа хамгийн гол нь цалин хөлс чухал гэсэн бол ажил олгогчид цалин хөлснөөс илүү ажлын хариуцлага, тогтвор суурьшилтай байдлыг илүү чухалчилсан байна.

Үйлчилгээний салбарт ажиллагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацаа 12 цаг байгаа нь тухайн салбарт ажиллагчдын ажлын цаг харьцангуй урт байгааг харуулж байна.

Судалгаанд хамрагдсан үйлчилгээний газар ажиллагчдын 1/3-д үйлчлүүлэгчдийн зүгээс секс үйлчилгээ үзүүлээч гэсэн санал тавьж байсан байна. Энэ нь үйлчилгээний газар ажиллагчид бэлгийн мөлжлөгт өртөх магадлал өндөртэйг харуулж байна.

Үйлчилгээний газар ажиллагчдын 62.4 хувь нь тухайн салбарт үргэлжлүүлэн ажиллах сонирхолтой байгаа бөгөөд чухам ямар хугацаанд ажиллахаа төдийлөн хэлж мэдэхгүй байлаа. Судалгаанд хамрагдагчдын 66.9 хувь нь гадаадад ажиллах сонирхолтой гэжээ. Үйлчилгээний газар ажиллагчид өөрсдийгээ хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэл багатай гэж үзэж байсан хэдий ч хэн нэгэн хүн гадаадад үйлчилгээний газар ажиллах санал тавьбал тэдний 60.7 хувь хүлээж авна, талаас илүү (50.3 хувь) хувь нь ямар ч хамаагүй ажлыг хийнэ гэснээс харахад үйлчилгээний газар ажиллагчид хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж болзошгүйг харуулж байгаа юм.


### Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн асуудлууд

Өмнө нь хийгдэж байсан судалгаануудаас үзэхэд хүн худалдах гэмт хэргийн золиос буюу хохирогч болох магадлал ихтэй бүлэгт хүн амын эрсдэлтэй бүлгийн биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүд, шөнийн цэнгээний газар ажиллагч залуу эмэгтэйчүүд ихэвчлэн ордог байна. Тэд амь зуулгаа залгуулах, өөрийн гэсэн мөнгөтэй болох, сургалтын төлбөрөө олох, эцэг, эхдээ туслах зэрэг олон шалтгааны улмаас биеэ үнэлэх замд ордог бөгөөд улмаар энэ нь тэднийг хүн худалдаалагчдын бай, хүн худалдах гэмт хэрэгт өртөх замыг нээж өгдөг ажээ. Гэтэл охид, эмэгтэйчүүд маань энэ байдлыг тэр бүр мэддэггүй, мэдсэн ч өнөө маргаашаа бодсоноор ганц нэгээрээ хүн худалдах гэмт хэргийн хохирогч болсоор байгаа билээ.

Энэ бүлгээр хүн худалдах гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн дунд явуулсан судалгааны дүнг үндэслэн биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн ерөнхий шинж, ажлын нөхцөл, эрүүл мэндийн байдал, тэдэнд тохиолдож буй бэрхшээлүүд, зуучлагч, үйлчлүүлэгчдийн шинж байдал, ДОХ/БЗХӨ-ний талаарх мэдлэг, хандлага, хүн худалдах гэмт хэргийн талаарх тэдний үзэл бодол зэргийг харуулахыг зорьсон юм. Судалгаанд хамрагдсан хариулагчдын тоо аймаг, хот бүрээр ялгаатай, ялангуяа Замын-Үүдийн хувьд хоёрхон эмэгтэй судлагдсан нь аймаг, хот хоорондын харьцуулсан дүгнэлтийг хийх боломжгүй болгосон. Гэвч сонирхолтой үр дүн ажиглагдсан тохиолдолд тайлбар хийхийг оролдсон.

#### 5.1 Судалгаанд хамрагдагчдын ерөнхий шинж байдал

Судалгаанд Улаанбаатар хотын 60, Дорнод аймгийн 19, Дархан-Уул аймгийн 10, Дорноговь аймгийн Замын-Үүд хотын 2, нийт 91 биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүд хамрагдсан. Тэдгээрийн дундаж нас 19.4. Хамгийн залуу нь 14 настай охин, хамгийн ахмад нь 25 настай эмэгтэй байлаа. Судалгаанд хамрагдсан охид, эмэгтэйчүүдийн насны бүтцийг Зураг 5.1-д харуулав.



Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн боловсролын түвшний байдлыг сонирхоход 17.6 хувь нь одоогоор суралцагчид, 56.0 хувь нь сургуульд суралцаагүй байгаа, 26.4 хувь нь ямар нэг шатны сургууль төгсөгчид байлаа. Одоогоор сургуульд суралцаж буй 16 охид байгаагийн дөрөвний гурав нь их дээд сургуульд, тавны нэг нь ерөнхий боловсролын сургуулийн 9-10-р ангид, үлдсэн 6.3 хувь нь ерөнхий боловсролын

сургуулийн 4-8-р ангийн сурагчид байна. Сургуульд суралцдаггүй 51 охид байгаагийн 96.1 хувь нь ямар нэг шатны сургуульд суралцаж байгаад гарсан сургууль завсардсан хүүхдүүд байна. Эдгээр сургуульд завсардагсдын 93.9 хувь нь ерөнхий боловсролын сургуулиас, үлдсэн 6.1 хувь нь буюу 3 охид их дээд сургуульд суралцаж байгаад сургуулиа хаяжээ. Ерөнхий боловсролын сургууль завсардсан охидын талаас илүү хувь нь ахлах ангид, гуравны нэг орчим нь дунд анги, үлдсэн хэсэг (15.2 хувь) нь бага ангид байхдаа сургуулиас гарсан байна. Сургууль завсардагсад дунджаар 7 жил суралцаад сургуулиас гарчээ. Их дээд сургуульд суралцаж байгаад сургуулиа хаясан 3 охид нэг, хоёр, дөрөвдүгээр дамжааны оюутан байхдаа сургуулиа орхижээ.

Сургууль завсардсан гол шалтгааныг тодруулахад сургууль завсардсан нийт охидын 41.2 хувь нь санхүүгийн бэрхшээлээс, 13.7 хувь нь эцэг, эх явуулаагүйгээс, 5.9 хувь нь ажил хийх гээд сургуулиас гарчээ. Үлдсэн хэсэг нь бусдад уруу татагдсан, ялгаварлан гадуурхагддаг, шилжин ирсэн зэрэг бусад шалтгааны улмаас сургуулиас гарсан байна.

Сургууль завсардсан болон сургуульд суралцаж байгаагүй нийт (N=51) охид, эмэгтэйчүүдийн 84.3 хувь нь ямар нэг албан бус сургалтад хамрагдаж байгаагүй байна.

Судалгаанд хамрагдсан биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн өмнөх ажил эрхлэлтийн байдлаас харахад тэдний 35.2 хувь (N=32) нь урьд өмнө ямар нэгэн ажил эрхэлж байжээ. Эдгээр ажил эрхэлж байсан охид, эмэгтэйчүүдийн бараг 94 орчим хувь нь үйлчилгээний салбарт ажиллаж байжээ. Үйлчилгээний салбарт ажиллаж байсан охид, эмэгтэйчүүдийг насны бүлгээр авч үзвэл, 6.7 хувь нь 16-17 настай, 60.0 хувь нь 18-21 насны, 33.3 хувь нь 22-25 насныхан байна. Харин бусад салбарт ажиллаж байсан ердөө хоёрхон эмэгтэй байгаа тэд 22-25 насны эмэгтэйчүүд байна.

Урьд өмнө ажил эрхэлж байсан нийт охид, эмэгтэйчүүдийн (N=32) 15.6 хувь нь 13-15 насандаа, 43.8 хувь нь 16-18 настайдаа анх ажиллаж эхэлсэн байна. Ажил эрхэлж эхэлсэн дундаж нас 18.1 байна. Мөн эдгээр ажил эрхэлж байсан охид, эмэгтэйчүүдээс ажлаа сольсон гол шалтгааныг асуухад бараг тал хувь нь цалин бага, 15.7 хувь нь ажлын нөхцөл муу, 6.3 хувь нь ажил олгогч дарамталдаг, үлдсэн хэсэг нь сургуульд суралцах болон гэр бүлийн бусад шалтгааны улмаас ажлаасаа гарсан байна.


Судалгаанд хамрагдсан нийт (N=91) охид, эмэгтэйчүүдийн 42.9 хувь нь одоогийн оршин сууж буй газартаа 5-аас доош жил, 57.1 хувь нь 5 ба түүнээс дээш жилийн хугацаатайгаар амьдарч байна. Насны ялгавартай байдлаар шилжилтийн статусыг харвал, 14-15 насны охидын 61.5 хувь, 16-17 насны охидын 50.0 хувь, 18-21 насныхны 29.5 хувь, 22-25 насны эмэгтэйчүүдийн 34.6 хувь нь шилжин ирэгчид буюу одоогийн оршин сууж буй газраа 5-аас доош жил амьдарч байгаа ажээ. Шилжих хөдөлгөөнд оролцсон охид, эмэгтэйчүүдийн (N=39) 43.6 хувь нь гэр бүлийнхэнтэйгээ, 35.9 хувь нь ганцаараа, найз нөхөдтэйгээ 15.4 хувь нь шилжин ирсэн байна. Эдгээр охид, эмэгтэйчүүдийн 35.9 хувь нь эцэг эх, гэр бүлээ дагаад, 25.6 хувь нь ажил олж хийхээр, 17.9 хувь нь суралцах, 7.7 хувь нь их мөнгө олох зорилготойгоор одоогийн амьдарч буй газартаа шилжин иржээ. Шилжин ирсэн охид, эмэгтэйчүүдийн 70 гаруй хувь нь орон нутгийн засаг захиргаандаа бүртгүүлээгүй байгаа ба бүртгүүлээгүйн гол шалтгаанаа орон нутгийн шилжүүлэг байхгүй (32.1 хувь), бичиг баримтгүй (17.9 хувь), түр зуур амьдарч байгаа (25.0 хувь), хаана бүртгүүлэхээ мэдэхгүй (14.3 хувь) зэрэгтэй холбон тайлбарлаж байв.

## **5.2 Амьдралын нөхцөл, Гэр бүл, Хүүхэд нас**

Аливаа хүн бие хүн болж өсөж, хүмүүжихэд хүүхэд насаа өнгөрөөсөн үе, гэр бүлийн орчин, найз нөхөд, хамт олны нөлөө чухал байдаг билээ. Иймд судалгаанд хамрагдсан биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн гэр бүлийн байдал, хүүхэд насны талаар судалж үзсэн юм.

Судалгаанд хамрагдагчдын 37.4 хувь нь одоогоор гэр бүлийнхэнтэйгээ цуг, 62.6 хувь нь ганцаараа болон гэр бүлийн гишүүн бус хэн нэгэн хүнтэй амьдардаг ажээ. (Зураг 5.2).

**Зураг 5.2 Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн хамт амьдардаг хүмүүс**



Хамт амьдарч байгаа хүмүүсийн бүтцийг охид, эмэгтэйчүүдийн насны бүлгээр ялгаатай авч үзвэл, гэр бүлийнхэнтэйгээ хамт амьдардаггүй 14-15 насны 10 охид байгаагийн 40.0 хувь нь найзуудтайгаа, 30.0 хувь нь ганцаараа, 20.0 хувь нь халамжийн төвд, үлдсэн хэсэг нь найз залуу болон найз нартайгаа хамт амьдарч байна. 16-17 настай охидын хувьд мөн 10 охид ганцаараа буюу гэр бүлийн гишүүн бус хэн нэгэнтэй хамт амьдарч байгаагаас 40.0 хувь нь найзуудтайгаа, 20.0 хувь нь зуучлагчтайгаа, бусад нь найз залуу, хамаатан, халамжийн төвд амьдрагчид ажээ. Харин судалгаанд хамрагдсан нийт 18 ба түүнээс дээш настай эмэгтэйчүүдийн 61.7 хувь нь ганцаараа болон гэр бүлийн гишүүн бус хэн нэгэнтэйгээ амьдарч байна. Тэдний хувьд 56.8 хувь нь найз нартайгаа, 18.9 хувь нь ганцаараа, 8.1 хувь нь хамаатантайгаа, 5.4 хувь нь зуучлагчтайгаа, үлдсэн хэсэг нь найз залуу, таньдаг айл, оюутны дотуур байранд амьдарч байна.

Судалгаанд оролцогчдын 35.2 хувь нь 2-3, 30.8 хувь нь 4-5, 15.4 хувь нь 6 ба түүнээс дээш хүнтэй одоогоор хамт амьдарч байгаа ажээ. Дунджаар 3.5 хүнтэй хамт амьдарч байна.

Судалгаанд хамрагдсан биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн одоогийн амьдарч буй сууцны төрөл, түүний эзэмшлийн талаар сонирхон үзэхэд тэдний 39.6 хувь нь өөрийн сууцанд, бусад нь түрээсийн (34.1 хувь), зуучлагч үнэгүй байлгадаг (4.4 хувь), хамаатан, найз нөхөд үнэгүй байлгадаг (16.5 хувь), халамжийн төвд (5.5 хувь) амьдарч байгаа гэж хариулжээ. Одоогийн амьдарч буй сууцны эзэмшлийг насны ялгавартай байдлаар харвал, 14-15 настай охидын дунд өөрийн болон халамжийн төвийн байранд амьдрагчид (тус бүр 38.5 хувь) давуу байхад 16-17 насны охидын хувьд өөрийн болон хамаатан, найзындаа (тус бүр 33.3 хувь) амьдрагчид их байна.

Харин 18-21 насныхны тэн хагас нь түрээсийн байранд амьдарч байгаа ажээ. 22-25 насны эмэгтэйчүүдийн бараг тал хувь нь өөрийн эзэмшлийн байранд амьдарч байна. 22-25 насны эмэгтэйчүүдийг зуучлагч нь үнэгүй байлгах явдал (7.7 хувь) бусад насны бүлгийнхэнтэй харьцуулахад өндөр байна. Тэгэхэд 16-17 насны охидын 5.6 хувь, 18-21 насныхны 2.9 хувийг зуучлагч нь үнэгүй байлгадаг ажээ. Харин 14-15 насны охидын хувьд ийм тохиолдол байхгүй байна.


Сууцны төрлийн хувьд гэрт 44.0 хувь, хувийн байшинд 16.5 хувь, тохилог сууцанд 20.9 хувь, зочид буудалд 6.6 хувь, дотуур байранд 3.3 хувь, халамжийн төвийн байранд 7.7 хувь нь тус тус амьдардаг байна. Сууцны төрлийг насны бүлгээр ялгаатай авч үзвэл, 18-21 насны бүлгийнхнээс бусад бүлгийнхний хувьд гэрт амьдрагчид зонхилох хувийг эзэлж байна. Тухайлбал, 14-15 насныхны 46.2 хувь, 16-

17 насныхны 55.6 хувь, 22-25 насныхны 53.8 хувь нь гэрт амьдарч байна. 14-15 насныхны дунд халамжийн төвд (46.2 хувь) байрлагчид бусад насны бүлгийнхэнтэй харьцуулахад олон байна. Нийтийн эзэмшлийн орон сууцанд амьдарч буй охид, эмэгтэйчүүдийн хувь 18-21 насны бүлгийнхний хувьд (29.4 хувь) бусадтай харьцуулахад илүү байна. Байшинд нийт охид, эмэгтэйчүүдийн 11.1-29.4 хувь нь амьдарч байгаа ба насны бүлгийн хувьд онцын ялгаа алга байна. Ерөнхийд нь гэр болон байшинд амьдрагчдыг хамтад нь гэр хорооллын оршин суугч гэж тооцвол, нийт судалгаанд хамрагдсан охид, эмэгтэйчүүдийн бараг 60-аас илүү хувь нь гэр хороололд амьдрагчид болж байгаа юм.

Эцэг эхийн гэр бүлийн байдал, ам бүлийн тоо, айлын хэд дэх хүүхэд, гэр бүлийнхэнтэйгээ ямар харилцаа холбоотой байдгаас судалгаанд оролцогчын биеэ авч яваа байдал болон одоогийн эрхэлж буй ажлаа хийх шалтаг болсон байж болзошгүй юм. Ийм учраас судалгаанд оролцогчдын гэр бүл, хоорондын харьцаа холбоо, эцэг эхийнх нь гэр бүлийн байдал зэргийн судлан, тэдгээрийн хамаарлыг тогтоохыг зорилго.

Эцэг эхийнх нь гэр бүлийн байдал болон судалгаанд оролцогчид гэр бүлийнхэнтэйгээ хамт амьдарч буй эсэхийг харуулсан хамаарлыг Зураг 5.3-аар харуулав.

**Зураг 5.3 Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн гэр бүлийнхэнтэйгээ хамт амьдардаг эсэх, эцэг эхийн гэрлэлтийн байдлаар**



Тэмдэглэл: Давхар хариултаас тооцсон тул хувийн жин 100-аас илүү байна.

Зургаас харахад эцэг эх нь салсан, дахин гэрлэсэн охид, эмэгтэйчүүдийн хувьд гэр бүлийнхэнтэйгээ хамт амьдрахгүй байх тохиолдол их байна. Мөн эцэг эхийнх нь хэн нэг нь дахин гэрлэсэн тохиолдолд ч хамт амьдрах явдал бага байна.

Судалгаанд оролцогч охид, эмэгтэйчүүдийн ам бүлийн тоог авч үзэхэд тавны нэг нь 8 ба түүнээс дээш, аравны нэг нь 1-3, бараг гуравны нэг орчим нь 5 ам бүлтэй гэр бүлээс гаралтай ажээ. Ам бүлийн дундаж тоо 5.6 байна. Одоогоор гэр бүлд нь байгаа гишүүдийг сонирхоход давхардсан дүнгээр 71.4 хувь нь ээж, 56.0 хувь нь эгч, дүү, 42.9 хувь нь ах, дүү, 37.4 хувь нь аав, 18.7 хувь нь хойд эцэг, 7.7 хувь нь хойд эх, 4.4 хувь нь хамаатан садан нь гэж хариулжээ.

Нийт судалгаанд оролцогч охид, эмэгтэйчүүдийн аравны нэг нь айлын ганц хүүхэд, 38.5 хувь нь 1-2, 31.9 хувь нь 3-4, үлдсэн 19.8 хувь нь 5 ба түүнээс олон ах, эгч, дүүтэй гэжээ. Мөн нийт охид, эмэгтэйчүүдийн бараг тал хувь нь айлын 2-3 дахь хүүхэд, гуравны нэгээс илүү хувь нь айлын анхны хүүхэд, үлдсэн хэсэг нь дөрөв, тав, зургаа, долоо дахь хүүхэд нь гэж хариулсан байна.

Гэр бүлийнхэнтэйгээ хэр ойр дотно байдаг талаар асуухад нийт хариулагчдын хувьд гэр бүлийн гишүүдтэйгээ дотно бус байдаг хүн нэг ч байхгүй байлаа. Харин тэдний 35.2 хувь нь бүгдтэй, 22.0 хувь нь ах, эрэгтэй дүүтэйгээ, 22.0 хувь нь эгч, эмэгтэй дүүтэйгээ, 20.9 хувь нь хэн нэгэнтэй нь дотно харьцаатай байдаг байна. Насны бүлгээр харвал, гэр бүлийн гишүүдтэйгээ дотно харьцаатай байх явдал 14-15 насны охидын хувьд бусад насны бүлгийнхэнтэй (32.1-42.3 хувь) харьцуулахад 2.5 дахин бага байна.

Гэр бүлийнх нь муу хандаж байсан эсэхийг тодруулахад тал хувь нь хэзээ ч ийм тохиолдол болж байгаагүй гэж хариулсан байхад тохиолдож байсан гэж хариулсан охидын хувьд давхардсан тоогоор 35.2 хувь нь сэтгэл зүйн, 17.6 хувь нь бие махбодын дарамт үзүүлдэг, 19.8 хувь нь гэрээсээ хөөдөг, 11.0 хувь нь сургуульд суралцуулахгүй завсардуулсан, 5.5 хувь нь хоол ундгүйгээр байлгах явдал байдаг гэсэн хариултыг өгчээ.

Гэхдээ насны бүлгийн хувьд нэлээд ялгаатай дүр төрх ажиглагдаж байна. Тухайлбал, 14-15 насны охидын 15.4 хувь нь гэрийнхэн нь хэзээ ч муу хандаж байгаагүй гэдэг хариулт өгсөн нь бусад насны бүлгийн охид, эмэгтэйчүүдийнхтэй харьцуулахад харьцангуй бага байна.

Судалгаанд хамрагдсан нийт охид, эмэгтэйчүүдийн анхны бэлгийн харьцаанд орсон дундаж нас 16.2. Тэдний 1.1 хувь нь 9 настайдаа, аравны нэг нь 12-13, дөрөвний нэг нь 14-15, гуравны нэг нь 16-17, тавны нэг нь 18-19, үлдсэн 8.8 хувь нь 20-23 настайдаа анх бэлгийн харьцаанд оржээ.


Анх бэлгийн харьцаанд орохдоо 36.3 хувь нь найз залуутайгаа, 22.0 хувь нь санамсаргүй тохиолдлоор орсон байна. Гэр бүл болсноор анх бэлгийн харьцаанд орох тохиолдол цөөхөн байна. Харин зарим охид, эмэгтэйчүүдийн хувьд хүчиндүүлж (19.8 хувь), биеэ үнэлж (4.4) анхны бэлгийн харьцаанд орсон байлаа.

Анх бэлгийн харьцаанд ямар нөхцөлд орж байсан талаарх мэдээллийг насны бүлгээр Зураг 4.4-т харуулав. Зургаас харахад, 14-15 настай охидын хувьд хүчиндүүлж анх бэлгийн харьцаанд орсон тохиолдол бусадтайгаа харьцуулахад харьцангуй өндөр байна.

Гэрлэснээр анх бэлгийн харьцаанд орох тохиолдол 22-25 насны бүлгийн эмэгтэйчүүдээс бусад охид, эмэгтэйчүүдийн хувьд байхгүй байна. 21 ба түүнээс доош настай охидын хувьд биеэ үнэлснээр анх бэлгийн харьцаанд орох тохиолдол нэлээд байна.



**Зураг 5.4 Анх бэлгийн харьцаанд орсон нөхцөл**



Судалгаанд оролцсон нийт (N=91) охид, эмэгтэйчүүдийн 40.7 хувь нь хүчиндүүлж байжээ. Хүчиндүүлсэн охид, эмэгтэйчүүдийн (N=37) 51.4 хувь нь нэг, 21.6 хувь нь хоёр, 8.1 хувь нь гурав, 18.9 хувь нь дөрөв ба түүнээс дээш удаа хүчиндүүлсэн байна. Эдгээр охид, эмэгтэйчүүдээс хүчиндсэн хүмүүс нь хэн байсныг тодруулахад 59.5 хувь нь үл таних хүнд, 13.5 хувь нь найздаа, 10.8 хувь нь хамаатандаа, бусад нь хойд эцэгтээ (8.1 хувь), найз залуу (5.4 хувь) болон үйлчлүүлэгчдээ (2.7 хувь) хүчиндүүлж байжээ.

Насны ялгаатай байдлаар авч үзвэл, 14-15 насны охидын 92.3 хувь, 16-17 насныхны 66.7 хувь, 18-21 насныхны 17.6 хувь, 22-25 насны эмэгтэйчүүдийн 26.9 хувь нь хүчиндүүлж байжээ.

Дээрх 2 хэсгээс дүгнэж хэлэхэд 16-21 насны, ялангуяа 16-17 насны буюу шилжилтийн насны охидууд, санхүүгийн болон гэр бүлийн амьдралын бэрхшээлт байдлаас шалтгаалж сургууль завсардсан, олон хүүхэдтэй, гэр хорооллын өрхийн, эцэг, эх нь салсан эсвэл дахин гэрлэсэн, гэр бүлийнхнээс нь тодорхой хэмжээгээр дарамт шахалт үзүүлдэг, найзуудтайгаа болон ганцаараа амьдардаг, үйлчилгээний салбарт ажилладаг, урьд өмнө нь хэн нэгэнд хүчиндүүлж байсан охид, эмэгтэйчүүдийн хувьд биеэ үнэлэх явдалд орох, уруу татагдах тохиолдол илүүтэй байгаа нь ажиглагдаж байна.


### 5.3 Биеэ үнэлэх байдал

Өмнөх хэсгүүдэд судалгаанд хамрагдсан биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн нас, боловсрол, өмнөх ажил эрхлэлт, хүүхэд нас, гэр бүл, тэднийг тойрон хүрээлж буй найз нөхөд, хамаатан садан, тэдгээрийн хоорондын харилцаа холбоо зэрэг ерөнхий шинж байдлыг харуулсан олон асуудлыг авч үзсэн бол энэхүү хэсэгт биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн биеэ үнэлэх байдал, энэ зам руу ороход нөлөөлсөн хүчин зүйлс, тэдэнд тохиолдож буй бэрхшээл, цаашдын хувь заяаны талаарх судалгааны гол үр дүнг танилцуулъя.

#### **Биеэ үнэлж буй хугацаа**

Судалгаанд хамрагдсан нийт охид, эмэгтэйчүүд дунджаар 1.6 жил биеэ үнэлж байгаа ажээ. Биеэ үнэлж буй хугацааг авч үзвэл 23.1 хувь нь нэгээс доош жилдээ, 8.8 хувь нь 5 ба түүнээс дээш жил биеэ үнэлж байна (Зураг 5.5).

Зураг 5.5 Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн биеэ үнэлж буй хугацаа



Биеэ үнэлж эхэлсэн анхны наснаас харахад хамгийн бага нь 12, хамгийн ахмад нь 25 настайдаа, дунджаар 17.8 настайдаа биеэ үнэлж эхэлсэн байна.

Судалгаанд хамрагдсан аймаг, хотоор авч үзвэл, Улаанбаатар хотоос судалгаанд хамрагдсан охид, эмэгтэйчүүдийн 70 орчим хувь, Дорнод

аймгийн охид, эмэгтэйчүүдийн 57.9 хувь нь 18 ба түүнээс доош насандаа биеэ үнэлж эхэлсэн байна. Харин Дархан-Уул аймгийн охид, эмэгтэйчүүдийн 80.0 хувь нь 19-өөс дээш насандаа биеэ үнэлж эхэлсэн байна. Ерөнхийдөө, нийт судалгаанд хамрагдсан охид эмэгтэйчүүдийн 60.4 хувь нь 18 ба түүнээс доош насандаа буюу насанд хүрээгүй, бие организм нь бүрэн хөгжиж амжаагүй байхдаа биеэ үнэлж эхэлсэн нь анхаарал татахаар асуудлын нэг болж байна.

### Биеэ үнэлэх болсон шалтгаан

Судалгаанд оролцсон нийт охид, эмэгтэйчүүдийн биеэ үнэлэх болсон шалтгааныг анхны болон одоогийн гэсэн цаг хугацааны ялгаатай байдлаар, насны бүлгээр Хүснэгт 5.1-д харуулав.

Хүснэгт 5.1 Биеэ үнэлэх болсон анхны болон одоогийн шалтгаан, насны бүлгээр

Биеэ үнэлж буй шалтгаан	Насны бүлэг							
	14-15 нас		16-17 нас		18-21 нас		22-25 нас	
	Анхны	Одоогийн	Анхны	Одоогийн	Анхны	Одоогийн	Анхны	Одоогийн
Мөнгө олох гээд	46.2	92.3	66.7	72.2	47.1	70.6	46.2	65.4
Найз нөхдөө дагаад	23.1	0.0	11.1	11.1	20.6	8.8	15.4	11.5
Гэр бүлийн зөрчил	0.0	0.0	0.0	0.0	2.9	0.0	11.5	0.0
Гэр бүлээ тэжээх гээд	0.0	0.0	0.0	5.6	8.8	11.8	15.4	15.4
Боловсрол, сургалтын мөнгө олох гээд	0.0	0.0	0.0	0.0	8.8	2.9	3.8	3.8
Хүчиндүүлснээс	30.8	7.7	11.1	11.1	2.9	0.0	0.0	3.8
Хүчээр	0.0	0.0	11.1	0.0	2.9	0.0	3.8	0.0
Сонирхоод	0.0	0.0	0.0	0.0	5.9	5.9	3.8	0.0
Хувь	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	13	13	18	18	34	34	26	26

Хүснэгтээс харахад аль ч насны охид, эмэгтэйчүүдийн хувьд анхны болон одоогийн шалтгаанд мөнгө олох явдал голлож байна. Мөнгө олох гээд анх биеэ үнэлсэн гэж тал хувь нь хариулж байсан бол одоо биеэ үнэлэх гол шалтгаан нь мөн л мөнгө олох явдал гэж 70-аас дээш хувь нь хариулсан байна. Мөн үүний дараагаар гэр бүлээ тэжээх, найз нөхдөө дагаж, хүчиндүүлснээс ийм замд орсон буюу ийм замаар явахаас өөр аргагүй болоод байгаа гэдэг хариултыг өгчээ.

Анхны болон одоогийн шалтгааныг харьцуулахад гэр бүлээ тэжээхийн тулд биеэ үнэлж буй байдал 16-17 настай болон 18-21 насны охид, эмэгтэйчүүдийн хувьд ялимгүй өссөн байна. Харин мөнгө олох гэсэн шалтгааныг тоочигчид 20 гаруй хувиар нэмэгдсэн байгаа нь нэг талаас амьдралын нөхцөл байдал дорой, ядуу байгаагийн илрэл, нөгөө талаас охид эмэгтэйчүүдийн дунд хялбар аргаар мөнгө олох гэсэн буруу ойлголт илүү түгээмэл болоо юу гэдэг сэтгэгдлийг төрүүлэхээр байна.

Судалгаанд хамрагдсан биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн тэн хагас нь найз нөхөд нь энэ ажилд анх оруулж байсан гэдэг хариултыг өгчээ. Мөн тэдний гуравны нэг нь өөрөө энэ замд орсон бол 14.1 хувь нь танил хүн, зуучлагч, 6 гаруй хувь нь бусад буюу хүчиндүүлсэн, хадам эцэг нь энэ ажилд оруулсан зэрэг тайлбарыг өгсөн байна. Насны бүлгээр харахад, мөн л дээрхтэй ижил дүр төрх ажиглагдаж байна. Тухайлбал, 14-15 насны охидын 46.2 хувь, 16-17 насныхны 44.4 хувь, 18-21 насныхны 55.9 хувь, 22-25 насны эмэгтэйчүүдийн 46.2 хувь нь найзууд нь уруу татсанаар биеэ үнэлж эхэлсэн ажээ.

Дээрх байдлаас дүгнэхэд гэр бүлийн хүнд хэцүү амьдрал, санхүүгийн бэрхшээл, залуу насны гэнэн томоогүй шохоорхол, бусдад уруу татагдах, бусдын хүчирхийлэлд автагдсанаас охид, эмэгтэйчүүд маань биеэ үнэлэх замд орж байгаа нь харагдаж байна. Судалгаанд хамрагдсан аймаг, хотын ялгаатай байдлаар харахад онцын ялгаатай байдал ажиглагдсангүй.

### **Биеэ үнэлэх ажлын нөхцөл**


Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн анх биеэ үнэлэхдээ ажиллаж байсан болон одоо биеэ үнэлж байгаа газруудын талаар сонирхоход бараг тал хувь нь гудамжинд зогсож, гуравны нэг орчим нь зочид буудлаар явж биеэ үнэлдэг байна. Мөн шөнийн цэнгээний газар болон дуудлагаар явж биеэ үнэлдэг охид, эмэгтэйчүүд цөөнгүй байгаа нь харагдлаа. Улаанбаатар хотоос судалгаанд хамрагдсан охид, эмэгтэйчүүдийн 60.0 хувь, Дархан-Уул аймгийн охидын 40.0 хувь нь гудамжинд зогсож биеэ үнэлдэг бол Дорнод аймгийн охидын хувьд бараг тал хувь нь зочид буудлаар явж биеэ үнэлдэг ажээ. Харин Замын-Үүдийн хувьд судалгаанд хоёрхон эмэгтэй хамрагдсан бөгөөд нэг эмэгтэй зочид буудлаар, нөгөө нь шөнийн цэнгээний газраар явж биеэ үнэлдэг байна.

Анхны болон одоогийн биеэ үнэлж буй газруудыг хооронд нь харьцуулахад зочид буудал, саун болон гудамжинд биеэ үнэлэгчид бага зэрэг нэмэгдэж, бусад тохиолдлын биеэ үнэлэгчдийн хувь буурсан байдал ажиглагдлаа.

Хэдийгээр биеэ үнэлдэг газраа сольсон охид, эмэгтэйчүүдийн эзлэх хувь цөөхөн буюу нийт судалгаанд оролцогчдын 15.4 хувийг эзэлж байгаа ч биеэ үнэлдэг газраа өөрчилсөн байдлыг нарийвчлан харахад сонирхолтой дүр зураг харагдаж байгаа юм. Тухайлбал, анх гудамжинд зогсож биеэ үнэлж байсан охид, эмэгтэйчүүдийн 90.2 хувь нь газраа өөрчлөөгүй байна. Харин 7.3 хувь нь зочид буудлаар явж, 2.4 хувь нь саунд биеэ үнэлдэг болжээ. Зочид буудлаар явж анх биеэ үнэлж байсан охидын 96.6 хувь нь одоо ч гэсэн зочид буудлаар л явж байгаа ба харин үлдсэн 3.4 хувь нь газраа сольж шөнийн цэнгээний газраар явдаг болсон байна. Шөнийн цэнгээний газраар явж биеэ үнэлэгчдийн хувьд 57.1 хувь нь газраа өөрчлөөгүй ба 21.4 хувь нь гудамжинд зогсож, 14.3 хувь нь зочид буудлаар, 7.1 хувь нь дуудлагаар явж биеэ үнэлдэг болжээ. Харин саун, зах, айл, гэртээ болон дуудлагаар явж биеэ үнэлдэг охид, эмэгтэйчүүдийн тоо цөөхөн байсан тул өөрчлөлтийн талаар тайлбар хийх боломжгүй байлаа.

Зураг 4.6-д анх болон одоогийн биеэ үнэлж байгаа газруудыг насны ялгавартай байдлаар харуулав. Зургаас харахад 16-17 насны охид, эмэгтэйчүүдийн хувьд гудамжинд зогсож биеэ үнэлэх явдал буурч, зочид буудал, саунаар явж биеэ үнэлэх байдал нэмэгдсэн байхад 18-21 насныхны хувьд зочид буудлаар, 22-25 насныхны хувьд гадаа гудамжаар явж биеэ үнэлэх байдал бага зэрэг нэмэгдсэн байна.

**Зураг 5.6 Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн биеэ үнэлдэг газар**



Харин 14-15 насны охидын хувьд ямар нэгэн өөрчлөлтгүй гараагүй байсан тул зурагт дүнг оруулсангүй. Тэдний 46.2 хувь нь гудамж, 46.2 хувь нь зочид буудал, 7.7 хувь нь шөнийн цэнгээний газраар явж анх биеэ үнэлж эхэлсэн бөгөөд одоо ч гэсэн энэ л газраараа явж байгаа ажээ.


Биеэ үнэлдэг газраа солих болсон гол шалтгаанд илүү мөнгө олох (42.9 хувь), цагдаагийн дарамт шахалт (21.4 хувь), илүү аюулгүй, боломжийн орчинд ажиллах (7.1 хувь), ямар ч шалтгаангүйгээр сольсон (28.6 хувь) зэрэг орж байна.

Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн ажлын ачааллыг долоо хоногт болон өдөрт дунджаар ажилладаг хугацаа, давхар ажил эрхлэлтийн байдал зэргээр харуулахыг зорилгоо.

Судалгаанд оролцогчид долоо хоногт дунджаар 4.3 өдөр ажиллаж байгаа ажээ. Тэдний 26.4 хувь нь долоо хоногийн дөрвөн өдөр, 18.7 хувь нь гурван өдөр, 17.6 хувь нь таван өдөр, 14.3 хувь нь 1-2 өдөр, 23.1 хувь нь 6-7 өдөр ажилладаг байна.

Насны бүлгээр харахад, 16-17 насны бүлгээс бусад бүх насны бүлэгт долоо хоногийн 3-4 өдөр ажилладаг охид, эмэгтэйчүүд зонхилох хувийг эзэлж байна. 16-17 насныхны хувьд долоо хоногийн 5-6 өдөр ажиллагчид талаас илүү нь байна. Харин 14-15 насныхны хувьд бусад насны бүлэгтэй харьцуулахад долоо хоногийн бүх өдрүүдэд ажилладаг охид олон байна.

**Зураг 5.7 Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн долоо хоногт ажилладаг дундаж өдөр**



Биеэ үнэлэгчид өдөрт дунджаар 7.5 цаг ажилладаг байна. Судалгаанд хамрагдсан охид, эмэгтэйчүүдийн 12.1 хувь нь 1-4 цаг, 56.1 хувь нь 5-8 цаг, 27.5 хувь нь 9-12 цаг, 4.4 хувь нь 14-18 цаг ажиллаж байна. Хамгийн багадаа 1, хамгийн ихдээ 18 цаг ажилладаг байна. Өдөрт ажиллаж буй дундаж цагийг насны бүлгээр харвал, 14-15 настай охидууд бусадтай харьцуулахад харьцангуй цөөхөн цаг ажилладаг байна. Тэдний 61.6 хувь нь өдөрт 4-6 цаг ажилладаг ажээ. Харин 16-17 насны охидын 72.3 хувь, 18-21 насныхны 58.9 хувь нь өдөрт 6-9 цаг, 22-25 настай эмэгтэйчүүдийн 61.4 хувь нь өдөрт 4-7 цаг ажиллаж байна.


Судалгаанд хамрагдагчдаас биеэ үнэлэхээс гадна өөр ажил давхар эрхэлдэг талаар тодруулахад 8.8 хувь нь эрхэлдэг гэж хариулсан бөгөөд эдгээр давхар ажил эрхэлдэг эмэгтэйчүүдийн тэн хагас нь энэ ажилдаа долоо хоногт дунджаар 15 хүртэл, дөрөвний нэг нь 20-40, мөн үлдсэн 25.0 хувь нь 60-77 цаг зарцуулдаг ажээ. Давхар эрхэлдэг ажилдаа дунджаар 30 цаг зарцуулдаг гэнэ. Давхар ажил эрхэлдэг нийт 8 охин байгаа ба тэдний дөрөв нь 22-25 насныхан байна.

### **Биеэ үнэлэх ажлын орлого, зарцуулалт**

Судалгаанд хамрагдсан охид, эмэгтэйчүүд биеэ үнэлснээр өдөрт дунджаар 20000 орчим төгрөг олдог байна. Хамгийн багадаа 3,000 төгрөг, ихдээ 120,000 төгрөгөөр (зөвхөн нэг эмэгтэй) өдөртөө биеэ үнэлдэг охид, эмэгтэйчүүд байдаг ажээ. Насны бүлгээр авч үзвэл, 14-15 настай охидын дундаж орлого 25,000 орчим, 16-17 насны охидынх 20,000 орчим, 18-21 насны охидынх 21,000 гаруй, 22-25 насны эмэгтэйчүүдийн өдрийн дундаж орлого 16,000 гаруй төгрөг байна.

Биеэ үнэлэгчдийн орлогын хэмжээг насны бүлгээр Зураг 5.8-д харууллаа. 14-15 настай охидын 60 гаруй хувь, 16-17 насны охидын 40 гаруй хувь нь өдөрт 5,000-15,000 төгрөгийн орлоготой байдаг бол 18-21 насны эмэгтэйчүүдийн бараг тал хувь нь өдөртөө 10,000-20,000 төгрөгийн орлого олдог ажээ.

**Зураг 5.8 Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн өдөрт олдог орлогын дундаж хэмжээ, төгрөгөөр**



Ерөнхийдөө, 14-21 насны охид, эмэгтэйчүүдийн 70-аас дээш хувь нь өдөрт 10,000 ба түүнээс дээш төгрөгийн орлоготой байхад 22-25 насны эмэгтэйчүүдийн дөнгөж 50

хүрэхгүй хувь нь л ийм орлоготой байж чаддаг байна. Өдөрт олдог орлогын хэмжээ ба биеэ үнэлж буй газар хоорондын хамаарлыг авч үзвэл зочид буудалд биеэ үнэлдэг охид, эмэгтэйчүүд бусад газруудаар биеэ үнэлэгчдээс 2.5 дахин илүү орлоготой байдаг ажээ. Тухайлбал, гудамж, шөнийн цэнгээний газар, саун, зах зэрэг бусад газруудад биеэ үнэлэгчдийн гуравны хоёр нь 20,000 төгрөгөөс бага өдрийн орлоготой байхад зочид буудлаар биеэ үнэлэгчдийн гуравны хоёр нь 20,000 төгрөгөөс дээш өдрийн орлоготой байдаг байна.

Орлогын төрлийг сонирхон үзэхэд нийт охид, эмэгтэйчүүдийн 94.5 хувь нь бэлэн мөнгөөр, үлдсэн 5.5 хувь (N=5) нь мөнгөн бус хэлбэрээр орлого олж авдаг байна. Эдгээр охидын 3 нь 14-15 настай, үлдсэн 2 нь 16-17 насны охидууд байна. Мөнгөн бус хэлбэрээр орлого авагчдын хувьд бүгдээрээ биеэ үнэлснийхээ төлөө зөвхөн хоол унд идэж уудаг ажээ.

Үйлчлүүлэгчдийн зүгээс биеэ үнэлэгчдэд нэмэлт мөнгө өгөх тохиолдол байдаг гэнэ. Нийт судалгаанд оролцогчдын 60 гаруй хувь нь үйлчлүүлэгчид хааяа илүү мөнгө өгдөг гэж хариулсан байна. Гэхдээ насны бүлгийн ялгавартай байдал энд ажиглагдаж байгаа юм. Жишээлбэл, 14-15 насны охидын 15.4 хувь нь үйлчлүүлэгчид тэдэнд илүү мөнгө хааяа өгдөг гэж хариулсан байхад 16 ба түүнээс дээш настай охидын 70 орчим хувь нь үйлчлүүлэгчид тэдэнд хааяа илүү мөнгө төлдөг гэжээ.

Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн дийлэнх нь (давхардсан хариултаар тооцов) олсон орлогоо өөрт хэрэгтэй эд зүйлс (76.9 хувь) болон хоол хүнс (63.7 хувь) худалдан авахад хэрэглэдэг байна. Мөн тодорхой хэсгийг гоо сайхан (31.9 хувь), гэр бүлийнхэн (30.8 хувь), эрүүл мэнд (23.1 хувь), байрны түрээс (22.0 хувь), зуучлагчийн татвар (20.9 хувь), өр зээлэндээ (14.3 хувь) зарцуулдаг бөгөөд өөрийнхөө төлөө буюу сурч боловсрох (4.4 хувь), ирээдүйдээ зориулж хадгаламж (4.4 хувь) бий болгоход өчүүхэн хэсгийг зарцуулж байгаа нь чамлалттай санагдлаа. Орлогын зарцуулалтыг насны бүлгээр Хүснэгт 5.2-т үзүүлэв.

**Хүснэгт 5.2 Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн орлогын зарцуулалт, насны бүлгээр**

Орлогын зарцуулалт	Охидын нас		Эмэгтэйчүүдийн нас		Нийт
	14-15	16-17	18-21	22-25	
Хоол хүнс	76.9	77.8	55.9	57.7	63.7
Өөрт хэрэгтэй зүйл	53.8	77.8	85.3	76.9	76.9
Хадгаламж	0.0	38.9	29.4	3.8	19.8
Зуучлагчид татвар	15.4	0.0	8.8	19.2	11.0
Байрны түрээс	7.7	22.2	32.4	15.4	22.0
Өр зээл төлөх	7.7	22.2	14.7	11.5	14.3
Гоо сайханд	7.7	16.7	26.5	26.9	22.0
Эрүүл мэндэд	7.7	33.3	44.1	19.2	29.6
Гэр бүлийнхэндээ	7.7	22.2	29.4	38.5	27.5
<b>Тоо</b>	<b>13</b>	<b>18</b>	<b>34</b>	<b>26</b>	<b>91</b>

Тэмдэглэл: Давхар хариултаас тооцсон тул хувийн жин 100-аас илүү байна.

14-15 настай охид бусад насны бүлгийнхэнтэй харьцуулахад хоол хүнс, өөртөө хэрэгтэй зүйл авах болон зуучлагчийн татварт орлогын ихэнх хэсгээ зарцуулдаг байна. Харин бусад насныхны хувьд өөрт хэрэгтэй эд зүйлс, хоол хүнс, гоо сайхандаа илүүтэй зарцуулахаас гадна гэр бүлийнхэндээ орлогын тодорхой хэсгээ зарцуулж байгаа нь харагдаж байна.

Орлогын зарцуулалтаас харахад охид, эмэгтэйчүүдийн зарим нь зуучлагч болон бусдад нэлээд өр зээл тавьжээ. Магадгүй энэ байдал нь тэднийг эдгээр хүмүүсийн эрхэнд байх нэг нөхцөл болдог байж болзошгүй юм. Нийт охид, эмэгтэйчүүдийн аравны нэгээс илүү хувь нь зуучлагч этгээддээ өртэй байгаа гэж хариулсан байна. Насны хувьд 14-15 настай охидын 23.1 хувь, 16-17 настай охидын 22.2 хувь нь зуучлагчдаа өртэй гэж хариулсан нь бусад насныхантай харьцуулахад өндөр байгаа

юм. Харин 18-25 насныхны хувьд зуучлагчдаа өртэй гэж хариулсан охид, эмэгтэйчүүд арав ч хүрэхгүй хувийг эзэлж байна.

Судалгаанд оролцогчдын 63.7 хувь нь биеэ үнэлсэн орлогоо үйлчлүүлэгчээс шууд өөрөө авдаг бол үлдсэн эмэгтэйчүүдийн хувьд зуучлагч нь авдаг байна. Насны бүлгийн хувьд авч үзвэл, 14-15 настай охидын 84.6 хувь нь зуучлагч төлбөрийг нь авдаг гэсэн хариулт өгчээ. Харин 16-17 насны охидын 44.4 хувь, 18-21 насныхны 29.4 хувь, 22-25 насны эмэгтэйчүүдийн 15.4 хувь нь ийм хариулт өгсөн байна. Байршлаар харвал, Улаанбаатараас судалгаанд хамрагдсан охид, эмэгтэйчүүдийн хувьд зуучлагчаар дамжуулж орлогоо авах тохиолдол байгаа ба бусад газруудын хувьд охид, эмэгтэйчүүд өөрсдөө шууд орлогоо үйлчлүүлэгчээс авдаг байна. Улаанбаатарын судалгаанд хамрагдсан бие үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн 55.0 хувь нь зуучлагчаар дамжуулж орлогоо авч байгаа ажээ. Эндээс биеэ үнэлэгч охидын нас бага байх, хот газар биеэ үнэлэх тохиолдолд зуучлагч нар орлогыг нь авах тохиолдол илүүтэй байгаа нь харагдаж байна. Магадгүй энэ нь зуучлагчид бага насны охидыг насанд хүрсэн охидтой харьцуулахад илүү өөрийн гарын дор байлгаж, тэдний биеийг үнэлүүлж мөнгө олж байдгийн нэг илрэл гэж хэлж болох юм.

#### **5.4 Зуучлагчид ба үйлчлүүлэгчдийн шинж байдал**

Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн тодорхой хэсэг нь зуучлагчаар дамжуулж биеэ үнэлэх ажилд оролцдог нь судалгааны үр дүнгийн эхний хэсгүүдэд өгүүлсэн билээ. Тэгвэл энд биеэ үнэлэгчдийг зуучлах ажил эрхэлдэг хүмүүсийн талаар дэлгэрэнгүй авч үзье.

##### ***Зуучлагчид***

Судалгаанд оролцогчдын 62.6 хувь нь зуучлагчтай ажээ. Судалгаанд хамрагдсан аймаг, хотын байдлаар авч үзвэл, Улаанбаатар, Замын-Үүд хотууд болон Дархан-Уул аймгийн биеэ үнэлэгчдийн хувьд зуучлагчтай байх нь Дорнод аймгийн эмэгтэйчүүдтэй харьцуулахад илүү байгаа нь харагдлаа. Зуучлагчтай эсэхийг насны бүлгийн ялгавартай байдлаар харвал, 14-15 насны бүх охидууд (N=13) зуучлагчтай ажээ. 16-17 насны охидын 61.1 хувь, 18-21 насныхны 58.8 хувь, 22-25 настай эмэгтэйчүүдийн тэн хагас нь зуучлагчаар дамжуулж үйлчлүүлэгч олж, биеэ үнэлдэг байна.

Хүйсийн хувьд зуучлагчдын 60 орчим хувь нь эмэгтэйчүүд байна. Дархан-Уул, Дорнод аймгийн биеэ үнэлэгчдийн зуучлагчид бүгд эрэгтэй байхад Улаанбаатар хотынхны хувьд талаас илүү нь эмэгтэйчүүд байна.

Зуучлагчдыг насны ангиллаар авч үзвэл, 40.4 хувь нь 30 ба түүнээс дээш настай, 29.8 хувь нь 25-аас бага, үлдсэн хэсэг нь 25-29 настай байна. Зуучлагчдаас хамгийн залуу нь 14 настай, хамгийн ахмад нь 40 настай хүн байгаа бөгөөд дундаж нас нь 26.7 байна. Улаанбаатар хотын биеэ үнэлэгчдийн зуучлагчдын дунд бусад аймгуудынхтай харьцуулахад 25 ба түүнээс доош насныхан их байна.

Зуучлагчдын зүгээс туслалцаа, дэмжлэг үзүүлдэг эсэхийг тодруулахад зуучлагчтай нийт эмэгтэйчүүдийн 15.8 хувь нь ямар нэг туслалцаа, дэмжлэг үзүүлдэггүй гэж хариулжээ. Харин үзүүлдэг гэж хариулсан эмэгтэйчүүдийн хувьд давхардсан тоогоор бараг тал хувь нь үнэгүй хоол унд өгдөг, 30 гаруй хувь нь тус бүрдээ шөнийн цагаар үнэгүй унаагаар үйлчилдэг болон аюулгүй байдлыг хангахад тусалдаг гэжээ. Мөн тавны нэг орчим нь үнэ төлбөргүй байраар хангах, гэртээ үнэгүй хонохыг зөвшөөрдөг бол 15 гаруй хувь нь үнэгүй хувцас, гоо сайхны бүтээгдэхүүн өгдөг гэнэ. Хүснэгт 5.3-т зуучлагчид нь дэмжлэг, туслалцаа үзүүлдэг охидын хувьд ямар туслалцаа, дэмжлэг авч байгааг харууллаа.

**Хүснэгт 5.3 Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн зуучлагчдын үзүүлж буй туслалцаа, насны бүлгээр**


Үйлчилгээнүүд	Охидын нас		Эмэгтэйчүүдийн нас		Нийт
	14-15	16-17	18-21	22-25	
Үнэгүй хоол өгдөг	46.1	72.7	20.0	38.5	40.3
Үнэгүй байраар хангадаг	46.1	18.2	5.0	23.1	21.0
Гэртээ үнэлгүй байлгах	46.1	36.4	15.0	15.4	26.3
Унаагаар үйлчилдэг	38.5	45.5	20.0	30.8	31.6
Аюулгүй байдал хангах	38.5	54.5	30.0	23.1	35.1
Хувцас, гоо сайхан	30.8	9.1	15.0	7.7	15.8
Сургалт	7.7	9.1	5.0	0.0	5.3
<b>Тоо</b>	<b>13</b>	<b>11</b>	<b>20</b>	<b>13</b>	<b>57</b>

Тэмдэглэл: Давхар хариултаас тооцсон тул хувийн жин 100-аас илүү байна.

Хүснэгтээс 14-17 насны, ялангуяа 14-15 насны охидын хувьд бусад насны бүлгийн охид, эмэгтэйчүүдтэй харьцуулахад зуучлагчийн зүгээс үнэгүй хоол ундаар хангах, үнэгүй байраар хангах явдал илүү байгаа нь харагдаж байна. Энэ байдал нь тэднийг зуучлагчдын гарын дор байх үндсэн нөхцөл болж байж ч болох талтай.

### Үйлчлүүлэгчид

Судалгаанд оролцсон биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн хувьд өдөрт дунджаар 3.4 үйлчлүүлэгчтэй байдаг. Тэдний 35.1 хувь нь 3-4, 30.8 хувь нь 1-2, үлдсэн 24.2 хувь нь 5 ба түүнээс дээш хүнд үйлчилдэг байна. Үйлчлүүлэгчдийн дундаж нас 33.3 бөгөөд хамгийн залуу нь 14-төй, хамгийн ахмад нь 60 настай хүмүүс байна. Зураг 5.9-д биеэ үнэлэгчдийн өдрийн дундаж үйлчлүүлэгчдийн тоог биеэ үнэлэгчдийн насны бүлгээр харууллаа.



Зургаас харахад 14-15 настай охид өдөрт 5 ба түүнээс дээш хүнд үйлчлэх явдал бусад насныхантай харьцуулахад ялимгүй өндөр байна.

Биеэ үнэлэгчдийн хувьд байнгын үйлчлүүлэгчид олон байдаг байна. Тухайлбал, судалгаанд хамрагдагчдын бараг 60 орчим хувь нь үйлчлүүлэгчдийн зарим нь байнга, 3.3 хувь нь ихэнх үйлчлүүлэгчид байнгынх байдаг гэж хариулсан байна. Харин 26.4 хувь нь үйлчлүүлэгчдийн хэн нь ч

байнгын хүн байдаггүй гэж хариулсан байхад 11.0 хувь нь хэн гэдгийг мэддэггүй эсвэл сонирхдоггүй ажээ. Насны бүлгийн хувьд 16-25 насны охид, эмэгтэйчүүдийн талаас илүү хувь нь үйлчлүүлэгчдийн зарим нь байнга үйлчлүүлдэг хүн байдаг гэдэг хариултыг өгчээ.

Судалгаанд хамрагдсан биеэ үнэлэгчдийн 62.6 хувийг гадаадын үйлчлүүлэгчид авч байжээ. Улаанбаатараас судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 58.3 хувь, Дархан-Уул аймгийн 80.0 хувь, Дорнод аймгийн 65.0 хувь нь гадаадын иргэн үйлчлүүлэгчтэй байсан байна. Харин насны ангиллаар авч үзвэл, 14-15 настай охидын 7.7 хувийг гадаадын иргэд авч байсан байна. Гэтэл 16-17 насны охидын 50.0



хувь, 18-21 насныхны 82.4 хувь, 22-25 насны эмэгтэйчүүдийн 73.1 хувь нь гадаадын иргэдэд үйлчилж байсан ажээ.

Биеэ үнэлэгчдээр үйлчлүүлэгчдийг үндэстний ялгаатай байдлаар харвал, давхардсан тоогоор 97.8 хувь нь монголчууд, 60 орчим хувь нь хятадууд, бараг 30 хувь нь солонгосчууд, 26.1 хувь нь оросууд байна. Мөн япончууд 7.6 хувь, германчууд 7.6 хувь, америкчууд 10.9 хувийг эзэлж байна.

Үйлчлүүлэгчид биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдтэй зөвхөн бэлгийн харьцаанд орохоос гадна ямар нэг өөр санал тавьдаг эсэхийг асуухад бараг тал хувь нь бэлгийн харьцаанаас өөр зүйл шаарддаггүй гэсэн бол тавны нэг нь болзоонд урих, 14.3 хувь нь Монголд өөр ажил эрхлэх, 9.9 хувь нь гадаадад ажиллах санал тавьдаг байна. Мөн үйлчлүүлэгчдийн хувьд эдгээр охид, эмэгтэйчүүдэд хайртай болох, гэрлэх санал тавих, санхүүгийн туслалцаа үзүүлэх зэрэг тохиолдол ч цөөнгүй байдаг ажээ. Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн насны ангиллаар дээрх үзүүлэлтийг сонирхвол, 14-15 настай охид бүгдээрээ бэлгийн харьцаанаас өөр санал хүлээн авч байгаагүй байхад 16-17 насны охидын 55.6 хувь, 18-21 насныхны 61.8 хувь, 22-25 насны эмэгтэйчүүдийн 76.9 хувь нь үйлчлүүлэгчдийн зүгээс бэлгийн харьцаанаас өөр ямар нэгэн санал тавьж байсан гэж хариулжээ.

### **5.5 Биеэ үнэлэгчдийн эрүүл мэнд ба ДОХ/БЗХӨ-ний талаарх мэдлэг, хандлага**

Биеэ үнэлэгчид нь ДОХ/БЗХӨ тусах болон эрүүл мэндийн эрсдэлт байдалд орох магадлал өндөртэй бүлэгт тооцогддог. Тэдний хувьд өөрийн эрүүл мэнддээ эрсдэлтэй алхмуудыг байнга хийж байдаг бөгөөд энэхүү байдлаас хэрхэн сэргийлж, хамгаалж байдаг талаар судалж үзэх зайлшгүй чухал юм. Иймд судалгаанд хамрагдсан охид, эмэгтэйчүүдийн хувьд эрхэлж буй үйл ажиллагаатай нь холбоотойгоор эрүүл мэндийн бэрхшээл, хүндрэлүүд тохиолдож байсан эсэх болон энэ тохиолдолд хэнд хандаж, хэрхэн яаж тусламж, дэмжлэг авч чадаж байгаа, ДОХ/БЗХӨ-ний талаар үнэн зөв ойлголт, хандлагатай байгаа тухай судалж үзлээ.

#### ***Биеэ үнэлэгчдийн эрүүл мэндийн байдал***

Биеэ үнэлж байхдаа эрүүл мэндийн хүндрэл, бэрхшээлд орж байсан гэж судалгаанд оролцогчдын 47.3 хувь нь хариулжээ. Насны ангиллаар харвал нэлээд ялгаатай дүр төрх ажиглагдаж байна. Тухайлбал, 14-15 настай охидын 69.2 хувь, 16-17 насныхны 72.2 хувь нь эрүүл мэндийн хүндрэлд орж байсан нь бусад 2 насны бүлгийн эмэгтэйчүүдийнхээс бараг 2 дахин илүү байна. 22-25 насны бүлгийнхний 34.6 хувь нь эрүүл мэндийн бэрхшээлтэй тохиолдож байжээ. Эндээс харахад бага насны биеэ үнэлэгчдийн хувьд эрүүл мэндийн эрсдэлтэй байдал илүү их тохиолддог болох нь харагдаж байна.

Эрүүл мэндийн хүндрэл гарсан тохиолдолд тэдний 39.5 хувь нь эмийн сангаас эм, тариа авч хэрэглэсэн, 41.9 хувь нь эмч, эмнэлэгт очсон, үлдсэн хэсэг нь найз нөхөд, хамаатан садан, танилдаа хандсан байна. Энэхүү байдлыг насны бүлгээр авч үзвэл, 14-15 настай охидын (66.7 хувь) хувьд эмийн сангаас эм тариа аван өөрийгөө эмчлэх явдал бусад насны бүлгийнхэнтэй (22.2-43.8 хувь) харьцуулахад 2-3 дахин илүү байна. Эндээс харахад биеэ үнэлэгчдийн хувьд өөрөө өөрийгөө эмчлэх явдал түгээмэл байна гэж хэлж болох юм. Өөрөөр хэлбэл, эмч, эмнэлэгт очихоос илүүтэйгээр өөрийгөө дур мэдэн эмчлэх нь тэдний эрүүл мэндэд эрсдэлийг бий болгож байгаа хэрэг билээ.


Эрүүл мэндийн хүндрэл, бэрхшээл тохиолдож байсан гэж хариулсан охид, эмэгтэйчүүдээс ямар хүндрэл тохиолдож байсныг тодруулахад, давхардсан дүнгээр 14-15 насны охидын 88.9 хувь нь БЗХӨ, 77.8 хувь нь бөөр, шээсний замын өвчин тусаж байжээ. 16-17 насны охидын хувьд БЗХӨ тусаж байсан гэж 84.6 хувь, арьсны өвчин туссан 38.5 хувь, амьсгалын замын өвчин тусаж байсан гэж хариулсан охид 30.8 хувь байгаа нь бусад өвчин, хүндрэлүүдээс хамгийн өндөр нь байна. Мөн 22-25

насны эмэгтэйчүүдийн хувьд БЗХӨ (66.6 хувь) болон бөөр шээсний замын өвчин (55.5 хувь) тусаж байсан эмэгтэйчүүд өндөр хувийг эзэлж байна. 18-21 насны охидын хувьд БЗХӨ (66.7 хувь), мэдрэлийн ядаргаа (33.3 хувь) болон бөөр, шээсний замын өвчин (33.3 хувь) тусах явдал их байна.

Судалгаанд хамрагдагчдын 22.0 хувь нь үр хөндүүлж байжээ. Үр хөндөлтийн давтамж дунджаар 2 байгаа бөгөөд тэдний 55.0 хувь нь нэг, 25.0 хувь нь гурав, 15.0 хувь нь хоёр, үлдсэн 5.0 хувь нь таван удаа үр хөндүүлсэн байна. Үр хөндүүлэгчид бүгд 16 ба түүнээс дээш настай охид, эмэгтэйчүүд байна. Үр хөндүүлж байсан 18-21 настай эмэгтэйчүүд бүгдээрээ нэг удаа үр хөндүүлж байжээ. Харин үр хөндүүлсэн 16-17 настай охидын (N=4) гурав нь гурван удаа, нэг охин хоёр удаа үр хөндүүлж байсан бол үр хөндүүлсэн 22-25 настай эмэгтэйчүүдийн (N=10) тэн хагас нь нэг удаа, 10.0 хувь нь таван удаа үр хөндүүлжээ.

Биеэ үнэлэгчдээс бэлгэвч гэх мэт хамгаалах хэрэгсэл бэлгийн харьцаанд орохдоо хэрэглэдэг эсэхийг сонирхоход 40 гаруй хувь нь үргэлж, гуравны нэг нь заримдаа, тавны нэг орчим нь ихэнх тохиолдолд, үлдсэн хэсэг нь ердөө хэрэглэдэггүй гэж хариулжээ. 14-15 настай охидын 38.5 хувь, 16-17 насныхны 16.7 хувь нь хэзээ ч бэлгэвч хэрэглэж байгаагүй гэнэ. Харин бусад насныхны хувьд хэрэглэдэггүй эмэгтэйчүүдийн хувь харьцангуй бага буюу ердөө тав ч хүрэхгүй хувийг эзэлж байна. 18-25 настай эмэгтэйчүүдийн хувьд бэлгэвч хэрэглэх явдал бусад насны бүлгийнхэнтэй харьцуулахад өндөр байна. Тухайлбал, 22-25 насны бүлгийн эмэгтэйчүүдийн бараг 70 хувь, 18-21 насныхны талаас илүү хувь нь байнга бэлгэвч хэрэглэдэг байна.

**Зураг 5.10 Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн БЗХӨ тусаж байсан эсэх**



Судалгаанд оролцогчдын 41.8 хувь нь БЗХӨ тусаж байжээ. Э. БЗХӨ тусаж байсан эсэхийг насны ялгаатай

байдлаар Зураг 5.10-т харуулав. 14-15 насны бүлгийн охидын хувьд БЗХӨ тусаж байсан тохиолдол бусад насны бүлгийнхэнтэй харьцуулахад өндөр байна. Судалгааны энэхүү дүн өмнө нь эрүүл мэндийн хүндрэл тохиолдож байсан охид, эмэгтэйчүүдийн хувьд ямар хүндрэл байсныг тодруулсан дүнтэй харьцуулахад дүйцэж байгаа юм. Өөрөөр хэлбэл, эрүүл мэндийн хүндрэл гарч байсан охид, эмэгтэйчүүдийн мөн дийлэнх нь 14-15 насны охидууд байсан билээ. 14-15 насны охидын хувьд БЗХӨ өндөр байгаа нь бэлгэвч хэрэглэх явдал бусад насны бүлгийнхэнтэй харьцуулахад бага байсантай холбоотой байж магадгүй.

БЗХӨ тусаж байсан охид, эмэгтэйчүүдийн 84.2 хувь нь эмчилгээ хийлгэсэн байна. Насны бүлгээр авч үзвэл, 14-15 настай охидын бараг 40 хувь, 16-17 насныхны 21.4 хувь нь эмчилгээ хийлгээгүй байна. Харин 18-25 насны БЗХӨ өвчин тусаж байсан эмэгтэйчүүд бүгдээрээ 100 хувь эмчлүүлсэн байна. БЗХӨ туссан мөртлөө эмчилгээ

хийлгээгүй охид, эмэгтэйчүүд байгаа нь тэдний хувьд ДОХ-ын халдвар авах болон эрүүл мэндийн ямарваа нэг хүндрэл бий болох нөхцлийг бүрдүүлж байгаа хэрэг юм.

### **ДОХ/БЗХӨ-ний талаарх мэдлэг, хандлага**

Биеэ үнэлэгчдийн хувьд ДОХ/БЗХӨ-ний талаар үнэн зөв мэдээлэлтэй байж, урьдчилан сэргийлэх, хамгаалах арга замыг мэддэг байх нь зайлшгүй чухал. Судалгаанд хамрагдагчдын 93.4 хувь нь БЗХӨ-ний талаар сонссон байгаа ба тэдний 87.2 хувь нь бэлгийн хавьталд ороход энэхүү өвчний халдвар авдаг гэсэн зөв ойлголттой байна. Гэтэл зарим охид, эмэгтэйчүүдийн хувьд зүү тариур, эмнэлгийн хэрэгслээр, үнсэлцэх зэргээс халдвар авч болзошгүй гэсэн ойлголттой байна. БЗХӨ-ний талаарх мэдээллийг зурагт (30.6 хувь), сонин сэтгүүл (17.6 хувь), найз нөхөд хамаатан (16.5 хувь), эрүүл мэндийн ажилтнуудаас (15.3 хувь) мэдэж авах тохиолдол хамгийн өндөр байна. Бусад мэдээллийн эх үүсвэрийн хувьд арав ч хүрэхгүй хувийг эзэлж байна. Мэдээлэл авдаг эх үүсвэрийг насны ангиллаар авч үзвэл, 14-15 насны охидын бараг 60 хувь нь найз, нөхөд, хамаатан саднаасаа мэдэж авсан гэж хариулсан бол 16-25 насны охид, эмэгтэйчүүдийн ихэнх хувь нь зурагтаас мэдээлэл олж авдаг байна.

БЗХӨ өвчин туссан үед илрэх шинж тэмдгийн талаар 74.1 хувь нь ямар шинж тэмдэг илэрдгийг мэднэ гэж хариулжээ. Бүх насны бүлгийн охидын дөрөвний нэг нь ямар шинж тэмдэг илэрдгийг мэдэхгүй байна. Мөн нийт охид, эмэгтэйчүүдээс БЗХӨ-нөөс сэргийлэх болон туссан тохиолдолд хамгийн түрүүн юу хийх ёстойг тодруулахад 94.1 хувь нь сэргийлж болох бөгөөд бэлгэвч хэрэглэснээр (нийт охид, эмэгтэйчүүдийн 86.3 хувь) найдвартай хамгаалах болно гэж үзэж байна.

Судалгаанд оролцогч охид, эмэгтэйчүүдийн 93.4 хувь нь ДОХ-ын талаар сонссон бөгөөд энэ талын мэдээллийг авдаг гол эх үүсвэр нь зурагт, сонин сэтгүүл, эрүүл мэндийн ажилтнууд гэж хариулжээ. Нийт охид, эмэгтэйчүүдийн 85.9 хувь нь ДОХ үүсгэгчээс сэргийлэх боломжтой гэж бодож байгаа ба эдгээр эмэгтэйчүүдийн 91.8 хувь нь бэлгэвч хэрэглэснээр, 6.8 хувь нь бэлгийн харьцааг тэвчснээр, 1.4 хувь нь зөвхөн нэг бэлгийн хавьтагчтай байснаар хамгаалж чадна гэж үзэж байна. Насны ялгаатай байдлаар онцын хэлбэлзэл ажиглагдсангүй.

Судалгаанд хамрагдсан биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн гуравны нэг нь хэзээ ч ДОХ/БЗХӨ-ний шинжилгээнд хамрагдаж байгаагүй, 41.8 хувь нь 1-3 сарын өмнө, 13.2 хувь нь 3-6 сарын өмнө, 7.7 хувь нь 6-12 сарын өмнө, үлдсэн хэсэг нь нэг ба түүнээс дээш жилийн өмнө шинжилгээ хийлгэж байжээ. Насны ялгаатай байдлаар харвал, 14-15 настай охидын хувьд шинжилгээнд орох явдал маш хангалтгүй байгаа нь харагдлаа. Нийт 14-15 настай охидын 76.9 хувь нь ерөөсөө шинжилгээнд орж байгаагүй ажээ. 16-17 настай охидын 50.0 хувь нь мөн л ердөө орж байгаагүй байна. Ерөнхийдөө, биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн хувьд шинжилгээнд хамрагдах явдал хангалтгүй байна хэлж болно. Биеэ үнэлэгчид нь бэлгийн олон хавьтагчтай, бэлгийн харьцааны давтамж өндөртэй, эрүүл мэндийн эрсдэлтэй бүлгийн хувьд тогтмол шинжилгээнд орж байх нь чухал юм.

### **5.6 Биеэ үнэлэгчдэд тохиолдож буй хүндрэл, бэрхшээлүүд**

Биеэ үнэлэгчид нь өөрсдийн зуучлагч болон үйлчлүүлэгчидтэй зөрчилдөж, тэдний дарамт шахалтад орох явдал цөөнгүй байдаг ажээ. Судалгаанд оролцогчдын хувьд 42.9 хувь нь үйлчлүүлэгчийн зүгээс заримдаа, 35.2 хувь нь хааяа дарамт шахалт үзүүлдэг гэж хариулсан байна. Хааяа (42.9 хувь) болон үргэлж (11.0 хувь) гэсэн хоёр тохиолдлыг нийлүүлэн ерөнхийд нь авч үзвэл үйлчлүүлэгчийн зүгээс дарамт үзүүлэх явдал их байна гэж хэлж болно.

Зуучлагчдын хувьд үйлчлүүлэгчтэй харьцуулахад дарамт үзүүлэх байдал бага байдаг аж. Зуучлагч нь дарамт шахалт үзүүлдэггүй гэж 42.1 хувь нь хариулсан байхад үйлчлүүлэгч дарамт үзүүлдэггүй гэж 11-хэн хувь нь үзэж байна. 14-15 настай охидын

хувьд зуучлагчийн зүгээс дарамт үзүүлдэггүй гэж хариулсан охин алга байна. 14-15 настай охидын гуравны нэг нь зуучлагчийн зүгээс байнгын дарамттай байдаг гэж хариулжээ. Харин бусад насныхны хувьд байнгын гэсэн хариулт байхгүй ч заримдаа болон хааяа гэсэн хариултууд дийлэнх хувийг (30.8-66.7 хувь) нь эзэлж байна.

Судалгаанд хамрагдсан 14-15 насны 13 охин байгаагийн тал хувь нь хааяа үйлчлүүлэгчийн зүгээс дарамт үзүүлдэг гэсэн байна. Эдгээр охидын хувьд үйлчлүүлэгч дарамталж байгаагүй тохиолдол байхгүй байна. Харин 16-17, 18-21, 22-25 насныхны хувьд үйлчлүүлэгчийн зүгээс дарамталж байгаагүй гэдэг хариултыг өгсөн байдал харгалзан 11.1, 14.7, 11.5 хувь байна. 16-17 насныхны 44.4 хувь, 18-21 насныхны 50 орчим хувь нь үйлчлүүлэгчийн зүгээс заримдаа дарамт үзүүлдэг гэсэн хариултыг өгсөн бол 22-25 насныхны 40 гаруй хувь нь энэ хариултыг өгсөн байна.

Үйлчлүүлэгч болон зуучлагчдын зүгээс үзүүлдэг дарамт шахалтыг Хүснэгт 5.4, Хүснэгт 5.5-д үзүүлээ. Энэхүү үзүүлэлтийг үйлчлүүлэгч, зуучлагчдын зүгээс ямар нэг дарамт шахалт үзүүлдэг охид, эмэгтэйчүүдийн хувьд авч үзсэн болно.

**Хүснэгт 5.4 Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн үйлчлүүлэгчдийн зүгээс үзүүлдэг дарамт, шахалт, насны бүлгээр**

Дарамт шахалт	Охидын нас		Эмэгтэйчүүдийн нас		Нийт
	14-15	16-17	18-21	22-25	
Хэл амаар доромжилдог	69.2	100.0	79.3	95.6	86.4
Хүчинддэг	69.2	56.3	72.4	65.2	66.7
Зоддог	61.5	31.3	27.6	26.1	33.3
Дээрэмддэг	38.5	18.8	13.8	8.7	17.3
Бага мөнгө төлдөг	23.1	50.0	37.9	52.2	42.0
Ёс бус, гаж зүйл шаарддаг	7.7	25.0	6.9	4.8	10.0
<b>Тоо</b>	<b>13</b>	<b>16</b>	<b>29</b>	<b>23</b>	<b>81</b>

Бүх насны охидын хувьд үйлчлүүлэгчдийн зүгээс хэл амаар доромжлох явдал илүү түгээмэл байдаг ажээ. Үүний дараагаар охид, эмэгтэйчүүдийг хүчирхийлэх явдал орж байна. 14-15 настай охидын хувьд үйлчлүүлэгчдийн зүгээс хэл амаар доромжлуулах, зодуулах, хүчиндүүлэх явдал өндөр байхад бусад охид, эмэгтэйчүүдийн хувьд хэл амаар доромжлуулах, хүчиндүүлэх, төлбөрөө бага авах явдал элбэг байна.

Зуучлагчдын зүгээс охидыг хэл амаар доромжлох, айлган сүрдүүлэх, багахан хэмжээний ажлын хөлс өгөх, өрөө төлөхийг шаардах зэрэг дарамт шахалтыг байнга үзүүлдэг ажээ. Бусад насны бүлэгтэй харьцуулахад 14-15 насны охидуудыг зуучлагчид нь бусдад худалдах явдал илүү түгээмэл байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна.

**Хүснэгт 5.5 Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн зуучлагчдын зүгээс үзүүлдэг дарамт, шахалт, насны бүлгээр**

Зуучлагчдын зүгээс үзүүлдэг дарамт шахалт	Охидын нас		Эмэгтэйчүүдийн нас		Нийт
	14-15	16-17	18-21	22-25	
Айлган сүрдүүлдэг	76.9	66.7	66.7	75.0	72.0
Хэл амаар доромжилдог	69.2	88.9	33.3	80.0	69.7
Худалдах	53.8	22.2	16.7	25.0	34.1
Бага цалин өгдөг	46.2	44.4	33.3	50.0	43.9
Зоддог	23.1	22.2	0.0	25.0	18.9
Өрөө төлөхийг шаарддаг	23.1	22.2	0.0	50.0	22.7

Тэмдэглэл: Давхар хариултаас тооцсон тул хувийн жин 100-аас илүү байна.

Ерөнхийд нь дүгнэвэл, үйлчлүүлэгчдийн хувьд хэл амаар доромжлох, хүчиндэх, бага мөнгө төлөх, зодох зэрэг үйлдлүүд түгээмэл байдаг бол зуучлагчдын хувьд хэл амаар доромжлох, айлган сүрдүүлэх, бага цалин олгох, худалдах, өрөө төлөхийг шаардах зэрэг дарамтыг илүү үзүүлдэг байна.

Ямар нэгэн дарамт шахалттай тохиолдолд судалгаанд оролцогчдын гуравны нэг нь найз нөхөддөө, 26.4 хувь нь зуучлагчдаа, 15.4 хувь нь цагдаад хандаж байжээ. Мөн эцэг эх, ах эгч дүү болон хамтран ажиллагсаддаа хандах явдал цөөнгүй байдаг ажээ.

Судалгаанд хамрагдагчдын 71.4 хувь нь цагдаад баригдаж байжээ. Тэдний цагдаад баригдаж байсан гол шалтгаан нь биеэ үнэлэх явдал гэнэ. Цагдаад баригдаж байсан эмэгтэйчүүдийн 92.3 хувь нь биеэ үнэлснээс болж баригдсан байна. Хамгийн багадаа нэг, хамгийн ихдээ 30 удаа цагдаад баригдаж байжээ. Хоёр удаа цагдаад баригдаж байсан охид, эмэгтэйчүүдийн эзлэх хувь (32.3 хувь) бусадтай нь харьцуулахад харьцангуй өндөр байна. Бусдынх нь хувьд арав ч хүрэхгүй хувьтай байна. Цагдаад баригдсан тохиолдолд 96.9 хувь нь захиргааны арга хэмжээгээр (мөнгөн торгууль төлөх гэх мэт) шийтгүүлсэн байна.


### 5.7 Биеэ үнэлэгчид ирээдүйнхээ талаар

Биеэ үнэлэх явдал нь гэмт хэрэгт тооцогддог бөгөөд хүн бүр л биеэ үнэлэгчдийг жигшин зэвүүцэж байдгийг хэн хүнгүй мэдэх билээ. Тэгвэл судалгаанд хамрагдсан биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн хувьд биеэ үнэлж буй байдлаа хэрхэн үзэж байгаа болон цаашдаа энэ л замаараа явах эсэхийг тодруулж, ирээдүйгээ хэрхэн төсөөлж, юуг хүсч, мөрөөдөж байдаг талаар тэдэнтэй ярилцсан юм.

Нийт судалгаанд оролцсон охид, эмэгтэйчүүдийн гуравны нэг нь цаашид биеэ үнэлэх ажлаа үргэлжлүүлэн хийх бодолтой байгаа гэнэ. Гэхдээ ийнхүү үргэлжлүүлэх бодолтой байгаа эмэгтэйчүүдийн 60.7 хувь нь хэр удаан үргэлжлүүлэн ажиллахаа сайн тодорхой хэлж мэдэхгүй байгаа ажээ. Харин 25.0 хувь нь нэг жил орчим, 14.4 хувь нь нэг хүрэхгүй жилийн хугацаанд ажиллаж байгаад болихоор зэхэж байгаа гэнэ. Биеэ үнэлэх ажлаа цаашид үргэлжлүүлэн хийх бодолтой байгаа эсэхийг насны ангиллаар нь авч үзвэл, 14-15 насны охидын 53.8 хувь нь цаашид үргэлжлүүлэн хийх бодолтой байгаа гэж хариулсан байхад бусад насны бүлгийн охид, эмэгтэйчүүдийн дийлэнх нь буюу 16-17 насны охидын 61.1 хувь, 18-21 насныхны 79.4 хувь, 22-25 насны эмэгтэйчүүдийн 73.1 хувь нь цаашид үргэлжлүүлэх бодолгүй байгаа ажээ.

Судалгаанд оролцсон охид, эмэгтэйчүүдээс гадаадад үйлчилгээний салбарт ажиллах хүсэлтэй байгаа болон хэрэв гадаадад ажиллах санал ирвэл хүлээн авах эсэхийг тодруулахад олонх нь

Зураг 5.11 Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн гадаадад ажиллах талаарх хүсэл бодол



гадаадад ажиллах хүсэлтэй бөгөөд ийм санал тавибал дуртайяа хүлээн авах ажээ (Зураг 5.11). Зургаас харахад, 14-15 насны охидын хувьд гадаадад явж ажиллах хүсэл эрмэлзэл бусад насны бүлгийнхэнтэй харьцуулахад харьцангуй өндөр байна.

Гадаадад ажиллах сонирхолтой, санал тавибал хүлээн авна гэж хариулсан охид, эмэгтэйчүүдээс ажлын ямар төрлийг илүү эрхэмлэж байгааг сонирхоход 64.2 хувь нь ямар ч хамаагүй ажил хийнэ гэсэн хариултыг өгчээ. Үүний дараа шөнийн цэнгээний газар, саунд үйлчлэгч, зөөгч (9.4 хувь), ресторанд зөөгч (7.5 хувь), зочид буудалд цэвэрлэгч (5.7 хувь), баар, шөнийн цэнгээний газарт бүжигчин (3.8 хувь) хийх зэрэг орж байна. Мөн массажист, биеэ үнэлэх, гэрийн үйлчлэгч, загвар өмсөгч, эмч зэрэг ажил хийх хүсэлтэй охид, эмэгтэйчүүд байгаа ч тэд дөнгөж хоёрхон хувийг эзэлж байгаа юм.

Гадаадын ямар улс оронд явах сонирхолтой байгааг асуухад 62.3 хувь нь Азийн аль нэг улс оронд, гуравны нэг нь Европын орнууд руу, үлдэх 7.5 хувь нь аль ч улс руу хамаагүй явна гэсэн бодолтой байна.


Судалгаанд оролцсон биеэ үнэлэгч нийт охид, эмэгтэйчүүдийн цаашдын зорилгын талаарх мэдээллийг Зураг 5.12-д үзүүлээ. Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн дийлэнх нь сурч боловсрон, мэргэжлийн ур чадвар эзэмших, өөрийн хүссэн ажлаа эрхлэх, өөрийн гэсэн амьдрал ахуйтай болж, үр хүүхэдтэй, сайхан амьдрах зэрэг өөдрөг хүсэл эрмэлзэлтэй байгаа ажээ. Гэвч заримынх нь хувьд ямар ч аргаар хамаагүй мөнгөтэй болох, цаашдаа яахаа мэдэхгүй байгаа нь тэдний ирээдүй бүрхэг, ямар ч төсөөлөлгүйг илтгэж байна.

Биеэ үнэлэгчдийн цаашдын зорилгыг насны ангиллаар харахад онцын ялгаатай байдал ажиглагдахгүй байна.

Гадаад, дотоодын төрийн бус байгууллагууд биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүд болон аль нэг эрсдлийн бүлгийнхэнтэй хамтран

ажиллаж, эдгээр охид, эмэгтэйчүүдийг буруу замаас татан гаргах, тэдний эрх ашгийг хамгаалах, тусалж дэмжих зэрэг олон тал дээр хамтран ажилладаг билээ.

Зураг 5.12 Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн ирээдүйн хүсэл эрмэлзэл



Судалгаанд оролцсон охид, эмэгтэйчүүд өөр ажил төрөл олж хийх, биеэ үнэлэхээ болих, одоогийн нөхцөл байдлаа өөрчлөх зорилгоор ямар нэгэн төрийн бус байгууллагад хандаж байсан эсэхийг тодруулбал, 12.1 хувь нь ямар нэг төрийн бус байгууллагад хандаж байжээ. Эдгээр охид, эмэгтэйчүүд бүгд тухайн төрийн бус байгууллагаас зохион байгуулсан сургалтууд хамрагдаж байсан бөгөөд нэг эмэгтэй нийтдээ таван удаа сургалтад хамрагдсан нь хамгийн олонд тооцогдож байна. 18.2 хувь нь нэг удаа, бусад нь 2-4 удаа сургалтад хамрагдсан байна.

## 5.8 Биеэ үнэлэгчдийн хүн худалдах гэмт хэргийн талаарх ойлголт, хандлага

Монголд хил давуулан хүн худалдаалах гэмт хэргийн талаарх асуудал сүүлийн жилүүдэд нэлээд эрчимтэй яригдаж байгаа бөгөөд энэ талаар зарим нэг судалгаа хийгдсэн байдаг. Судалгааны дүнгээс харахад хүн худалдах гэмт хэргийн золиос, хохирогч бологчдын дийлэнх хувийг биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүд эзэлж байгаа ба тэднийг хүн худалдах гэмт хэрэгт өртөх хамгийн өндөр магадлалтай бүлэгт хамруулдаг байна. Гэтэл биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүд маань энэ талаарх


мэдээлэл хомс, ойлголтгүй, эсвэл ар гэрийн амьдралын хүнд нөхцөл, санхүүгийн бэрхшээлт байдлаасаа шалтгаалан өөрөө ч мэдэлгүй энэхүү гэмт хэргийн хохирогч болох явдал байсаар байна.

Судалгаанд хамрагдсан нийт биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн 65.9 хувь нь хүн худалдах гэмт хэргийн талаар урьд өмнө нь сонссон ажээ. Мөн нийт охид, эмэгтэйчүүдийн 56.0 хувь нь биеэ үнэлэгчид бол ийм гэмт хэрэгт өртөх эрсдэл ихтэй хүмүүс гэж үзэж байна. Яагаад биеэ үнэлэгчид хүн худалдах гэмт хэрэгт өртөх эрсдэл ихтэй байдаг талаар тодруулбал, бараг тал хувь нь гадаад, дотоодын олон хүнтэй харьцаж, их мөнгө амалсан, янз бүрийн ажлын санал ихтэй байдгаараа биеэ үнэлэгчид эрсдэлтэй хүмүүст тооцогдох ёстой гэж бодож байна.

Мөн зарим охидын хувьд үйлчилгээний салбарт ажиллах нь угаас эрсдэл ихтэй (9.8 хувь), өмнө нь ийм зүйл ойр дотны хэн нэгэнд нь тохиолдож байсан (9.8 хувь), найз нөхөд, хэвлэл мэдээллээс энэ талаар мэдсэн (7.8 хувь), тэдний биеэ үнэлж буй байдлыг ашиглан, хууран мэхлэх явдал (15.7 хувь) их байдаг зэрэг нь биеэ үнэлэгчдийн хүн худалдах гэмт хэргийн хохирогч болох магадлалыг нэмэгдүүлдэг гэж үзэж байгаа аж.

Харин нийт эмэгтэйчүүдийн 7.8 хувь нь биеэ үнэлэгчид ямар ч байсан эрсдэлтэй, гэхдээ яагаад гэдэгт хариулт өгч, сайн тайлбарлаж чадахгүй байлаа. Нийт судалгаанд оролцогчдын 27.5 хувь нь худалдаалагдсан охид, эмэгтэйчүүдийн тухай мэддэг (Зураг 5.13) бөгөөд энэ талаар бусад биеэ үнэлэгчдээс болон зуучлагчаасаа мэдсэн, мөн тухайн худалдаалагдсан эмэгтэй өөрийнх нь найз нөхөд байсан тухай ярьж байсан.

Зураг 5.13 Биеэ үнэлэгчдийн худалдаалагдсан охид, эмэгтэйчүүдийн тухай мэддэг эсэх, мэдсэн эх үүсвэрээр



Эдгээр охид, эмэгтэйчүүдийг хаашаа худалдаалсан тухай мэддэг эсэхийг асуухад 64.0 хувь нь Хятад, 4.0 хувь нь Солонгос, 4.0 хувь нь Монголдоо худалдаалагдсан гэж хариулсан. Харин 28.0 хувь нь мэдэхгүй гэдэг хариултыг өгсөн байна. Тэдний сонссоноор эдгээр худалдаалагдсан охидын 60.0 хувийг монгол, 12.0 хувийг гадаадын зуучлагчид худалдсан ажээ. Мөн ойр дотны найз нөхөд, хамаатан болон найзууд нь худалддаг байна. Худалдаалагдсан охид, эмэгтэйчүүдийг одоогоор хаана байгааг нь мэддэг эсэхийг асуухад охидын 28.0 хувь нь Монголд, 16.0 хувь нь Хятадад, үлдсэн хэсэг нь хаана байгааг мэдэхгүй гэжээ.

Худалдаалагдсан охид, эмэгтэйчүүдийн талаар мэддэг охидын 24.0 хувь нь сүүлийн нэг жилийн хугацаанд 2-5 охид зарагдсан тухай мэддэг бол нэг охин 6 охидыг, гурван охин 9 охидыг зарсныг мэдэж байгаа ажээ. Үлдсэн охидын хувьд энэ талаар мэдэхгүй гэдэг хариултыг өгсөн байна.

Судалгаанд оролцсон нийт охид, эмэгтэйчүүдийн 16.5 хувь нь буюу 15 охид, эмэгтэйчүүд өөрсдөө хүн худалдах гэмт хэрэгт өртөх шахсан тухайгаа ярьж байлаа. Тэдний арван охидыг монгол зуучлагч, гурвыг нь ойр дотны найз нөхөд, хамаатан,



нэг, нэг охидыг гадаадын зуучлагч болон үйлчлүүлэгч нь зарах талаар санал тавьж байсан байна.

Үйлчлүүлэгчдийн зүгээс охид, эмэгтэйчүүд олж өгөх саналыг биеэ үнэлэгчдэд тавьдаг байна. Судалгаанд оролцсон нийт охидын 67.0 хувь нь ийм санал үйлчлүүлэгчээс ирж байсан гэж хариулжээ.

Зочид буудал болон бусад үйлчилгээний газруудад насанд хүрээгүй охид/хөвгүүдийг хүмүүс авч орох тохиолдол ажиглагддаг байна. Биеэ үнэлэгчдийн 60.4 хувь нь ийм тохиолдол ажигласан байна. Тэдний ажигласнаар Монгол (59.3 хувь), Хятад (41.8 хувь), Солонгосчууд (16.5 хувь) олонх нь байдаг гэнэ. Мөн япон, америк, герман, оросуудын хувьд иймэрхүү тохиолдол байдаг ч цөөхөн гэж тэд үзэж байна.

Биеэ үнэлэгчдийн ажигласнаар насанд хүрээгүй хүүхдүүдийг уруу татагч эдгээр хүмүүсийн хувьд 28-43 насны хүмүүс байдаг ажээ. Тэдний бодож байгаагаар насанд хүрээгүй хүүхдүүдийг зочид буудал, бусад газруудаар авч ороод бэлгийн харьцаа (85.5 хувь), наргиж цэнгэн, цагийг хамт өнгөрөөхийг (5.5 хувь) ихэвчлэн санал болгодог гэж үзэж байна.

## **Дүгнэлт**

Санхүүгийн болон гэр бүлийн амьдралын бэрхшээлт байдлаас шалтгаалж сургууль завсардсан, олон хүүхэдтэй, гэр хорооллын өрхийн, эцэг, эх нь салсан эсвэл дахин гэрлэсэн, гэр бүлийнхнээс нь тодорхой хэмжээгээр дарамт шахалт үзүүлдэг, найзуудтайгаа болон ганцаараа амьдардаг, үйлчилгээний салбарт ажилладаг, урьд өмнө нь хэн нэгэнд хүчиндүүлж байсан охид, эмэгтэйчүүдийн дунд биеэ үнэлэх явдал их байна. Ялангуяа 17 ба түүнээс доош насандаа буюу насанд хүрээгүй, бие организм нь бүрэн хөгжиж амжаагүй, бэлгийн бойжилтийн үедээ байхдаа биеэ үнэлж эхлэх явдал багагүй байгааг анхаарах хэрэгтэй байна. Иймд биеэ үнэлэх явдал руу орохоос урьдчилан сэргийлэх, уруу татагдахаас зайлсхийхэд чиглэсэн үйл ажиллагааг энэхүү эрсдэлт бүлгийнхний дунд тогтмол зохион байгуулах шаардлагатай байна.

Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүд эрүүл мэндийн эрсдэлтэй байдалд байна. Тэд эрүүл мэндийн хүндрэл гарсан үедээ эмч, эмнэлэг гэхээсээ илүүтэйгээр өөрөө өөрсдийгөө дур мэдэн эмчлэх нь их, ДОХ/БЗХӨ-ний шинжилгээнд хамрагдах явдал хангалтгүй байна. Ялангуяа 14-15 настай охидын дунд БЗХӨ тусах явдал өндөр, бэлгэвч хэрэглэх явдал бага, өөрөө өөрийгөө дур мэдэн эмчлэх явдал өндөр байгааг анхаарах хэрэгтэй байна.

Насанд хүрээгүй охидуудыг биеэ үнэлэх замд татан оруулагчид бол тэднийг зуучлагчид гэж хэлж болно. Тухайлбал, судалгаанд хамрагдсан насанд хүрээгүй охид бүгдээрээ зуучлагчаар дамжуулж биеэ үнэлэх ажлыг хийж байна. Мөн тэдний биеэ үнэлээд олсон мөнгөний ихэнх хувийг зуучлагчид нь авдаг. Зуучлагчдын зүгээс биеэ үнэлэгчдэд үзүүлэх дарамт, шахалт их, ялангуяа бага насны охидод үнэгүй хоол унд өгөх, байр сууцаар хангах төдийгөөр хууран, өөрийн гарын дор байлгаж, биеийг нь үнэлүүлэх, дарамтлах явдал их байгааг анхаарч, энэхүү үйл ажиллагааг таслан зогсоход чиглэсэн арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай байна.

Гадаадад ажиллах, тэднийг гадаадад ажиллуулах санал тавибал хүлээн авна гэсэн бодолтой биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүд олон байна. Тэдний хувьд ажлын ямар ч санал тавьсан хүлээн зөвшөөрөхөд бэлэн байна. Энэ байдал нь биеэ үнэлэгчдийн хүн худалдах гэмт хэргийн золиос болоход бэлэн байгааг харуулж байгаа юм.

Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүд гадаад, дотооддоо худалдаалагдсан охид, эмэгтэйчүүдийн талаар багагүй мэдээлэлтэй байдаг ажээ. Үүнийгээ тэд эрхэлж буй ажлынхаа онцлог гэж тайлбарлаж байна. Мөн тэднийг хил давуулан худалдах санал тавьсан цөөнгүй тохиолдол байсан талаар ярьж байгаа нь биеэ үнэлэгч охид,



эмэгтэйчүүдийн хувьд хүн худалдах гэмт хэрэгт өртөх магадлал асар өндөр байдгийг илтгэж байгаа юм.

**Ажил олгогчийн асуудлууд**

Тус бүлэгт ажил олгогчдын ерөнхий шинж байдал, ажиллуулж буй үйлчилгээний газруудын шинж байдал, ажиллагчдаа хэрхэн ажилд авдаг, охид, эмэгтэйчүүдийг ажиллуулах давуу, сул талуудын талаар болон эдгээр газруудаар үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдийн талаарх ажил олгогчдын үзэл бодлыг гаргахыг зорилоо.

**6.1 Ажил олгогчдын шинж байдал**

Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын нас 20-60 байсан бөгөөд судалгаанд нийт 180 ажил олгогч хамрагдсан. Тэдний дундаж нас 36, хүйсийн хувьд 63.3 хувь нь эмэгтэйчүүд байв.

Ажил олгогчдын дийлэнх нь буюу 75.6 хувь нь гэрлэсэн/хамт амьдардаг, 16.7 хувь огт гэрлээгүй, 8 орчим хувь нь салсан/тусгаарласан/бэлбэсэн хүмүүс байлаа.

Ажил олгогчдын 71.1 хувь нь дээд, 12.8 хувь нь бүрэн дунд, 9 хувь нь техник мэргэжлийн, мөн 7 орчим хувь нь бүрэн бус дунд боловсролтой байна. Тухайн байгууллагад хашиж буй албан тушаалаар нь авч үзвэл, 1/3 нь захирал, 29.4 хувь менежер, 22.2 хувь зохион байгуулагч, 11.1 хувь эзэн, 4.3 хувь боловсон хүчин, эрхлэгч, нягтлан бодогч ажилтай байлаа.


Ажил олгогчдын өмнө нь ажил эрхэлж байсан эсэх болон давхар ажил хийдэг эсэх талаар асуусан юм. Судалгаанд хамрагдагчдын дийлэнх буюу 76.1 хувь өмнө нь өөр ажил эрхэлж байсан бөгөөд эдгээрээс үйлчилгээний салбарт ажиллаж байсан ажил олгогчдын хувь дөнгөж 7.3 байлаа.

Ажил олгогчдыг өмнө нь эрхэлж байсан ажлын төрлөөр үзэхэд нэлээд олон янз байв. Санхүү, эдийн засгийн мэргэжлийн (16.8 хувь) болон багш, сурган хүмүүжүүлэгчид (15.3 хувь), инженер техникийн ажилчид (13.1 хувь) үйлчилгээний салбарт цөөнгүй орсон нь ажиглагдаж байна.

Ажил олгогчид давхар ажил хийх нь харьцангуй цөөн, тэдний 10.6 хувь л давхар ажил хийдэг бөгөөд дийлэнх хэсэг (36.8 хувь) нь хувийн бизнес хийдэг гэж хариулжээ.

Ажил олгогчдоос тэдний байгууллагын үзүүлж буй үйлчилгээний нэр төрлийг Зураг 6.1-д харууллаа. Байгууллагууд хэд хэдэн нэр төрлийн үйлчилгээ хослуулан эрхлэх нь элбэг бөгөөд нийт үйлчилгээний газруудын 55.5 хувь нь нэгээс дээш нэр төрлийн үйлчилгээ үзүүлдэг гэжээ.

**Зураг 6.1** Үйлчилгээний газруудын хувийн жин, үзүүлж буй үйлчилгээний төрлөөр



Давхардсан тоогоор судалгаанд хамрагдсан байгууллагуудын талаас илүү хувь нь баар, 40 орчим хувь нь зочид буудал ажиллуулдаг бөгөөд ресторан/зоогийн газар, массаж/сауна, шөний клуб ажиллуулдаг байгууллага тус тус 25.6, 22.2 ба 20.6 хувийг эзэлж байна. Үйлчилгээний газруудын дийлэнх нь нээгдээд зөвхөн нэг жил болж байгаа бөгөөд тал хувь нь 3 жилээс бага хугацаанд ажиллаж байна.

Судалгаанд хамрагдсан үйлчилгээний газруудын ажиллагчдын тоог авч үзэхэд 70 хувь нь 15-аас бага тооны ажиллагчидтай, 20.6 хувь нь 15-30 ажиллагчидтай, үлдсэн 9.5 хувь нь 30-с дээш ажиллагчидтай бөгөөд эдгээр 30-аас дээш ажиллагчидтай газрууд бүгд Улаанбаатарт байрладаг ажээ. Үйлчилгээний салбарт ажиллагчдын хувьд ажил олгогч, ажиллагчид аль аль нь ихэнхдээ эмэгтэйчүүд байдаг талаар дээр дурьдаж байсан. Тухайлбал, ажил олгогчдоос эрэгтэй болон эмэгтэй ажиллагчдын харьцааг тодруулахад тэдний тал нь дунджаар эмэгтэйчүүд нийт ажиллагчдын 67-оос дээш хувийг эзэлдэг байна.

Ажил олгогчид ажиллагчдынхаа насыг нэлээд нэмж хэлэх хандлагатай байгаа нь ажиглагдсан. Учир нь үйлчилгээний газар ажиллагчдаас асуусан асуулгад тэнд ажиллаж буй хамгийн залуу хүн 16 настай байхад ажил олгогчид ажиллагчдынхаа хамгийн залуу насыг эрэгтэйчүүдийн хувьд 19, эмэгтэйчүүдийн хувьд 18 байгаа гэж хариулжээ.

## **6.2 Ажиллагчдыг ажилд авах үйл явц, ажиллуулах талаар**

Судалгааны дүнгээс харахад, охид, эмэгтэйчүүд компанийн зарлалын дагуу хандаж ажилд орох нь нэлээд түгээмэл байна. Тухайлбал, нийт 180 ажил олгогчоос 117 нь буюу 65 хувь нь дээрх хариултыг өгчээ. Тэдний 15.6 хувь нь охид, эмэгтэйчүүд өөрсдөө хандаж ирдэг, 8.9 хувь нь найз нөхөд, хамаатан садныхаа зөвлөсний дагуу тэднийг ажилд авдаг байна. Ажиллагчид ажлаа хир их сольдог вэ гэсэн асуултанд ажил олгогчдын дийлэнх нь буюу 63.9 хувь хааяа гэсэн бөгөөд түгээмэл гэж 19.4 хувь, байнга гэж 16.7 хувь хариулсан байв.

Ажил олгогчид ажилд авахдаа ямар шаардлага тавьдаг талаар Зураг 6.2-т харууллаа.

**Зураг 6.2** Ажил олгогчид ажиллагчдыг ажилд авах үедээ тавьдаг шаардлага



Давхардсан дүнгээр судалгаанд хамрагдсан ажил олгогчдын 76.1 хувь нь ажиллагчдыг ажилд авахдаа ажлын өндөр чадвартай байх шаардлагыг тавьдаг. Мөн тогтвортой ажиллах болон нас, хүйс зэргийг мөн чухалчилсан байна.

Ажиллагчидтай гэрээ байгуулдаг эсэхийг авч үзэхэд ажил олгогчдын 83.9 хувь “тийм” гэжээ. Энэ нь үйлчилгээний салбарт ажиллагчдын хариултаас нэлээд ялгаатай байгаа юм. Учир нь өмнөх бүлэг дэх ажиллагчдын хариултаас харахад тэдний 48.9 хувь нь ажил олгогчтойгоо бичгээр гэрээ байгуулсан гэж хариулсан байна.


Ажил олгогчдоос гэрээ байгуулаагүй шалтгааныг нь тодруулахад тэдний 62.1 хувь шаардлагагүй, 20.7 хувь хүмүүс байнга солигдож байдаг, 17.2 хувь нь амжаагүй гэсэн байна.

Ажиллагчдын ажлын цагийн үргэлжлэх хугацааны талаарх асуултад ажил олгогчид болон ажиллагчид нэлээд ялгаатай хариулт өгчээ. Тухайлбал, ажил олгогчдын 23.3 хувь ажиллагчдаа өдөрт дунджаар 8 цаг ажилладаг гэсэн бөгөөд тэдний хариулснаар ажиллагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацаа 12 цаг байна.


Ажил олгогчдын талаас илүү буюу 51.7 хувь нь ажиллагчиддаа 14 хоног тутамд цалин олгодог гэжээ. Сард нэг удаа цалин олгодог гэж хариулсан ажил олгогчдын хувь 34.4, 7 хоног бүр олгодог болон өдөр бүр цалин хөлсийг нь олгодог ажил олгогчид тус тус 5.0, 8.9 хувь байна.

Үйлчилгээний салбарт ажиллагчдын дийлэнх нь охид, эмэгтэйчүүд байна гэж бид өмнө нь дурьдсан. Тэгвэл охид эмэгтэйчүүдийг ажиллуулахад ямар давуу болон сөрөг талууд байдаг талаар Хүснэгт 6.3 а, б-д харуулав.

**Зураг 6.3а** Ажил олгогчдын хувь, үйлчилгээний газар охид эмэгтэйчүүдийг ажиллуулах давуу талаар



**Зураг 6.3б** Ажил олгогчдын хувь, үйлчилгээний газар охид эмэгтэйчүүдийг ажиллуулах сул талаар



Судалгаанд хамрагдсан нийт ажил олгогчдын 48.3 хувь нь охид, эмэгтэйчүүдийг ажиллуулахад ямар нэгэн сул тал байхгүй гэжээ. Ажил олгогчид охид, эмэгтэйчүүдийн чухам ямар чанарыг илүүд үзэж байгааг сонирхвол, тэдний 72.2 хувь охид, эмэгтэйчүүдийг ажиллуулах давуу тал нь нямбай зан чанар гэсэн байна. Түүнчлэн, охид, эмэгтэйчүүдийн хурдан шуурхай (58.3 хувь), дуулгавартай (28.9 хувь), харьцахад хялбар (27.2 хувь) зэрэг давуу талуудыг ажил олгогчид нэрлэжээ. Гэхдээ охид, эмэгтэйчүүдийг ажиллуулахад зарим нэг дутагдалтай тал байх бөгөөд ажил олгогчдын хамгийн их нэрлэсэн дутагдал нь туршлагагүй байдал (26.7 хувь) гэжээ. Мөн тэдний 15 хувь нь охид эмэгтэйчүүдийг үнэнч бус байдаг гэж үзэж байна.

### 6.3 Ажил олгогчид үйлчлүүлэгчдийн талаар

Ажил олгогчдоос тэдний үйлчилгээний газраар өдөрт үйлчлүүлдэг үйлчлүүлэгчдийн тоо, байнгын болон гадаад үйлчлүүлэгчдийн хувийн жин, үйлчлүүлэгчдийн нас, үндэс, үйлчлүүлэгчдийн зүгээс ажиллагчдад ямар нэгэн санал тавьдаг эсэх талаар сонирхсон юм.

Ажил олгогчдын хариултаас харахад 50 хувь нь өдөрт 30 хүртэл хүнд үйлчилдэг гэсэн бөгөөд өдөрт үйлчилдэг үйлчлүүлэгчдийн дунджийг тооцоход 42.4 байна. Үйлчлүүлэгчдийн дундаж нас 35 байсан бөгөөд үйлчлүүлэгчид дунджаар 20 орчим хувь нь байнгын байдаг гэжээ. Ажил олгогчдын 73.3 хувь тухайн үйлчилгээний газраар гадаад үйлчлүүлэгчид үйлчлүүлдэг гэсэн бөгөөд тэд дунджаар нийт үйлчлүүлэгчдийн 16 орчим хувийг эзэлдэг дүн гарчээ.

Үйлчлүүлж буй хүмүүс ямар үндэстэн болохыг тодруулахад гадаадын үйлчлүүлэгчдээс хамгийн өндөр хувийг Хятад үйлчлүүлэгчид эзэлж байна. Тухайлбал, ажил олгогч нарын 61, ажиллагчдын 50 хувь үйлчлүүлэгчид нь “Хятад” гэж хариулсан байв. Түүнчлэн Солонгос, Орос, Америк хүмүүс цөөнгүй үйлчлүүлдэг нь харагдаж байна.

Ажил олгогчдоос үйлчилгээний ажиллагчдад үйлчлүүлэгчид ямар нэгэн санал тавьдаг эсэхийг тодруулсан бөгөөд тэн хагас нь үйлчлүүлэгчид үйлчилгээний газрын ажиллагчдад ямар нэгэн санал огт тавьдаггүй гэжээ. Гэхдээ болзох (23.3 хувь), найзлах (22.2 хувь), бэлэн мөнгө өгөх (14.4 хувь), биеэ үнэлэх (11.7 хувь) зэргийг санал болгох тохиолдол мөн байдаг гэж үзэж байгаа ажил олгогчид ч байв.

## **Дүгнэлт**

Ажил олгогчид ажиллагчдаа голдуу зарын дагуу ажилд авч байгаа ба охид, эмэгтэйчүүдийг илүү ажиллуулах сонирхолтой байдаг байна. Тэдний тал нь дунджаар эмэгтэйчүүд нийт ажиллагчдын 67-оос дээш хувийг эзэлдэг гэсэн байна. Тэд охид, эмэгтэйчүүдийг ажиллуулах давуу тал нь нямбай зан чанар (72.2 хувь) гэсэн байна. Түүнчлэн, охид, эмэгтэйчүүдийн хурдан шуурхай (58.3 хувь), дуулгавартай (28.9 хувь), харьцахад хялбар (27.2 хувь) зэрэг давуу талуудыг мөн нэрлэжээ.

Ажил олгогчдын 83.9 хувь нь ажиллагчидтай гэрээ байгуулдаг гэжээ. Энэ нь үйлчилгээний салбарт ажиллагчдын хариултаас нэлээд ялгаатай байгаа юм. Учир нь ажиллагчдын 48.9 хувь л ажил олгогчтойгоо бичгээр гэрээ байгуулсан гэж хариулсан байна. Ажил олгогчдоос гэрээ байгуулаагүй шалтгааныг нь тодруулахад тэдний 62.1 хувь шаардлагагүй, 20.7 хувь хүмүүс байнга солигдож байдаг, 17.2 хувь нь амжаагүй гэсэн байна.

Ажиллагчдын ажлын цагийн үргэлжлэх хугацааны талаар ажил олгогчид болон ажиллагчид ялгаатай хариулт өгсөн. Тухайлбал, ажил олгогчдын 23.3 хувь ажиллагчдаа өдөрт дунджаар 8 цаг ажилладаг гэсэн байхад үйлчилгээний газрын ажиллагчид өөрсдөө өдөрт дунджаар 13 цаг ажилладаг гэж хариулж байгаагаас харахад цагийн зөрүүтэй байдал ажиглагдаж, чухам хэн нь үнэн хэлж буй нь тодорхой бус байгаа юм.

**Дүгнэлт, зөвлөмж**

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага-Хүүхдийн Хөдөлмөрийг Устгах (АЙПЕК) олон улсын хөтөлбөрийн нэг бүрэлдэхүүн хэсэг нь хүүхдийн хөдөлмөрийн талаарх олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх, хүүхдийг биеэ үнэлэх явдлаас урьдчилан сэргийлэх явдал юм. Охид эмэгтэйчүүд, хүүхдүүд бэлгийн мөлжлөг болон хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж байгаа эсэхийг тодруулах зорилготой энэхүү судалгааг Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (АЙПЕК)-ын санхүүжилтээр Хүйсийн Тэгш Эрхийн Төв, МУИС-ийн Хүн амын сургалт судалгааны төвийн судлаачид хамтран хийж гүйцэтгэлээ.

Судалгаанд 25-с доош насны биеэ үнэлэгч охид мөн үйлчилгээний газар ажиллагчид, тэдний ажил олгогчид хамрагдсан бөгөөд судалгаанаас дараах дүгнэлт гарлаа.

- Судалгаанд хамрагдсан биеэ үнэлэгчдийн ерөнхий шинж байдлаас харахад 15-21 насны, санхүүгийн болон гэр бүлийн амьдралын бэрхшээлт байдлаас шалтгаалж сургууль завсардсан, олон хүүхэдтэй өрхийн, эцэг, эх нь салсан эсвэл дахин гэрлэсэн, гэр бүлийнхнээс нь тодорхой хэмжээгээр дарамт шахалт үзүүлдэг, найзуудтайгаа болон ганцаараа амьдардаг, урьд өмнө нь хэн нэгэнд хүчиндүүлж байсан охид, эмэгтэйчүүд дийлэнх хувийг эзэлж байна.
- Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүд эрүүл мэндийн эрсдэлтэй байдалд байна. Тэд эрүүл мэндийн хүндрэл гарсан үедээ эмч, эмнэлэг гэхээсээ илүүтэйгээр өөрөө өөрсдийгөө дур мэдэн эмчлэх нь их, ДОХ/БЗХӨ-ний шинжилгээнд хамрагдах явдал хангалтгүй байна.
- Гадаадад ажиллах, тэднийг гадаадад ажиллуулах санал тавибал хүлээн авна гэсэн бодолтой биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүд олон байна. Тэдний хувьд ажлын ямар ч санал тавьсан хүлээн зөвшөөрөхөд бэлэн байна. Энэ байдал нь биеэ үнэлэгчдийн хүн худалдах гэмт хэргийн золиос болоход бэлэн байгааг харуулж байгаа хэрэг юм.
- Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүд гадаад, дотооддоо худалдаалагдсан охид, эмэгтэйчүүдийн талаар багагүй мэдээлэлтэй байдаг ажээ. Үүнийгээ тэд эрхэлж буй ажлынхаа онцлог гэж тайлбарлаж байна. Мөн тэднийг хил давуулан худалдах санал тавьсан хэд хэдэн тохиолдол байсан талаар ярьж байгаа нь биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүдийн хувьд хүн худалдах гэмт хэрэгт өртөх магадлал асар өндөр байдгийг илтгэж байгаа юм.
- Үйлчилгээний газар ажиллагчдын дийлэнх нь залуу насны эмэгтэйчүүд байдаг байна. Тэдний дийлэнх нь шилжин ирсэн, ерөнхий боловсролын болон их дээд сургуулийн аль нэг ангиас завсардсан, эсвэл төгсөөд ажил олдохгүйн улмаас энэ салбарт ажиллаж байгаа хүмүүс байна.

- Тэдний ажлын нөхцөл хүнд буюу ажлын өдөр нэлээд урт хугацаанд үргэлжилж, шөнийн цагаар ажиллах тохиолдол элбэг бөгөөд авч буй цалин харьцангуй бага байна.
- Тухайн салбарт ажиллаж буй дундаж хугацаа 2 жил байгаа бөгөөд тэдний талаас бага хувь нь буюу 45 хувь нь ажил олгогчтойгоо бичгээр, 14.5 хувь нь амаар гэрээ хийсэн ба үлдсэн 40.5 хувь нь ямар нэгэн гэрээгүй ажиллаж байна.
- Үйлчилгээний салбарт ажиллагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацаа 12 цаг байгаа нь тухайн салбарт ажиллагчдын ажлын цаг харьцангуй урт байгааг харуулж байна.
- Тухайн салбарт ажиллахад хамгийн бэрхшээлтэй зүйл нь үйлчлүүлэгчдийн харьцаа байдаг бөгөөд үйлчлүүлэгчид тэднийг хэл амаар доромжлох нь хамгийн элбэг тохиолддог байна.
- Судалгаанд хамрагдагчдын 66.9 хувь нь гадаадад ажиллах сонирхолтой гэжээ. Үйлчилгээний газар ажиллагчид өөрсдийгээ хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэл багатай гэж үзэж байсан хэдий ч хэн нэгэн хүн гадаадад үйлчилгээний газар ажиллах санал тавьбал тэдний 60.7 хувь хүлээж авна, талаас илүү (50.3 хувь) хувь нь ямар ч хамаагүй ажлыг хийнэ гэснээс харахад үйлчилгээний газар ажиллагчид хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж болзошгүйг харуулж байгаа юм.
- Судалгаанд хамрагдсан үйлчилгээний газар ажиллагчдын 1/3-д үйлчлүүлэгчдийн зүгээс секс үйлчилгээ үзүүлээч гэсэн санал тавьж байсан байна. Харин бэлгийн харьцаанд орохыг хүлээн зөвшөөрч буй гол шалтгаан нь эдийн засгийн сонирхол гэж хариулсан хариулагчдын хувь хамгийн өндөр байлаа. Энэ нь үйлчилгээний газар ажиллагчид бэлгийн мөлжлөгт өртөх магадлал өндөртэйг харуулж байна.
- Үйлчилгээний салбарт ажиллагчдын нэлээд хэсэг нь хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн охид, эмэгтэйчүүдийн талаар мэддэг гэжээ. Үйлчлүүлэгчид тэдэнд охид, эмэгтэйчүүдийг олж өгөх санал цөөнгүй тавьдаг нь хүн худалдах гэмт хэргийг анхаарах цаг болсон нь тодорхой байна.

### **Зөвлөмж**

- Охид, эмэгтэйчүүдийн хувьд 18 ба түүнээс доош насандаа буюу насанд хүрээгүй, бие организм нь бүрэн хөгжиж амжаагүй, бэлгийн бойжилтийн үедээ байхдаа биеэ үнэлж эхлэх явдал багагүй байгааг анхаарах хэрэгтэй байна. Ийм учраас биеэ үнэлэх явдал руу орохоос урьдчилан сэргийлэх, уруу татагдахаас зайлсхийхэд чиглэсэн үйл ажиллагааг энэхүү эрсдэлт бүлгийнхний дунд тогтмол зохион байгуулах шаардлагатай байна.
- Биеэ үнэлэгч охид, эмэгтэйчүүд эрүүл мэндийн эрсдэлтэй байдалд байгааг анхаарч, тэднийг ДОХ/БЗХӨ-ний шинжилгээнд тогтмол хамруулах, энэхүү өвчнөөс урьдчилан сэргийлэх болон хамгаалах бүх



талын сургалт, сурталчилгааны үйл ажиллагаанд биеэ үнэлэгчдийг байнга хамруулж байх;

- Охид, эмэгтэйчүүдийг, ялангуяа насанд хүрээгүй охидыг биеэ үнэлэх ажилд татан оруулж байгаа зуучлагч этгээдүүдийн үйл ажиллагааг таслан зогсоох. Үүний тулд цагдаагийн болон холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг улам чангатгах, биеэ үнэлэгчдийг энэхүү үйл ажиллагаанд татан оролцуулах;
- Биеэ үнэлэгчдэд болон биеэ үнэлэх эрсдэлд байгаа охид, эмэгтэйчүүдэд биеэ үнэлэхийн сөрөг үр дагавар, цаашилбал, хүн дамлан худалдаалах гэмт хэргийн гол золиос болох эрсдэл өндөр байгааг ойлгуулахад чиглэгдсэн бүх талын арга хэмжээг зохион байгуулах;
- Үйлчилгээний салбарт ажиллагчдын бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх магадлал нь тэдний эдийн засаг, санхүүгийн эмзэг байдалтай холбоотой байна. Үйлчилгээний газар ажиллагчид ихэвчлэн сургуульд суралцаж буй залуучууд, сургууль төгссөн боловч мэргэжлээрээ ажиллаж чадахгүй өөрөөр хэлбэл, цалин багатай ч хамгийн элбэг олдож буй үйлчилгээний газар ажиллахаас өөр аргагүйд хүрээд байгааг анхаарч суралцахын зэрэгцээ ажил эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, түүнчлэн хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэхэд анхаарах;
- Үйлчилгээний газар ажиллагчдын ажлын нөхцөл хүнд буюу ажлын өдөр нэлээд урт хугацаанд үргэлжилж, шөнийн цагаар ажиллах тохиолдол элбэг байгаа нь баар цэнгээний газрын ажиллах цагийн тухай журам зөрчигдөж байна. Иймд шөнийн цагаар ажиллаж буй үйлчилгээний газруудад хяналт тавих;
- Биеэ үнэлэгчид болон үйлчилгээний газар ажиллагчдад гадаадад үйлчилгээний салбарт ажиллах саналыг үйлчлүүлэгчид тавьдаг нөгөө талаас, тэд өөрсдөө ийм саналыг хүлээн авч ямар ч хамаагүй ажил хийхэд бэлэн байгаа нь тэд бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй байгааг харуулж байна. Иймд тэднийг эрсдэлд өртүүлэхгүйн тулд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;